

**Орон нутгийн ардчиллын
төлөв байдал:
Үнэлгээний аргачлал**



Орон нутгийн ардчиллын төлөв байдал: Үнэлгээний аргачлал

Брехте Кэмп, Мелида Жименез

Энэхүү гарын авлагад орсон мэдээлэл нь хөгжлийн үнэлгээг салбар бүрээр нарийвчлан судалдаг АСДҮ Олон улсын хүрээлэнгийн Ардчиллын судалгааны багийн мэргэжлийн хамт олны хамтын судалгаа, ажлын үр дүнд бий болсон юм. Тиймээс гарын авлагыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн Хэлен Бьюрэмалм, Женни Хэдсрум, Нана Каландадзе, Кэбойце Мачангана, Сара Полек, Абдурашид Солижонов, Сэм Вандэр Стак, Каталина Юрибэ, Бурчер, Иорг Валладарес, Лотта Вэстэрбэргт гүн талархал илэрхийлье.



Улс төрийн нам, оролцоо, төлөөлөл

© 2016 Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн

© 2013 оны Англи хувилбар

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэнгээс гаргаж буй ном хэвлэл тодорхой нэг улс үндэсний болон улс төрийн ашиг сонирхлоос ангид байдаг. Энэ номд илэрхийлсэн үзэл бодол АСДҮОУХ, түүний Удирдах зөвлөл болон Зөвлөлийн гишүүдийн үзэл бодлыг заавал төлөөлөх албагүй.

АСДҮ Олон улсын хүрээлэн

Стромсборг, SE-103 34 Стокгольм, Швед

Утас: +46 8 698 3700, факс: +46 8 20 2422

Цахим хаяг: info@idea.int, цахим хуудас: www.idea.int

Энэ хэвлэлийн цахим хувилбарыг Creative Commons лицензийн (CC) буюу Creative Commons Attribute-NonCommercial-ShareAlike 3.0 лицензийн дагуу авах боломжтой. Та ижил төстэй лицензийн дагуу тус хэвлэлийн зохиогчийг дурдаж, түгээх нөхцөлд зөвхөн арилжааны бус зорилгоор хуулбарлаж, түгээж, дамжуулж, мөн найруулан товчилж болно. CC лицензийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах бол <http://creativecommons.org/licenses/by-nc-sa/3.0/> вэбсайтыг үзнэ үү.

Энэ нь АСДҮОУХ-ийн 2013 оны “Орон нутгийн ардчиллын төлөв байдал: Үнэлгээний аргачлал” англи хэл дээрх хэвлэлийн орчуулга. Орчуулгын үнэн зөвийг АСДҮОУХ шалгаж баталгаажуулаагүй. Эргэлзээ төрсөн үед англи хэл дээрх эх давуу хүчинтэй. (ISBN 978-91-87729-08-9)

Орчуулсан Ч.Цэрэннадмид

Орчуулгыг хянан тохиолдуулсан Ц.Цэцэнбилэг

График дизайныг Сантангело Дисено

Хавтасны дизайныг Сантангело Дисено

Хавтасны зургийг © Алберто Ругиери/Зургийн ажил/Корбис/ТТ

Медиабиран

Хэвлэлийн компани "Адмон принт" ХХК

ISBN 978-91-7671-082-1

ӨМНӨХ ҮГ

Ардчилсан институцын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тогтмол сайжруулахад иргэдийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтойгоос гадна тэр нь ардчилсан нийгмийн амин сүнс болж байдаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон оронд иргэдийн санаачилсан хөдөлгөөн өрнөснийг бид мэднэ. Эдгээрийн дийлэнх нь ардчиллыг эсэргүүцсэн бус харин илүү их, чанарлаг ардчиллыг шаардсан хөдөлгөөн байсан юм.

Иргэдийн зүгээс тавьж буй шаардлага улс орон бүрт харилцан адилгүй байсан хэдий ч ихэнх тохиолдолд улс төрийн төлөөллийн байгууллагуудын эгэх хариуцлага, хариу үйлдэл шуурхай үзүүлэх чадавх сул байгаа гэсэн шүүмжлэл давамгайлж байна. Тэр дундаа иргэдийг төлөөлөн сонгогдсон этгээд зөвхөн сонгуулийн кампанит ажлын үеэр санал авах зорилгоор олон нийтэд үзэгддэг гэж шүүмжилдэг байна. Үүний нэгэн адил сонгууль явуулах практик, сонгуулийн шударга байдалтай холбоотой олон чухал асуудал урган гардаг бөгөөд үүнд төрийн өмч хөрөнгийг зүй бусаар ашиглах, завших, кампанит ажлын явцад хэт их хэмжээний зардал гаргах, элитүүд давамгайлах зэрэг үйл явдлыг нэрлэж болно. Энэ байдал нь улс төрийн намуудын гишүүдийн тоо буурах, нийгмийн платформ дахь улс төрийн намуудын үүрэг оролцоо сул болсноор улам даамжран гүнзгийрдэг. Мөн түүнчлэн, ардчилсан институц хийгээд ардчилсан үйл явц дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төлөөлөл тэгш бус байх нь ардчиллын хөгжлийг сааруулж, сорилт бэрхшээлийг дагуулдаг.

Тиймээс ардчиллын тогтвортой байдлыг хангах нь иргэдийн дуу хоолойг сонсож, тэдний хэрэгцээ шаардлагад хэр мэдрэмжтэй хандахаас ихэд хамаарах болжээ. Ардчиллыг цогцлоож, нийгмийн өөрчлөлт хийхэд ардчиллын талаарх ойлголт, хэтийн санаа, төсөөлөл, хүсэл эрмэлзлийг нарийн ойлгох, тусгахад институцжсэн механизм зайлшгүй шаардагдаж байна. Иргэдийн санаачилгад суурилсан үнэлгээ энэхүү механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлж чадна.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн нь 2000 оноос хойш дэлхийн олон оронд ардчиллын үнэлгээ, тэр дундаа иргэдийн санаачилгад түшиглэсэн ардчиллын үнэлгээг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлсээр ирсэн юм. Энэ хугацаанд

Ардчиллын төлөв байдлын үнэлгээг нийт 23 улсад, Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээг 60 гаруй удаа хийж, Үйлчилгээ хүргэх ардчилсан хариуцлага сэдвээр дөрвөн улсад туршилтын үнэлгээ хийж гүйцэтгээд байна.

Орон нутгийн түвшинд үнэлгээ хийснээр ардчиллын төлөв байдалд тогтмол хяналт тавих, ололт амжилтыг дүгнэх, алдаа дутагдал гарвал шийдвэрлэж, шаардлагатай шинэчлэлийг эхлүүлэх тал дээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг иргэдэд олгодог. Энэ төрлийн үнэлгээ нь иргэдийн дуу хоолойг сонсох, орон нутгийн болон үндэсний түвшинд ардчиллын институцууд иргэдийн дуу хоолой, эрэлт хэрэгцээ, хүсэл эрмэлзэлд нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвар, чадавхыг бэхжүүлэхэд мөн чухал ач холбогдолтой.

Орон нутаг бол иргэдийн улс төрд оролцох, өөрийн төлөөллөө сонгох хамгийн анхан шат юм. Иргэдийн ардчиллын үнэт зүйл, соёлын талаарх үзэл бодол анх энд бий болдог бөгөөд улс төрийн сонголтын нь үр дүн, төрийн шийдвэрийн нөлөө бодит амьдралд өдөр тутам хэрхэн тусаж буйг эндээс хардаг. Ардчиллын чанар аливаа улсын засаг захиргааны нэгж, орон нутаг бүрт ижил түвшинд байдаггүйг энд тэмдэглэх нь зүйтэй, учир нь хуримтлуулсан туршлага, практик нөхцөл байдлаас шалтгаалан ардчиллын ойлголт, үйл ажиллагааны чанар аймаг, орон нутагт харилцан адилгүй байдаг билээ. Орон нутгийн түвшин дэх ардчиллын өвөрмөц байдал, онцлог шинжийг тодорхойлох, үнэлгээ хийх чадавхтай байх нь зөвхөн орон нутгийн түвшинд ардчилсан үйл явцыг гүнзгийрүүлэхэд чиглэх бус цаашлаад үндэсний түвшинд ардчилсан үйл явцыг өргөжүүлэх, гүнзгийрүүлэн хөгжүүлэх стратегийг боловсруулахад чухал шаардлагатай мэдлэг, мэдээлэл болдог. Ихэнх тохиолдолд иргэдийн хүсэл зорилго, тэмүүллийн норматив хэмжээ хийгээд бодит байдал дээрх дүр зураг хооронд илэрхий зөрүү байдаг. Орон нутаг дахь ардчилалд өгөх иргэдийн үнэлгээ энэхүү зөрүүг арилгахад чухал ач холбогдолтой.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн

Агуулга

	Өмнөх үг	5
	Товчилсон үгийн жагсаалт	9
	Гарын авлагын тухай товч	10
Бүлэг 1	ОНАТБ Үнэлгээний аргачлалын ерөнхий танилцуулга	12
	1.1. Орон нутгийн ардчилал	13
	1.2. Ардчиллыг үнэлэх иргэдэд түшиглэсэн арга	14
	1.3. Нийтлэг аргачлалыг орон нутгийн түвшинд ашиглах	15
Бүлэг 2	ОНАТБ Үнэлгээний аргачлал	20
	2.1. Ардчиллын зарчим, үнэт зүйлс	23
	2.2. Орон нутгийн түвшинд хийх нөхцөл байдлын шинжилгээ	26
	Чиглүүлэх асуултууд	29
	2.3. ОНАТБ Үнэлгээний тулгуур	31
	Тулгуур 1: Иргэний харьяалал, тэгш эрх, шударга ёс	32
	Тулгуур 2: Төлөөлөл бүхий, эгэх хариуцлагатай үйл явц, институт	35
	Тулгуур 3: Иргэдийн санаачилга, оролцоо	39
	2.4. Салбар хоорондын асуудал	43
	Хүйсийн тэгш байдал	43
	Нийгмийн нягтрал, ялгаатай байдал	44
	Зөрчил, аюулгүй байдал	46
	Ардчилал ба хөгжил	47
Бүлэг 3	Үнэлгээг хэрхэн гүйцэтгэх тухай	50
	3.1. Бэлтгэл хангах, хугацаагаа сонгох, түншлэл бий болгох	53
	ОНАТБ үнэлгээний аргачлалын ашиг тус	53
	Бенчмарк тогтоох	53
	Үнэлгээний хугацаа	53
	Түншлэлийн замаар шинэчлэгчдийг татан оролцуулах	55
	Шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх	55
	3.2. Үнэлгээ хийх байгууллага	56
	Үнэлгээ хийх үндсэн баг: ОНАТБ үнэлгээний хөдөлгөгч хүч	57
	Зөвлөх баг: шинэчлэлийн төлөөх түншлэл бий болгох	59

3.3.	Үнэлгээний загвар, ажлын төлөвлөгөө	60
	Асуулгын хуудсыг шинэчлэн боловсруулах	62
	Ажлын төлөвлөгөө гаргах, төсөв, хугацааг тодорхойлох	63
	Олон нийтэд танилцуулах	68
3.4.	Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	68
	Мэдээлэл цуглуулах арга техникийг сонгох	68
	Мэдээллийг тайлбарлах, дүн шинжилгээ хийх, дэлгэрүүлж бичих	71
3.5.	Тайлан бичих, зөвлөмж боловсруулах	72
	Тайлангийн төсөл бичих	72
	Зөвлөмж боловсруулах	73
	Богино, дунд, урт хугацааны шийдлүүдийг тодорхойлох	74
3.6.	Үр дүнг баталгаажуулах семинар ба тайлан эцэслэх	75
	Үр дүн баталгаажуулах семинарыг зохион байгуулах	76
	Үнэлгээний тайланг эцэслэх	76
3.7.	Хэвлэн нийтлэх, түгээх, шинэчлэлийн төлөөх ухуулга, сурталчилгааны ажил	76
	Хэвлэгдэн гарах бүтээлийн форматыг сонгох	77
	Мэдээлэл түгээх болон сурталчилгааны стратегийг хэрэгжүүлэх	77
3.8.	Үнэлгээ ба дараагийн алхмууд	79
	Дахин харах, нягтлах, үнэлгээгээ дүгнэх	80
	Орон нутгийн үзүүлэлт боловсруулах, ОнАТБ-г институтчилэх	80

Бүлэг 4

ОнАТБ Үнэлгээний аргачлал ба асуултууд	82
Тайлбар зүүлт	95
Талархал	100
АСДҮ Олон улсын хүрээлэнгийн тухай товчхон	102

Товчилсон үгийн жагсаалт

ММАБ	Мусульман Минданаогийн автономит бүс
МХТ	Мэдээлэл, холбооны технологи
НЗЭ	Нутаг заагдсан этгээд
НУОУХ	Нутгийн удирдлагын олон улсын холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
АТБ	Ардчиллын төлөв байдал (үнэлгээний аргачлал)
ОнАТБ	Орон нутгийн ардчиллын төлөв байдал (үнэлгээний аргачлал)

Гарын авлагын тухай товч

Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээний аргачлалыг (ОнАТБ) АСДҮ Олон улсын хүрээлэн иргэдэд түшиглэсэн орон нутгийн ардчиллын үйл явцыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс боловсруулсан юм. Энэхүү үнэлгээний аргачлал нь иргэдийг үнэлгээний үйл явцын гол цөм болгож, орон нутгийн иргэдээс гарах бодлогын санаачилга, боловсруулсан өөрчлөлт шинэчлэлтийн хөтөлбөрийг дэмжих зорилготой бөгөөд ингэснээр орон нутгийн ардчиллын төлөв байдлыг илүү нарийн нягт үнэлэх боломж бүрддэг байна.

АСДҮ Олон улсын хүрээлэн “*Орон нутаг дахь ардчилал*” гарын авлага¹-ыг боловсруулсны дараа, орон нутгийн ардчиллын төлөв байдлын (ОнАТБ) үнэлгээний анхны аргачлалыг “*Орон нутгийн ардчиллын төлөөх манлайлал: Орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх гарын авлага*” нэртэй 2002 онд хэвлүүлсэн юм. ОнАТБ нь үндэсний хэмжээнд ардчиллын чанарыг үнэлэх зориулалттай Ардчиллын төлөв байдлыг үнэлэх аргачлалын (АТБ)² нэмэлт болгон боловсруулсан юм.

ОнАТБ-ын анхны хувилбар болох 2002 онд хэвлэгдсэн “*Орон нутгийн ардчиллын төлөөх манлайлал: Орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх гарын авлага*”³ нь төлөөллийн болон иргэдийн оролцоог хангах үүрэг бүхий ардчиллын институцын төлөв байдал, орон нутгийн түвшин дэх ардчиллын үйл явцыг үнэлэхэд тусгайлан анхаарсан. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд энэхүү аргачлалыг ашиглан 11 орны 60 гаруй нутгийн удирдлагын байгууллагад үнэлгээ хийжээ. Эдгээр үнэлгээг хийсэн туршлага нь өөр хоорондоо ялгаатай нөхцөл байдалд үнэлгээний аргачлалыг хэрэглэсэн байдлаас сургамж авч, ардчиллын чанарыг үнэлэх илүү зохистой аргачлалыг цаашид эрэлхийлэх боломжийг олгосон юм.

Дээрх туршлагаас харахад үнэлгээний багийг дараах чиглэлээр сайжруулсан удирдамжаар хангах шаардлагатай нь тодорхой болсон. Тухайлбал:

- Ойлголт, үзэл баримтлалын хүрээ тодорхой байх;
- Орон нутгийн ардчиллыг төлөөлөл, оролцооноос илүү өргөн хүрээнд үнэлэх;
- Үнэлгээний аргачлалыг хот, хөдөөд нэгэн адил ашиглаж болохуйц нийтлэг шинж чанартай байх;
- Асуулгын хуудсыг шинэчлэн оруулах;
- Жендер, ялгаатай байдал, зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдлын асуудлуудад илүү анхаарал хандуулах.

Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээний аргачлалын шинэчилсэн хувилбарыг боловсруулахдаа урьд өмнө үнэлгээ хийсэн туршлагатай ажилтнуудын санал, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн зохих өөрчлөлтүүдийг тусган, илүү боловсронгуй болгов.

Аргачлалын энэхүү шинэ хувилбарыг дараагийн хэдэн жилийн турш үнэлгээ хийхэд туршин ашиглах бөгөөд тодорхой хугацааны дараа дахин сайжруулж, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ. Ардчилсан үйл явцын нэгэн адил энэ гарын авлага нь байнга шинэчлэгдэн өөрчлөгдөж байх учиртай.

Уг гарын авлага дөрвөн бүлгээс бүрдэнэ. 1-р бүлэгт ОнАТБ-ын үнэлгээний аргачлалын ерөнхий танилцуулга багтсан. Харин 2-р бүлэгт ОнАТБ-ын үнэлгээний аргачлалыг илүү дэлгэрэнгүй танилцуулсан бол 3-р бүлэгт үнэлгээг зохион байгуулах үйл явц, шат дарааллын талаар өгүүлэв. 4-р бүлэгт асуулгын хуудас боловсруулах гэх мэт үнэлгээний аргачлалтай холбоотой илүү нарийвчилсан мэдээллийг оруулав.

Бүлэг 1

**ОнАТБ үнэлгээний
аргачлалын ерөнхий
танилцуулга**

ОнАТБ үнэлгээний аргачлалын ерөнхий танилцуулга

Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээний аргачлал (ОнАТБ) нь орон нутаг дахь ардчиллын чанарыг хэмжих зорилготой юм. Үнэлгээний аргачлалыг ашигласнаар орон нутгийн засаг захиргааны албан хаагчид, улс төрийн намуудын тухайн нутаг дэвсгэр дэх төлөөлөл, иргэний хөдөлгөөний идэвхтэн, манлайлагчид, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд болон хэвлэл мэдээллийнхэн зэрэг нийгмийн харилцааны үндсэн тоглогчид өөрсдөө нутаг орныхоо ардчилсан институцын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, улмаар ардчиллын давуу болон сул талуудыг тодорхойлж, эдгээр давуу болон сул талыг орон нутгийн түвшинд хийх шинэчлэл, хөгжлийн бодлоготойгоо уялдуулах боломж бүрддэг.

1.1. Орон нутгийн ардчилал

Ардчилал нь хүн төрөлхтний нийтлэг хүсэл тэмүүллийг илэрхийлдэг боловч улс орон бүрт ардчилсан нийгмийн байгуулал харилцан адилгүй байдаг. Үүнээс гадна ардчилал бол засаг төр нь ард түмний хяналтад байж, энэхүү хяналтыг хэрэгжүүлэхэд иргэд адил тэгш боломжоор хангагдаж байдаг засаглалын тогтолцооны нэг хэлбэр мөн. Иргэдийн сонголтыг дээдлэх, улс төрийн эрх тэгш байдлыг бий болгох гэсэн үндсэн зарчмуудаас гадна хамгийн нэн тэргүүнд шаардлагатай сонголт хийх, ардчиллын чанарыг хамгийн бодитоор хэмжих, үнэлж чадах субъект бол иргэд өөрсдөө юм. Тиймээс ардчилсан өөрчлөлтийг нутаг орондоо жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадах манлайлах хүчин бол иргэд өөрсдөө байдаг бөгөөд энэхүү өөрчлөлтийн эхлэх цэг нь үндэсний болон орон нутгийн түвшинд гэсэн хоёр шатлалтай.⁴

Өнөөдрийн даяаршсан нийгэмд орон нутаг дахь ардчиллын чанарыг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх явдалд онцгой анхаарал хандуулах болжээ. Орон нутаг бол иргэдийн ардчиллын талаарх мэдлэг, туршлага олж авах хамгийн ойрын бөгөөд анхан шатны нэгж байдаг. Иргэд аюулгүй, найдвартай орчинд амьдрах, байр орон сууцаар хангуулах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, гэр бүлийн гишүүд хийгээд орон нутгийн иргэдийг анхааран халамжлах зэрэг асуудлаар орон нутгийн төлөөллийн

удирдах байгууллагатай нийгмийн харилцаанд орж байдаг. Эндээс л иргэдийн дийлэнх нь улс орныхоо улс төрийн тогтолцооны талаар ерөнхий ойлголт авдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ч мөн адил улс төрд оролцох, төлөөлөх, төлөөлүүлэх эрхээ эдлэх эхлэлийн цэг нь орон нутгийн ардчилсан институц байдаг.

Хэдий тийм ч ардчилсан үйл явц ихэнх тохиолдолд эмэгтэй, эрэгтэй хүмүүс хоорондын эрх мэдэл, хүчний харилцааг өөрчилдөг гэхэд хэтрүүлэг болохгүй. Харин ардчилсан үйл явц, институцын хөгжил, тогтвортой байдлыг бий болгохын тулд эрх мэдлийн тэгш хуваарилалтыг дэмждэг нь зарчмын асуудал. Нийгмийн бүлгүүдийн өвөрмөц, ялгаатай шинж байдлын алийг нь онцгойлон анхаарч, ардчилсан байдлаар шийдвэрлэж байгаа нь тухайн ардчиллын чанар, төлөв байдал ямар байгааг илэрхийлэх сайн үзүүлэлт болдог. Тухайлбал, ялгаварлан гадуурхалтыг зогсоож, адил тэгш боломжоор хангах явдал ихэнх тохиолдолд орон нутгийн түвшинд яригдаад шийдэгдэлгүй үлддэг. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн түвшинд нийтийг хамруулсан яриа, хэлэлцүүлэг өрнүүлж, тогтмолжуулах шаардлагатай.

Ардчиллын олон хэлбэр байж болох бөгөөд тэдгээр нь байнга хувьсан өөрчлөгдөж, хөгжиж байдаг. Бүгдэд тохирсон, ардчиллын нийтлэг хэлбэр гэж байхгүй бөгөөд ардчиллын чанарыг сайжруулахад эцэс төгсгөл гэж үгүй, байнга сайжирч боловсонгуй болох ёстой.⁵ Харин ардчиллын үнэт зүйлс, зарчим нь ардчилсан нийгэм, тогтолцооны үндэс суурийг бүрдүүлдэг. Энэхүү үнэт зүйлс болон суурь зарчмууд нь ардчилсан эрх, институц болон үйл явцын хэлбэр агуулгыг тодорхойлж байдаг. Эдгээрийг ашиглан амьдрал дээр нөхцөл байдал ямар байгааг үнэлж, дүн шинжилгээ хийж болох юм.

Орон нутгийн түвшинд үйл ажиллагаа нь жигдэрсэн ардчилсан институц ажиллаж, ардчилсан үйл явц өрнөж байх нь иргэдийн идэвх оролцоотой адил ач холбогдолтой бөгөөд үндэсний хэмжээнд илүү хүчирхэг, тогтвортой ардчиллыг хөгжүүлэх суурийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үндэсний хэмжээний бодлого, улс төрийн шийдлүүд нь орон нутагт практик дээр бодлогын хэрэгжилт ямар түвшинд байхыг тодорхойлж өгдөг шиг орон нутагт хуримтлуулсан туршлага, сургамж нь эргээд үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлдэг. Орон нутаг дахь ардчилсан институц нь үндэсний түвшинд боловсруулсан бодлогын баримт бичгийн орон нутагт хэрэгжих боломжтой эсэхийг нягтлахад мөн чухал үүрэг гүйцэтгэнэ.

1.2. Ардчиллыг үнэлэх иргэдэд түшиглэсэн арга

Ардчиллыг үнэлэх иргэдэд түшиглэсэн үнэлгээний арга нь тухайн орон нутгийн иргэд л зөвхөн өөрийн амьдран буй орон нутгийн ардчиллын төлөв байдалд хамгийн үнэн бодитой дүгнэлт хийнэ гэсэн итгэл үнэмшилд суурилсан байдаг.

“Юуны өмнө тухайн орон нутгийн иргэдэд ардчиллын төлөв байдал, чанарт үнэлгээ хийх боломжийг олгох хэрэгтэй. Учир нь зөвхөн

нутгийн иргэд л улс оронд үйл явдал хэрхэн өрнөдгийг ойлгодог, зөвхөн тэд л өөрийн уламжлал, түүх, соёлоо мэддэг, нэн тэргүүний асуудал юу болохыг мөн тэд л хамгийн сайн мэддэг.”

Профессор Стюарт Виер, Ардчиллын аудит (2008)⁶

ОнАТБ хийх энэхүү аргачлалыг ашиглан нутгийн иргэд ардчиллын чанар, үр нөлөөнд үнэлгээ хийх боломжтой. Аргын хувьд иргэдэд түшиглэсэн бөгөөд иргэдийн оролцоо хамгийн их байдаг орон нутгийн ардчиллыг үнэлэхэд зохимжтой гэж үздэг. Энэхүү үнэлгээ нь иргэдийн дунд мэдлэг, мэдээлэл түгээх, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэх, шинэчлэл шаардлагатай салбаруудыг тодорхойлох зорилготой. Ардчиллыг турших, улмаар ардчилсан институцыг байгуулах гэдэг нь өөрөө харилцан биенээсээ суралцах, хуваалцах үйл явц юм. Иргэдээс хэдий чинээ олон төрлийн үзэл санаа гарч, үзэл бодлын зөрүүтэй байдал үүснэ тэр хэмжээнд ардчиллын үнэлгээ илүү үр дүнтэй, тал бүрийн оролцоо ихтэй, өргөн хүрээг хамарч чадна. Цаашлаад үнэлгээнээс гарах үр дүнд үндэслэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, хэлэлцүүлгийн агуулга тодрох бөгөөд энэ нь эцсийн эцэст шаардлагатай шинэчлэл, реформыг эхлүүлэхэд түлхэц болдог.

Үнэлгээний явцад өөр хоорондоо ялгаатай нийгмийн олон бүлэгт хамаарах эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй харилцан ярилцаж, холбогдох мэдээ, мэдээлэл хүргэхээс гадна ардчиллын талаарх тэдний ойлголт, хүлээлтээр дамжуулан орон нутгийн түвшин дэх ардчиллын төлөв байдлыг судлан, дүн шинжилгээ хийнэ. Энэ нь ОнАТБ-ын үнэлгээ хийхэд тухайн орон нутагт амьдардаг иргэн, байгууллагын төлөөлөл аль нь ч манлайлах үүрэгтэй оролцох боломжийг бүрдүүлнэ гэсэн үг юм. Гэхдээ энэхүү үнэлгээний үйл явц нь иргэд, олон нийтийн төлөөллийг аль болох өргөн хүрээнд хамарсан байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, цуглуулсан мэдээ, тоо баримт нь иргэд, олон нийтийн үзэл санаа, дуу хоолойг олон талаас нь харуулсан, ялгаатай шинж байдлыг нь тодотгосон байх ёстой юм. Тиймээс үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнд аль болох олон төрлийн сэдвийг хамрах, олон салбарын төлөөллийг багтаах, төлөөлөл дэх хүйсийн тэнцвэрт байдлыг хангах, нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн төлөөллийг түлхүү хамруулах нь чухал ач холбогдолтой. Ардчиллын төлөв байдалд хийх үнэлгээ амжилттай болох эсэх нь үнэлгээ хийх багийн мэдлэг, туршлага, ур чадварын зөв зохицол бүрдсэн эсэхээс шууд хамаарна.

ОнАТБ-ын үнэлгээ хийснээр улс, үндэстний хэмжээнд ардчилсан нийгмийн хувьсал, хөгжилд орон нутгийн ардчиллын оруулах хувь нэмрийг судлах боломж бүрдэх юм. Учир нь зөвхөн энд л хүний эрх, ардчилсан засаглал, ардчилсан институц, үйл явц бодит утгаараа амьдралд биелэлээ олж, ард түмний аж байдлыг сайжруулах үүрэг хүлээдэг.

1.3. Нийтлэг аргачлалыг орон нутгийн түвшинд ашиглах

ОнАТБ-ын үнэлгээ хийх энэхүү аргачлалыг улс орон бүрийн онцлогт тохируулж, өөрчлөн ашиглаж болохуйц хэлбэрээр

боловсруулсан болно. Энд “орон нутаг” гэдэг ухагдахуун нь муж, хот, орон нутгийн хүмүүсийн нэгдэл,⁷ суурин, тосгон⁸ гэх мэт нутгийн засаг захиргааны төрөл бүрийн нэгжийг төлөөлүүлж хэрэглэсэн ухагдахуун бөгөөд үүнд тухайн орон нутгийн нэгжийн газар нутгийн хэмжээ, байршил зэрэг үл хамаарна.

Хайрцаг 1.1.

Орон нутгийн түвшний нэгжийг хэрхэн сонгох вэ? Индонезийн жишээ

Индонезид Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээг хийхдээ түүх, нийгэм, эрх мэдлийн харилцаа, эдийн засгийн хөгжлийн түвшин хийгээд хүн амын нягтрал гэх мэт хүн ам зүйн онцлог шинж байдлаараа өөр хоорондоо ялгаатай 6 хотыг хамруулсан байна.⁹

Эдгээр зургаан хотыг сонгохдоо олон шалгуур үзүүлэлтийг ашиглаж сонгожээ. Хамгийн анхны шалгуур нь Индонезийн Дотоод хэргийн яамнаас гаргадаг нутгийн удирдах байгууллагын Хариуцлага, гүйцэтгэлийн жил тутмын тайлангийн үр дүнд үндэслэсэн 2011 оны жагсаалт байлаа. Энэ жагсаалт нь нутгийн удирдлагын байгууллагын гүйцэтгэлийг хамгийн сайнаас хамгийн муу хүртэл эрэмблэн жагсаасан байна. Энэ мэдээлэлд үндэслэн үнэлгээний баг орон нутгийн засаг захиргаа, удирдах байгууллагуудыг гүйцэтгэлээрээ доод, дунд, дээд гэсэн бүлэгт хуваасан юм.

Үүний дараа, эдгээр орон нутгийн байгууллагын эрх мэдлийн хуваарилалтыг нягталж үзсэн байна. Орон нутгийн зарим байгууллага эрх мэдлийн төвлөрсөн тогтолцоотой байсан бол зарим нь эрх мэдлийг холбогдох талуудад тархан хуваарилсан тогтолцоотой байв. Төвлөрсөн эрх мэдлийн тогтолцоо гэдэг нь тухайн орон нутагт улс төрийн эрх мэдэл зөвхөн нэг тоглогчийн (захиргааны, зах зээлийн, уламжлалт удирдагчийн) гарт байгаа удирлагын хэлбэрийг хэлдэг. Харин олон төвт эрх мэдэл хэмээх ухагдахуун нь улс төрийн эрх мэдэл олон тоглогчид дунд тархан хуваарилсан хэлбэр юм.

Нутгийн засаг захиргааны бүлэг бүрээс Индонезийн баруун, төв, зүүн хэсгийг төлөөлсөн, эрх мэдлийн олон төвт болон нэг төвт тус бүр нэг нутгийг оролцуулан дараах тойргийг сонгон авсан байна:

- Суракарта, Төв Жава (дээд, олон төвт);
- Жомбанг, Зүүн Жава (дээд, нэг төвт);
- Асех Бесар (дунд, олон төвт);
- Маноквари, Баруун Папуа (дунд, нэг төвт);
- Купанг, Зүүн Нуса Тэнгарра (дундаас доогуур, олон төвт);
- Париги Моутонг, Төв Сулавеси (доод, нэг төвт).

Хэдийгээр ОнАТБ-ын үнэлгээний аргачлал орон нутгийг голлон анхаардаг ч үүнийг мөн бүс нутаг, аймаг, нийслэл зэрэг улс үндэсний дэд түвшинд хийж болно. Харин эдгээр түвшинд үнэлгээ хийх нь харьцангуй төвөгтэй байх магадлалтай учир нь ардчиллын төлөв байдлыг бүсийн болон орон нутгийн анхан, дунд шат гээд олон түвшинд дүн шинжилгээ хийж, үнэлэх шаардлагатай болно. Засаглалын олон шатлал бүхий бүтэцтэй эсвэл холбооны улсад ОнАТБ-ын үнэлгээний аргачлал нь хангалттай бус гэвэл үнэлгээ хийх баг үндэсний хэмжээнд Ардчиллын төлөв байдлыг үнэлэх аргачлалаас (АТБ) тодорхой элементүүдийг авах шаардлагатай гэж үзэж болно. Үүнтэй нэгэн адилаар АТБ үнэлгээний аргачлалыг ОнАТБ үнэлгээний аргачлалын холбогдох хэсгүүдтэй нэгтгэн ашигласан тохиолдолд бүс нутгийн ардчиллын мөн чанарыг илүү тусгаж болно. ОнАТБ-ын үнэлгээний аргачлал нь залуу, бэхжсэн, хэврэг, эсвэл тогтвортой гэх мэт бүх төрлийн ардчиллын чанарын үнэлгээ хийхэд зориулагдсан юм. Ардчиллын аливаа хэлбэр бүр өөрийн онцлог шинжтэй, дотоод уг чанараараа хөгжин дэвшиж байх учиртай гэж үздэг. Гэхдээ ардчиллыг тусгайлан анхаарах нь шилжиж буй орны багийг жишээлбэл, өөрийн орны онцлог шинж, нөхцөл байдалд тохируулан үнэлгээг хийх сонголтод саад учруулах ёсгүй.

Өөрөөр хэлбэл, энэхүү үнэлгээний аргачлалыг ашигласнаар ардчилсан хөгжлийг бүх шатанд үнэлэх боломжтойгоос гадна хамгийн анхан шатнаас эхлэн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар ардчилсан үйл явцын өрнөлийг дэмжих, гүнзгийрүүлэх зорилготой юм. Энэхүү аргачлалыг тухайн улс орны онцлогт тохируулан өөрчлөн хэрэглэх боломжтой бөгөөд соёл, ёс заншлын хувьд ялгаатай улс оронд ч амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгөх юм. Тиймээс тус үнэлгээний тодорхой хэсгийг өөрийн орны онцлогт тохируулан өөрчилж, ардчиллын төлөв байдлыг үнэлж болно гэсэн үг юм.

Хайрцаг 1.2

Мусульманчуудын Минданаогийн автономит бүсэд хийсэн ОнАТБ-ын үнэлгээ

Мусульманчууд олноороо амьдардаг Минданаогийн автономит бүс нутагт хийсэн ардчиллын төлөв байдлын үнэлгээ нь (ОнАТБ ММАБ)¹⁰ 2011 оны 7 сард эхэлсэн юм. Энэ нь Филиппины ардчиллын төлөв байдлыг иргэдэд түшиглэсэн аргаар үнэлсэн 5 дахь үнэлгээ байсан бөгөөд энэхүү аргачлалын дагуу энэ улсад хийсэн анхны ОнАТБ-ын үнэлгээ байсан юм.

Нийт таван суурин газарт хийгдсэн ОнАТБ-ын үнэлгээ орон нутгийн ардчиллын чанарын талаар мэдээлэл харилцан солилцох ажиллагааг дэмжихэд чиглэсэн байв. ММАБ болон үндэсний засгийн газар хоорондын харилцаа, орон нутгийн засаглалын асуудлууд тэр дундаа Филиппины өмнөд хэсэгт орших мусульманчууд түлхүү оршин суудаг орон нутаг дахь ардчиллын өмнө тулгарч буй асуудлуудыг тусгасан болно. Тухайн үед Филиппин улсад бий болоод байсан улс төрийн тогтворгүй байдал, үл ойлголцлыг арилгаж, энх тайвныг тогтоох

Хайрцаг [үрг.]

яриа хэлцэл, нийгмийн шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулна гэж найдаж тус үнэлгээний тайланг 2013 оны 9 сарын 2-ны өдөр нийтэд танилцуулсан билээ.

Үнэлгээг иргэд хөтлөн явуулж, эзэмшдэг, түүнчлэн үйл ажиллагаанд чиглэсэн, орон нутгийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой байдаг нь энэ аргачлалын давуу тал юм. Үнэлгээний энэхүү шинэчилсэн аргачлал өмнөх хувилбар болон бусад үнэлгээнээс зарим онцлог шинж байдлаараа ялгагдана.

Эдгээр онцлог шинж байдлын талаар 2-р бүлэгт илүү дэлгэрэнгүй өгүүлэх бөгөөд мөн дараах мэдээлэл багтана.


- Үнэлгээ нь орон нутгийн түвшинд ардчиллын үнэт зүйлс, үндсэн зарчмуудыг илэрхийлж, төлөөлж чадаж байгаа эсэхэд гол анхаарлаа хандуулдаг.
- Үнэлгээний хамгийн эхэнд хийх ажил бол орон нутгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх явдал юм.
- Үнэлгээ нь дараах үндсэн гурван тулгуурыг хамарч дүн шинжилгээ хийх учиртай:

I. Тэгш эрх, шударга байдал.

II. Төлөөлөл бүхий, эгэх хариуцлагатай институц, үйл явц.

III. Иргэдийн санаачилга, оролцоо.

- Үнэлгээний тулгуурт доор дурдсан нийтлэг шинжтэй асуудлыг мөн тусгахад тусгайлан анхаарах ёстой.
 - жендерийн мэдрэмжтэй үнэлгээний хандлагатай уялдуулах;
 - нийгмийн нягтрал болон бусдаас ялгаатай бүлэгт анхаарал хандуулах;
 - орон нутгийн түвшинд аюулгүй байдал; зөрчил мөргөлдөөний эрсдэл байгаа эсэхийг нягтлах, хүлээн зөвшөөрөх;
 - ардчилал, хөгжил хоорондын чухал уялдаа холбоог анхаарах.



БҮЛЭГ 2

ОнАТБ Үнэлгээний
аргачлал

ОнАТБ Үнэлгээний аргачлал

ОнАТБ-ын үнэлгээний аргачлалын гол зорилго нь дэлхийн аль ч улс орны орон нутгийн түвшинд нийтлэг аргачлалаар ардчиллын чанарт үнэлгээ хийх явдал юм. Энд ‘чанар’ хэмээх ойлголт нутгийн удирдлагын байгууллага, түүний үйл ажиллагаанд ардчиллын үндсэн зарчим, үнэт зүйлс хэр хэрэгжиж байгаа, гаргаж буй шийдвэрт нь ард түмэн хяналт тавьдаг эсэх, энэхүү хяналтыг хэрэгжүүлэхэд иргэд адил тэгш оролцдог эсэхийг илэрхийлнэ.¹¹

Ардчиллын эдгээр зарчим, үнэт зүйлс нь орон нутгийн түвшинд ардчиллын үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангах гол үндэс болдог. Тиймээс ардчиллын үндсэн зарчим, үнэт зүйлсийг хуульчлах, хуулиар хамгаалж төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд эрхэмлэх, төлөөлөл, оролцоо, хууль ёсны байдал, хариу шуурхай байдал, эгэх хариуцлагатай, ил тод байдал, эв нэгдэл зэрэг ардчиллын үнэт зүйлийг орон нутагт бэхжүүлэхэд иргэдийн санаачилга, оролцоог гол арга хэрэгсэл болгох ёстой (бүлэг 2.1-ээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл харах).

Төгс ардчилал гэж байхгүйн дээр улс төр, нийгмийн тогтолцоо бүрт давуу болон сул тал олон байх тул орон нутгийн ардчиллын чанарыг дараах үндсэн гурван тулгуурын хүрээнд үнэлэхэд энэхүү аргачлалыг ашиглах зориулалттай.

Хүснэгт 2.1. ОНАТБ-ын гурван тулгуурт бүтэц

1. ИРГЭНИЙ ХАРЬААЛАЛ, ТЭГШ ЭРХ, ШУДАРГА ЁС	2. ТӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ, ЭГЭХ ХАРИУЦЛАГАТАЙ ИНСТИТУЦ, ҮЙЛ ЯВЦ	3. ИРГЭДИЙН САНААЧИЛГА, ОРОЛЦОО
<p>1.1 Орон нутгийн түвшин дэх иргэний харьяалал</p> <p>1.2 1.2.Иргэний ба улс төрийн эрх</p> <p>1.3 1.3.Эдийн засаг, нийгэм, соёлын эрх</p> <p>1.4 1.4.Хууль дээдлэх ёс ба шүүхийн хүртээмжтэй байдал</p>	<p>2.1 Сонгууль ба орон нутагдахь шууд ардчиллын механизмүүд</p> <p>2.2 Орон нутгийн хууль тогтоох байгууллага</p> <p>2.3 Улс төрийн намууд</p> <p>2.4 Орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд</p> <p>2.5 Заншлын болон уламжлалт институт</p>	<p>3.1 Иргэдийн идэвхтэй оролцоо</p> <p>3.2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл</p>


Иргэний харьяалал гэдэг бол иргэний эрх, эрх чөлөө, шударга ёсны нэгдэл бөгөөд (Тулгуур 1) төлөөлөл бүхий, эгэх хариуцлагатай институт, үйл явцаар (Тулгуур 2) дамжин байгууллага, хүмүүсийн үйл ажиллагаагаар хэрэгждэг (Тулгуур 3).¹²

Зарчмын хувьд, үнэлгээний эхний шатанд тухайн улсын иргэдийн иргэний, улс төр, нийгэм-эдийн засгийн эрхэд юу хамаардгийг тодорхойлох нь зүйтэй. Түүний дараагаар орон нутгийн удирдах байгууллагын ардчиллын төлөв байдал, чанарт үнэлгээ хийх ёстой. Үүний дараа иргэд хуулиар хамгаалагдсан эдгээр эрх, эрх чөлөөгөө хэрхэн хэрэгжүүлж байна, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн оролцоог дэмжих ямар боломжууд байгааг судалж үзэх хэрэгтэй.

Дээр дурдсан тулгуур баганууд өөр хоорондоо нягт холбоотой, салшгүй асуудлууд мөн боловч үнэлгээний аргачлалыг тухайн орон нутгийн онцлог байдалд тохируулан өөрчилж болох бөгөөд үнэлгээ хийж буй баг хэрэгцээ, шаардлага, эх үүсвэр зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхой нэг асуудалд бусдаас түлхүү анхаарал хандуулан нарийвчлан үнэлж болох юм. Тухайлбал, иргэдийн санаачилга, оролцоо гэсэн тулгуур асуудлаас гадна иргэний харьяалал, хүний эрх, шударга ёсны асуудалд түлхүү анхаарал хандуулж, нарийвчлан судлах шаардлага байж болно.

Дүн шинжилгээ хийхдээ тухайн орон нутгийн мэдээлэлд үндэслэн боловсруулах шаардлагатай. Ардчиллын үндсэн зарчим, үнэт зүйлс бүгд үнэлгээний хүрээг үргэлж бэхжүүлж, бататгаж байдаг бөгөөд үнэлгээ хийхэд ашиглах асуултуудад тусгалаа олсон байдаг.

Зураг 2.1. ОНАТБ үнэлгээний аргачлалыг дүрслэх нь



2.1. Ардчиллын зарчим, үнэт зүйлс

Орон нутгийн ардчиллын төлөв байдлыг үнэлэх аргачлал нь шийдвэр гаргах үйл явц, шийдвэр гаргагчдыг ард түмэн хянах, энэхүү хяналтыг хэрэгжүүлэгчид улс төрийн тэгш эрхтэй байх гэсэн үндсэн хоёр зарчимд суурилсан ардчиллын тухай ойлголтод үндэслэдэг. Ард нийтийн хяналт, улс төрийн эрх тэгш байдал гэсэн хоёр зарчим хэр мөрдөгдөж байна, тэр хэмжээгээр ардчилал байна хэмээн тодорхойлж болно.¹³

Энэ нь орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, холбогдох шийдвэрийг гаргахдаа тухайн нутгийн иргэд, эмэгтэй, эрэгтэй иргэдийн үзэл бодол, хүсэл тэмүүлэл, эрмэлзэлд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэл тухайн орон нутгийн элит хэсэг буюу цөөн хэдэн тоглогчийн

гарт бус харин яс үндэс, нас, шашин, нийгмийн анги давхарга, нийгэмд эзлэх байр суурь, хэл, соёл зэргээрээр өөр хоорондоо ялгаатай нийгмийн бүх бүлгийн эрх ашгийг төлөөлөх төлөөлөлд жигд хуваарилагдах ёстой юм. Мөн түүнчлэн, орон нутгийн ардчилсан үйл явц дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн төлөөллийг ижил түвшинд хангаж чадаагүй нөхцөлд ардчилсан үйл явц нь өөрөө дутуу, алдаатай болох юм.

Төлөөллийн институтээр дамжуулан ард нийтийн хяналт, улс төрийн тэгш байдлыг хэрхэн хангаж байгааг үнэлэхийн тулд ардчиллын үнэт зүйлсийг нарийн судлах шаардлагатай.

Ардчиллын үнэт зүйлс гэдэгт төлөөлөл, оролцоо, зөвшөөрөл, эгэх хариуцлага, хариу шуурхай байдал, ил тод байдал, хууль ёсны байдал болон эв нэгдэл хэмээх ойлголтууд багтаж байгаа¹⁴ бөгөөд төрийн шийдвэрт ард нийтийн зүгээс тавих хяналт хийгээд улс төрийн эрх тэгш байдлын зарчмууд нь хүний эрх, ардчилсан институтээр дамжин өдөр тутмын амьдралд биелэлээ олдог юм. Ардчиллын үнэт зүйлс, зарчмууд нь орон нутагт хүний эрхийн хэрэгжилт, ардчилсан институц, түүний үйл ажиллагааг үнэлэх стандартыг тогтоож өгдөг учир ардчиллын төлөв байдал, чанар орон нутагт ямар түвшинд байгааг үнэлэх гол хэмжээс болдог байна.

Тодорхой зарчим, үнэт зүйлсэд тулгуурласан ардчиллын тухай үзэл баримтлал олон нийтийн зүгээс ардчиллын чанарт үнэлгээ өгөх хүрээг бий болгоход тус дэм болдог. ОнАТБ-ын үнэлгээний үе шат бүрт ардчиллын үнэт зүйлс, зарчмуудыг цогцоор нь ашиглах нь зүйтэй. Тэгснээр үнэлгээний аргачлалыг тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохируулахад дэмжлэг үзүүлэхээс гадна (ж.нь: судалгааны илүү дэлгэрэнгүй ярилцлагын асуултууд бэлтгэх гэх мэт), үнэлгээ, судалгааны үр дүнг тайлбарлах, бодит байдалд илүү дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийхэд тусалдаг. ОнАТБ-ын үнэлгээ хийх аргачлалыг тухайн онцлог байдалд тохируулан өөрчилж болох уян хатан шинж чанартай бол харин ардчиллын үнэт зүйлс, зарчмууд нь үргэлж ялгарч чухал байр суурь эзэлж байх ёстой.

Хүснэгт 2.2. Үнэт зүйлс

АРДЧИЛСАН ЗАРЧМУУД БА ҮНЭТ ЗҮЙЛС

Ардчиллын үндсэн зарчмууд:

- Шийдвэр гаргах үйл явц, шийдвэр гаргачдад тавих ард нийтийн хяналт
- Нийтийн хяналт дахь тэгш байдал

ҮНЭТ ЗҮЙЛС¹⁵	ТОДОРХОЙЛОЛТ
<i>Төлөөлөл</i>	Төлөөлөл гэдэг нь бүс нутаг, аймаг, орон нутгийн түвшинд сонгууль, улс төрийн намуудын төлөөллөөр дамжуулан ардчиллын институц, үйл явцад оролцох явдлыг хэлнэ. Төлөөлөл нь ард түмний эрх мэдэл, олон нийтийн янз бүрийн санаа бодлын бодит илэрхийлэл болдог.
<i>Оролцоо</i>	Оролцоо бол ардчиллын зайлшгүй нөхцөл бөгөөд институцчилэгдсэн болон албан бус механизмаар дамжуулан оролцоог хангаж болно. Иргэд гагцхүү улс төрийн үйл явцад оролцох замаар өөрсдийн төлөөлөгчдийг сонгож, тэднийг чиглүүлж, орон нутгийн бодлого, хөгжлийн хандлагыг тодорхойлдог.
<i>Зөвшөөрөл¹⁶</i>	Зөвшөөрөл гэдэг нь чөлөөт, шударга сонгуультай салшгүй холбоотой. Орон нутгийн сонгууль иргэдийн ашиг сонирхлыг нутгийн удирдлагын байгууллагад төлөөлөх төрийн албан хаагчдыг иргэд өөрсдөө сонгох боломжийг бүрдүүлдэг.
<i>Хууль ёсны байдал</i>	Ардчилсан хууль ёсны байдал гэдэг нь сонгогдсон төлөөлөгчдийн шийдвэр, үйлдлийн эрх мэдлийг нийтээр хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, ардчиллын үйл явц, холбогдох дүрэм журмыг ард иргэд бодит байдал дээр хүлээн зөвшөөрч, хүндэлж байгааг баталгаажуулахыг хэлнэ.
<i>Хариу шуурхай байдал</i>	Энэ нь нутгийн удирдлагын байгууллага иргэдийн хэрэгцээ шаардлага, сонголтын хариуд шуурхай арга хэмжээ авдаг, орон нутгийн бодлого ард иргэдийн хүсэл зоригийг илэрхийлдэг байхыг хэлнэ.
<i>Эгэх хариуцлага¹⁷</i>	Эгэх хариуцлага гэдэг нь орон нутгийн иргэд, тэдний төлөөлөл хоорондын харилцааг илэрхийлэх бөгөөд шийдвэр гаргагч төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх гэх мэт асуудлаар гаргасан шийдвэрийн төлөө хариуцлага хүлээж, тайлагнадаг байхыг хэлнэ. Эгэх хариуцлага нь босоо (эрх мэдэл тусгаарлах) болон хэвтээ (иргэн-элит) гэсэн хэмжээстэй байдаг.
<i>Ил тод байдал¹⁸</i>	Ил тод байдал гэдэг нь орон нутгийн төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, урьдаас ойлгомжтой, тайлагнах шинж чанарыг бүхэлд нь илэрхийлсэн ойлголт юм. Энэ нь ардчилсан үйл явцад иргэдийн оролцоог хангах, төрийн албан тушаалтанд хяналт тавих, эгэх хариуцлагатай, шуурхай байдлыг хангахад чухал ач холбогдолтой.
<i>Эв нэгдэл</i>	Эв нэгдэл нь бие даасан хувийн харилцааг бус, харин янз бүрийн хүмүүсийг холбож буй нийгэм дэх холбоо харилцааг илэрхийлдэг. Энэхүү ойлголт орон нутгийн түвшинд нийгмийн нягт холбоо, нэгдмэл байдал, иргэдийн эрх тэгш байдлаар илрэхээс гадна нийгмийн ялгаатай анги бүлэгт хамаарах иргэд хоорондын харилцаанд илэрдэг бөгөөд ингэснээр иргэд иргэний эрх, эрх чөлөө орон нутагт хэрхэн баталгаажиж байгааг үнэлэх боломж бүрддэг.

2.2. Орон нутгийн түвшинд хийх нөхцөл байдлын шинжилгээ

Орон нутаг дахь ардчилсан засаглалын төлөв байдлын үнэлгээ нь аливаа орон нутгийн хөгжлийн өвөрмөц шинж байдлыг хамгийн нарийн нягт судлах боломжтой байдгаараа давуу талтай. Орон нутаг бүр өвөрмөц байдал, онцлог шинж чанартай тул юуны өмнө тухайн газар нутгийн талаарх тоон болон чанарын мэдээлэл цуглуулах, тухайн газар нутгийн бусдаас ялгарах онцлог байдлыг илэрхийлсэн мэдээлэл, түүх, өгүүлэл зэргийг цуглуулах хэрэгтэй.

ОнАТБ-ыг судлахад нөхцөл байдлын шинжилгээ нь чухал ач холбогдолтой бөгөөд хэтийн төлөвт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнг тайлбарлахад дэмжлэг үзүүлдэг. Тиймээс нөхцөл байдлын шинжилгээг орон нутаг дахь ардчиллын төлөв байдлын үнэлгээний үндэс гэж ойлгож болно. Нөхцөл байдлын шинжилгээ нь тухайн орон нутагт ардчилсан үйл явц хэрхэн өрнөсөн түүхэн замналыг илүү сайн ойлгох боломжийг үнэлгээ хийж буй багт бүрдүүлдэг.

Нөхцөл байдлын шинжилгээнд дараах салбарын мэдээллийг түлхүү ашиглах нь зүйтэй.

- *Түүх, газарзүйн болон нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн мэдээлэл.* Аливаа орон нутгийн түүх, газарзүй, нийгэм эдийн засгийн тогтолцоонд ардчилсан үйл явц тодорхой хэмжээнд байр суурь эзэлсэн байдаг. Эдгээр тогтолцооны зарим онцлог талуудыг ардчилсан үйл явцын туршид хамгаалан, хяналт тавих ёстой байдаг бол эдгээрийн зарим нь ардчилсан үйл явцтайгаа зэрэгцэн хөгжиж нийгмийн интеграц, ардчилсан үйл явцын нэг хэсэг болон цааш хөгждөг, харин зарим нь нийгмийн дунд хагарал, хуваагдлыг бий болгож ардчилсан хөгжлийн явцад саад учруулна. Тухайн орон нутагт амьдарч буй иргэдийн хүйс, нас, соёл, шашны онцлог, нийгэм-эдийн засгийн төлөв байдал, орлого, ажил эрхлэлтийн түвшин, суурьшил, хүн ам зүйн онцлог шинж бүгд үнэлгээ хийж буй ардчилсан үйл явцын хөгжилд нөлөө үзүүлж, хөгжлийн чиг хандлага, хэлбэрийг тодорхойлж байдаг тул нөхцөл байдлын шинжилгээ хийхэд чухал ач холбогдолтой байдаг. Эдгээр мэдээлэл нь ардчилсан нийгмийн үндсэн үзүүлэлтүүд болох газар, ус, байгалийн баялаг зэргийг ашиглах, хүртэх бололцоо зэрэг тухайн орон нутгийн улс төр, эдийн засгийн асуудлуудад дүн шинжилгээ хийхэд мөн чухал ач холбогдолтой. Учир нь дээр дурдсан асуудлууд орон нутгийн түвшинд бүрэн шийдэгдсэн байх нь ховор, ихэнх тохиолдолд иргэд ардчилсан институц, үйл явцад үл итгэх явдлын үндсэн шалтгаан, эх үндэс болсон байдаг ажээ. Аль нэг хүйсэд давуу эрх олгосон, нийгмийн үүрэг хариуцлагыг тухайн нэг хүйсэд тохоосон, биологийн болон нийгмийн хүйсийн онцлог байдлаас шалтгаалж нийгмээс гадуурхагдсан эмзэг бүлгийн асуудлыг мөн нөхцөл байдлын шинжилгээний хүрээнд нарийвчлан авч үзэх шаардлагатай.
- *Орон нутгийн удирдлагын үүрэг, нөлөө.* Орон нутгийн удирдах байгууллага бол улс төрийн илүү том тогтолцоо, бүтцэд хамаарах нэгж юм. Үйл ажиллагаа, эрх мэдлийн хувьд бие даасан бус, улс төр, эдийн засгийн хувьд төвлөрсөн засгийн газраас хараат байдаг

бөгөөд эрх мэдлийн хувьд хязгаарлагмал эрх мэдэлтэй. Төв болон орон нутгийн удирдах байгууллагуудын харилцааг үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг бөгөөд энэхүү зохицуулалт практик дээр хэрхэн хэрэгжиж байгаагаас шалтгаалж орон нутаг дахь ардчиллын хөгжилд дэмжлэг үзүүлж эсвэл саад учруулж байгааг тодорхойлж болно. Орон нутгийн засаг захиргаа төв засгийн газраас хол байж, өөрийн эрх мэдлээ хэрэгжүүлж, орон нутгийн иргэдэд нөлөөлөх шийдвэр гаргах боломж бүрдэнэ. Орон нутгийн удирдах байгууллагын үүрэг хариуцлага, эрх мэдлийн ялгаатай байдлыг ойлгохын тулд тухайн улсын засаглалын бүтэц, төвлөрлийг сааруулах хүрээ, хэрэгжилтийн байдал зэргийг дэлгэрэнгүй тайлбарласан байх хэрэгтэй.

Төв засгийн газар болон орон нутгийн удирдах байгууллага хоорондын харилцааг тайлбарлахын тулд түүхэн үйл явц тэр дундаа эрх мэдлийн хуваарилалтыг хэрхэн институцын түвшинд хэрэгжүүлсэн зэргийг нарийвчлан судлах шаардлагатай. Холбооны, конфедераци, нэгдмэл гэх мэт улс төрийн байгууламжийн хувьд ялгаатай улс орон бүр эрх мэдлийн хуваарилалтыг өөрийн орны онцлогт тулгуурлан хийж, орон нутагт ардчилсан үйл явцыг өөр өөрийн хувилбараар хэрэгжүүлдэг. Гэхдээ орон нутаг дахь ардчиллын энэхүү онцлог шинж нь эерэг бөгөөд сөрөг үр дагаврын аль алиныг бий болгодог. Хамгийн их маргаан дагуулдаг асуудлуудад санхүүгийн болон бусад эх үүсвэрийн удирдлага, газрын харилцаа, газар өмчлөх эрх, нутгийн уугуул иргэд болон цагаач иргэд зэрэг нийгмийн цөөнхийн асуудал багтана. Асуудал хурцадсан нөхцөлд хүчирхийлэл дагуулсан зөрчил, тэмцэлд ч хүрч болзошгүй байдаг. Тиймээс нутгийн удирдах байгууллагын үүрэг, нөлөө, төв засгийн газраас хараат бус, бие даасан байх нь орон нутаг дахь ардчиллын хөгжлийн үндэс байдаг.

Хайрцаг 2.1

Төвлөрлийг сааруулах

Төвлөрлийг сааруулах гэдэг бол улс төр, эрх зүй, засаг захиргааны шинэчлэлийг хамарсан үндэсний хэмжээний үйл явц юм. Орон нутгийн засаглал болон төвлөрлийг сааруулах үйл явц нь улс төр, нийгмийн нөхцөл, цаг үеийн хэрэгцээ шаардлага зэргээс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Тиймээс улс, орон нутаг бүрт төвлөрлийг сааруулах үйл явц харилцан адилгүй өрнөдөг.

Хэдийгээр тухайн улс орон нутгийн нөхцөл байдал, хэрэгцээ зэргээс хамаарч төвлөрлийг сааруулах үйл явц харилцан адилгүй байдаг ч төвлөрлийг сааруулах үйл явцын дараах хэлбэрүүд ихэнх улс оронд нийтлэг ажиглагддаг. Эдгээр нийтлэг хэлбэрт (а) салбарын хэмжээнд төвлөрлийг сааруулах эсвэл (б) Ажил үүргээ хариуцан тайлагнах тогтолцооны төвлөрлийг сааруулах үйл явц багтана. Салбарын түвшинд төвлөрлийг сааруулах гэдэгт засаг захиргаа, улс төрийн эрх мэдэл, санхүүгийн эх үүсвэр, эдийн засаг, зах зээлийн төвлөрлийг сааруулах үйл явцыг ойлгох бол үүрэг хариуцлагын төвлөрлийг сааруулах гэдэгт нягтралыг сийрэгжүүлэх, эрх мэдэл шилжүүлэх, төлөөлүүлэх зэргийг ойлгоно.

Хайрцаг [үрг.]

Дээр дурдсан төвлөрлийг сааруулах бүх хэлбэрт эрх мэдэл, үүрэг хариуцлагыг нэгээс нөгөөд шилжүүлэх асуудал яригдах бөгөөд засгийн газрын төрөл бүрийн шатны байгууллага хооронд энэхүү эрх, үүргийн шилжилт хийгддэг бол зарим улсад төрийн эрх, үүргийг хэсэгчлэн хувийн салбарын байгууллагад шилжүүлэх тохиолдолд ч байдаг.

Төвлөрлийг сааруулах үйл явц нь төрийн эрх мэдлийг орон нутагт буюу иргэдэд ойртуулдаг учир орон нутгийн ардчиллын хөгжилд эерэг нөлөө авчирдаг. Гэхдээ төвлөрлийг сааруулна гэдэг нь төр, засгийн аливаа шийдвэрт тавих ард нийтийн хяналт шууд бий болно, хяналтад иргэд тэгш эрхтэй оролдоно гэсэн үг биш юм. Төвлөрлийг сааруулах үйл явц нь бодит байдал дээр тухайн орон нутгийн онцлог шинж байдлаас хамаарч ардчиллын хөгжилд нөлөөлнө.

- *Хүний аюулгүй байдал*

Хүний аюулгүй байдлыг хангах, тайван аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх явдал бол ардчилсан нийгмийн хамгийн үндсэн шаардлага байх ёстой.¹⁹ Энэ зорилгын үүднээс ардчилсан үйл явц чөлөөтэй хөгжих биет болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай болдог.

Орон нутгийн ардчиллыг үнэлэхэд амьдрах орчны аюулгүй байдлаас гадна хүний аюулгүй байдлын асуудлыг нягт судалж үзэх шаардлагатай. Орон нутгийн түвшинд хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг нийгмийн олон үзэгдэл байдгаас ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл, байгалийн гамшиг, нийгмийн цөөнх бүлгийг хавчин гадуурхах, жендерт суурилсан хүчирхийлэл, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл (хар тамхи, зэвсгийн худалдаа, байгалийн баялагийн хууль бус наймаа, газрын хууль бус наймаа, хүчээр улсын өмч болгох гэх мэт), зэвсэгт хүчин зэрэг нь хамгийн их эрсдэл дагуулсан нийгмийн үзэгдлүүд байдаг. Нийгмийн эдгээр сөрөг үзэгдлүүд бүхэлдээ зөвхөн нэг хүчин зүйлээс шалтгаалсан, түүнтэй холбоотой байх нь ховор. Ямартай ч эдгээр асуудлууд нь нийгмийн бүлэг хоорондын зөрчил мөргөлдөөний хамгийн түгээмэл илэрдэг асуудлууд юм.

Хайрцаг 2.2

Хохирол учруулахгүй байх

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй тогтворгүй, зөрчил мөргөлдөөн ихтэй улсад орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүсдэг ба зарим тохиолдолд ардчиллын төлөв байдлыг үнэлэх оролдлого нь тухайн орон нутагт үүсээд байсан зөрчил, маргааныг улам гүнзгийрүүлэх эрсдлийг дагуулдаг. Нөхцөл байдал ийм тохиолдолд үнэлгээний загвараа боловсруулахдаа нарийн, эмзэг асуудлыг анхаарч үзэх нь чухал. Жишээлбэл, улс төрийн дотоодын зөрчил, мөргөлдөөн ихтэй улсад сонгууль болохоос өмнө бус сонгууль болсны дараа

Хайрцаг [үрг.]

ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх нь илүү тохиромжтой. Дотоодын зөрчил, мөргөлдөөн ихтэй улсад асуудлыг улам хурцатгах эрсдэл өндөр байгаа нөхцөлд ардчиллын төлөв байдалд хийх үнэлгээг хойшлуулах, хэсэг хугацаанд хүлээх нь илүү ухаалаг шийдвэр байж болох талтай.

ОнАТБ нь хэдийгээр үнэлгээ хийх явцад иргэд, олон нийтийг нэгтгэх, хамтран шинэчлэл хийхэд нь дэмжлэг үзүүлэх гэх мэт давуу талтай боловч зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх, аюулгүй байдлыг хамгаалахад тохиромжтой механизм, аргачлал биш юм.

Чиглүүлэх асуултууд

Нөхцөл байдлын шинжилгээ хийх шатанд доор дурдсан үндсэн асуултыг ашиглан холбогдох мэдээллийг цуглуулах боломжтой. Нөхцөл байдлын шинжилгээ бол орон нутгийн ардчиллын төлөв байдалд хийх үнэлгээний анхан шатны судалгаа, шаардлагатай мэдээллийг цуглуулах ажлын эхлэл юм. Доор дурдсан асуултууд нь нөхцөл байдлын шинжилгээнд ашиглагддаг үндсэн асуултууд бөгөөд үнэлгээ хийх баг өөрсдийн мэдлэг, туршлагад үндэслэн аль сэдэв, асуултын хүрээнд илүү нарийвчилсан шинжилгээ, тусгай анхаарал хандуулах ёстойг шийдэх учиртай.

Хайрцаг 2.3**Нөхцөл байдлын шинжилгээ: Чиглүүлэх асуултууд**

Нөхцөл байдлын шинжилгээ нь орон нутгийн бодит байдал, хэтийн төлвийг тодорхойлж, ардчиллын үнэлгээний үндэс суурийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

А. Түүх, газар зүйн болон нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн мэдээлэл

Нийтлэг асуулт: Ардчиллын төлөв байдлыг ойлгоход чухал ач холбогдолтой тухайн орон нутагт хамаарах түүх, газарзүйн болон нийгэм, эдийн засгийн ямар онцлог шинж байдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- a. *Орон нутгийн үүсэл, хөгжилд чухал байр суурь эзэлдэг ямар түүхэн үйл явдлууд байдаг вэ?*
- b. *Орон нутагт хамаарах газар зүйн болон хил хязгаарын ямар онцлог шинжүүд байдаг вэ?*
- c. *Зөвхөн тодорхой газар нутагт хамаарах тусгай зохицуулалт байдаг эсэх хэрэв байдаг бол энэхүү зохицуулалт нь нутгийн уугуул иргэд, цөөнхийн бүлгийн өөрөө удирдах ёс, уламжлалтай хэрхэн холбогддог вэ?*

Хайрцаг [үрг.]

- d. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн үндэс, эх үүсвэр юунаас бүрддэг, хэн түүнийг эзэмшиж, захиран зарцуулж, хянах эрхтэй байдаг вэ?
- e. Тухайн орон нутагт байгалийн баялаг байх эсвэл огт байхгүй явдал нь орон нутгийн иргэдийн амьдралд ямар хэмжээнд нөлөө үзүүлэх вэ?
- f. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүрээлэн буй орчин, нийгэм-эдийн засагт үзүүлдэг сөрөг нөлөөлөл тухайн орон нутагт хэр тохиолддог вэ?
- g. Орон нутаг дахь эдийн засгийн нөхцөл байдлын улмаас нийгмийн ямар давхарга, хуваагдал бий болсон бэ?
- h. Соёл, шашин шүтлэг, үндэстэн болон хэл зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай, тусгай бүлэг, хүн ам байдаг эсэх?
- i. Тухайн орон нутагт шилжин ирсэн хүн амын тоо ямар түвшинд байдаг вэ?
- j. Орон нутгийн хүн амын нас, хүйсийн бүтэц ямар вэ?
- k. Өөр хоорондоо ялгаатай нийгмийн бүлгүүд хооронд орон нутгийн түүхэн хөгжил, газар зүйн болон хил хязгаарын зохицуулалт, нийгэм-эдийн засаг, хүн ам зүйн бүтцийн талаар нэгдсэн ойлголт, зөвшилцөл ямар түвшинд байдаг вэ?

Б. Нутгийн удирдлагын байгууллагын үүрэг, нөлөө

Нийтлэг асуулт: Улс орны засаглалын институцэд нутгийн удирдлагын байгууллагууд ямар үүрэг, нөлөөтэй байдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- a. Үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшиний институц хоорондын харилцаа, бүтэц зохион байгуулалтыг хэрхэн тайлбарлаж болох вэ?
- b. Орон нутгийн түвшинд ямар ардчилсан (эсвэл улс төрийн) институц, үйл явц байдаг вэ?
- c. Төвлөрлийг сааруулах үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг баталсан байдаг уу?
- d. Хэрэв тийм бол төвлөрөлийг сааруулах ямар төрлийн тогтолцоо байдаг вэ? Төвлөрлийг сааруулах, эрх мэдэл шилжүүлэх, төлөөлөх эсвэл нэгдэх зэрэг хэлбэрүүдийн аль болох? Гол онцлог шинж, бүтэц зохион байгуулалт нь ямар байдаг вэ?
- e. Төвлөрлийг сааруулах институцын болон бодлогын хүрээний баримт бичигт орон нутгийн ямар эрх мэдэл, шийдвэр гаргах үүрэг, хариуцлагын талаар зөвлөсөн байдаг вэ?
- f. Орон нутгийн бодлогыг засаглалын ямар түвшинд боловсруулдаг вэ?
- g. Орон нутгийн байгууллага орлогын эх үүсвэртэй болох, түүнийг захирах, зарцуулах тал дээр хэр бие даасан, эрх мэдэлтэй байдаг вэ?

Хайрцаг [үрг.]

- h. Эгэх хариуцлагын хэвтээ болон босоо тогтолцооны аль бүтэц нь албан ёсоор байдаг вэ?*
- i. Орон нутгийн түвшинд ардчиллын чанар, хэвийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг засаглалын уламжлалт институц эсвэл тогтолцоо байдаг уу?*
- j. Нутгийн засгийн газрын үйл ажиллагаанд хууль бус байдлаар нөлөөлдөг институц, бүтэц байдаг эсэх?*

С. Хүний аюулгүй байдал

Нийтлэг асуулт: Хүний аюулгүй байдал орон нутагт ямар түвшинд хангагдсан байдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- a. Сүүлийн хэдэн жил өлсгөлөн, онц аюултай өвчний тархалт, ган зэрэг байгалийн гамшиг хэр тохиолдсон бэ?*
- b. Аливаа төрлийн зөрчил (зэвсэгт) мөргөлдөөн гарсан эсэх, хэрэв гарсан бол ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?*
- c. Дээр дурдсан аюултай нөхцөл байдал орон нутгийн иргэдийн амьдрал, аюулгүй байдал хийгээд амьдрах орчинд ямар түвшинд сөргөөр нөлөөлж, аюул, эрсдэл дагуулдаг?*
- d. Орон нутгийн иргэд, хүн амын аюулгүй байдал, амьдралд учирч болох эдгээр эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюул занал, зөрчлийг арилгах, шийдвэрлэх эрх бүхий ямар байгууллага байдаг вэ?*
- e. Зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ, хууль бус хагас цэрэгжсэн зэвсэгт хүчин зэрэг хүчний байгууллагуудаас хараат бус, бие даасан байдлаар ажиллаж чаддаг эсэх?*
- f. Орон нутагт хууль сахиулах үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагаа олон нийтэд ил тод байдаг эсэх, тэдний үйл ажиллагааг ардчилсан механизмаар дамжуулан хянан шалгах боломжтой эсэх?*
- g. Хүний аюулгүй байдлын асуудал, сорилт бэрхшээл эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлдөг вэ?*
- h. Дээрх сорилт бэрхшээлүүд орон нутагт амьдарч буй нийгмийн олон янз бүлэг, давхаргад хэрхэн ялгаатай байдлаар нөлөөлдөг вэ?*

2.3. ОНАТБ үнэлгээний тулгуур

ОНАТБ-д үнэлгээ хийх энэхүү аргачлал нь орон нутаг дахь ардчиллын дараах гурван тулгуур баганыг үндэслэн ардчиллын хөгжил, төлөв байдлыг үнэлэхэд туслах зориулалттай:

1. Иргэний харьяалал, тэгш эрх, шударга ёс;
2. Төлөөлөл бүхий, эгэх хариуцлагатай институц, үйл явц;
3. Иргэдийн санаачилга, оролцоо.

Ардчиллын гурван тулгуур баганын талаарх товч танилцуулга, холбогдох чухал асуудлыг доор хураангуйлав.

Тулгуур 1: Иргэний харьяалал, тэгш эрх, шударга ёс

Ардчилсан нийгэм иргэнээс эхэлдэг. Тиймээс ардчиллын үнэлгээний тулгуур асуудлын нэгдүгээрт иргэний эрхийн асуудал тавигддаг. Орон нутгийн түвшинд бол иргэдийн эрх ашгийг хэрхэн хангаж байгаа, орон нутагт ажиллаж амьдарч буй иргэд эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж байгаа эсэх тухай асуудал тулгуур шинжтэй болох бөгөөд энэ сэдэвт хамгийн эхэнд анхаарал хандуулах ёстой. Өнөөгийн даяаршсан нийгэмд, дэлхийн олон улс оронд иргэн хэмээх ойлголт ихээхэн өөрчлөгдөж, тэр дундаа иргэний харьяалалгүй, төрсний гэрчилгээгүй, бичиг баримтгүй дүрвэгсэд, орогнол хүсэгчид олон болсон нь үнэлгээний эхний шатанд судлах ёстой иргэний харьяаллын асуудлыг илүү төвөгтэй болгодог.

Ядуу, эмзэг бүлгийн, эрх мэдэл багатай иргэдээ нийгмээс гадуурхдаг улс оронд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх, иргэний харьяалал хэмээх түгээмэл ойлголтууд учир холбогдлоо алдах эрсдэл байдаг.²⁰ Тиймээс ОнАТБ үнэлгээний аргачлал нь иргэний харьяалал хэмээх ойлголтыг өргөн утгаар нь ашиглаж үүнийг орон нутгийн түвшинд хэрхэн тодорхойлдог, хэрэгжилт онолын хийгээд практик түвшинд ямар байгааг судлах зорилготой. Үүнд иргэний харьяаллын хууль эрх зүй, нийгэм, эдийн засаг, орон зайн хэмжээс талаас нь судлах ажил багтах бөгөөд нийгэм, эдийн засгийн хувьд аль нэг бүлгийг гадуурхах, угсаа гарвалаар ялгаварлах, ижил төстэй болон ялгаатай байдалд суурилсан зөрчил зэрэг ээдрээтэй асуудлыг нягтлан шалгах ажил мөн багтана.

Хайрцаг 2.4

Иргэн хэмээх ойлголт оролцооны утгаараа

Иргэний харьяалал хэмээх ойлголт нь ардчилсан нийгмийн гол цөм байдаг тул иргэн хэмээх ойлголтыг онолын бөгөөд практик түвшинд хэрхэн ойлгож, хэрэглэдгийг судлах, дүн шинжилгээ хийх нь чухал. Иргэний харьяалал хэмээх ойлголт нь ихэнх улс оронд маргаан дагуулсан ойлголт байдаг бөгөөд тухайн улсын соёл, ашиг сонирхол, үзэл суртал, хууль эрхзүйн тогтолцоо зэргээс хамаарч өөр өөр утга агуулгатай байдаг. Хэдийгээр улс орон бүрт тус ойлголт ялгаатай байдаг ч иргэний харьяалал гэдэгт нийгмийн шударга ёс, өөрийгөө тодорхойлох эрмэлзэл, хүмүүс хоорондын эв нэгдэл зэрэг түгээмэл үнэт зүйлс тодорхой хэмжээнд багтсан байдаг. Энэхүү ойлголт нь байгууллага, адилсал, хүмүүсийн өөрсдийн үйлдэл зэргийг хамарсан олон талт ойлголт юм.²¹ Харин явцуу утгаараа иргэншил, иргэний харьяалал хэмээх ойлголт нь үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тухайн улсын иргэншил авах шаардлага хангасан хүнийг хэлдэг. Энэ тодорхойлолт нь засгийн газраас авч хэрэгжүүлэх болон үл хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж байдаг. Иргэншил хэмээх ойлголтыг зөвхөн хууль, эрх зүйн өнцгөөс харсан нөхцөлд орон нутагт амьдарч буй иргэд, тэдний ардчилсан

Хайрцаг [үрг.]

нийгмийн нэг хэсэг, хууль ёсны дагуу эрх тэгш байх ёстой гэдгийг умартах эрсдэлтэй.

Энэхүү ОнАТБ үнэлгээний гарын авлагад “иргэн” хэмээх ойлголтыг илүү өргөн хүрээнд буюу амьдрах газар, бүртгэлтэй эсэх, цагаач эсэхээс үл хамааран орон нутагт амьдарч буй бүх хүмүүсийн иргэний эрх, түүнтэй холбоотой асуудлыг адил тэгш анхаарч үнэлэх утгаар хэрэглэсэн болно.

Ардчилсан улс орнуудын өмнө тулгардаг үндсэн асуудлуудын нэг бол өөрийн тус тусын хүрээнд амьдарч буй орон нутгийн иргэдэд шууд нөлөө үзүүлэх аливаа шийдвэр гаргах үйл явцад бүх иргэний бүрэн, үр нөлөө бүхий оролцоог бодитой хэрэгжүүлэх явдал юм. Тиймээс ардчиллын чанарт үнэлгээ хийх ажлын гол цөм нь тухайн улс, орон нутагт амьдарч буй иргэд нас, хүйс, үндэс угсаа, оршин суугаа газар, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг болон бусад онцлог байдлаас үл хамааран хүний эдлэх ёстой үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн утгаар нь эдэлж чадаж байгаа эсэхэд анхаарах ёстой. Тухайлбал, орон нутгийн түвшинд ардчиллын чанарт үнэлгээ хийж байгаа нөхцөлд (хууль бус) цагаач, дүрвэгсдийн асуудлыг орон нутагт хэрхэн шийдвэрлэж, эдгээр хүмүүстэй хэрхэн харьцаж байгааг нягтлан үзэх нь зүйтэй.

Ардчилсан нийгэм дэх эрх тэгш байдлын үнэлгээ нь иргэний эрх, улс төрийн эрх болон нийгэм-эдийн засгийн эрхийг хүндлэх, эдгээр эрхийн (үүнд нийгмийн тодорхой бүлгийн эрх мөн хамаарна) хэрэгжилтийг хангах хамгаалах ямар арга зам, механизм байгааг анхааран судлахад чиглэнэ. Үүнд: дээрх эрхийг эдлүүлэх, хамгаалахад төр засгийн өмнө тулгарч буй саад бэрхшээл юу байгаа, жишээлбэл, нутгийн уугуул иргэд, шилжин ирэгсэд, дүрвэгсэд, нутаг заагдсан хүмүүс гэх мэт нийгмийн цөөнхийн сонгох эрхийн хэрэгжилт гэх мэт. Эдгээр сорилт бэрхшээл нь ихэнх тохиолдолд иргэншил, оршин суух зөвшөөрөл гэх мэт хууль эрх зүйн болон захиргааны түвшинд өөрчлөлт хийхийг шаардсан асуудлууд байх бөгөөд энэ нь нутгийн удирдлагын байгууллагаас ийм эрх мэдэлтэй байхыг шаарддаг гэсэн үг юм.²²

Иргэд орон нутаг дахь ардчиллын чанар, төлөв байдалд зөв үнэлэлт дүгнэлт хийдэг, учир нь тэдний өдөр тутмын амьдралд иргэний, улс төрийн болон нийгэм, соёлын эрхийн хэрэгжилт тодорхой хэмжээнд нөлөө үзүүлдэг, түүнээс хамаарч байдаг.²³ Улс төр, иргэний эрх болон нийгэм, соёлын эрхийг аливаа улс үндэсний Үндсэн хууль эсвэл холбогдох бусад хуулиар баталгаажуулсан байдаг ч бодит амьдрал дээр эдгээр эрхийн хэрэгжилт ямар түвшинд байгааг гагцхүү орон нутгийн түвшинд харах боломжтой.

Иргэний болон улс төрийн эрхийн баталгаа гэдэгт аливаа иргэн өөрийн санаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусадтай хуваалцаж, эвлэлдэн нэгдэх, цуглах, шашны зан үйл гүйцэтгэх, сонгуульд саналаа өгөх эсвэл сонгогдох эрхээ ямар түвшинд эдэлж байгаа зэрэг хамаарна. Эдгээр эрх бол улс төрийн үйл явцад оролцох

оролцооны зайлшгүй нэг хэсэг байдаг бөгөөд тэр утгаараа ардчилсан хэв маягийн амьдралын салшгүй хэсэг мөн.

Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хэрэгжилтийг үнэлэх нь ардчиллын чанарын үнэлгээнд мөн чухал ач холбогдолтой. Тэр дундаа ардчиллыг зөвхөн институт, шийдвэр гаргах үйл явц гэж хардаг нийгмийн бүлгийн хувьд дээрх эрхийн хэрэгжилт чухал ач холбогдолтой. Бодит байдал дээр иргэний эрх, эрх чөлөө, улс төрийн эрхээ бүрэн эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, боловсрол эзэмших гэх мэт эдийн засаг, нийгэм соёлын эрхийг эхлээд эдлэх хэрэгтэй гэдэгтэй маргах хүн цөөхөн байх.

Эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, ус, ариун цэврийн байгууламж, аюулгүй байдал гэх мэт иргэдийн үндсэн хэрэгцээг хангах төрийн бүх үйлчилгээг орон нутгийн засаг захиргаа хариуцдаг ч санхүүгийн эх үүсвэр болон бодлогын түвшинд ихэнх тохиолдолд үндэсний засгийн газраас хараат байдаг тул иргэдийн эдийн засаг, нийгэм соёлын эрхийг хамгаалах боломж, эх үүсвэр дутмаг байдаг. Энэхүү үнэлгээний гол зорилго бол ардчиллын чанар хийгээд нийгэм, эдийн засгийн эрх хоорондын харилцааг судлахаас илүүтэй эдгээр эрхийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд тулгардаг бэрхшээл, сул тал, давуу талыг системтэйгээр судалж, үндэсний болон орон нутгийн түвшний бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардагдах мэдээлэл цуглуулах явдал юм.

Тэгш эрх, хамарсан иргэншил хэмээх ойлголтууд амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаагаас шалтгаалж, орон нутагт чухам нийгмийн аль бүлэг, нэгж эрхээ бүрэн эдэлж, эрх тэгш байдлыг хүртэж, хуулиар хамгаалуулж чадаж байгааг үнэлэх боломж бүрдэнэ.

Хууль дээдлэх ёс ба шударга ёс зэрэг нь ялангуяа зөрчил мөргөлдөөнтэй байсан, ардчилсан үйл явц эхлэлийн шатандаа байгаа улс орнуудад чухал ач холбогдолтой ойлголтууд юм. Учир нь тэдгээр улсад хүний эрхийн зөрчил, түүнтэй холбоотой шийдвэрлэх шаардлагатай олон асуудал тулгардаг. Хууль дээдлэх ёс бол ардчиллын үндэс, суурь юм. Хууль дээдлэх ёс, шударга байдлыг сахиулах нь зөвхөн норм, дүрэм журмыг баталж, танилцуулснаар амьдралд биелэлээ олохгүй. Хүний эрхийг дээдлэх, хамгаалах нь хүний хөгжлийн үндэс гэж үзэж онцгой ач холбогдол өгөх шаардлагатай.²⁴

Хууль дээдлэх ёс, шударга ёсны зарчмууд яригдах ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдийн эрхийн асуудал хөндөгдөх ба эмэгтэйчүүдийн хувьд эдгээр эрхийг эдлэх боломж харьцангуй бага байдаг. Цаашлаад өөр хоорондоо ялгаатай газар нутагт амьдарч байсан хүмүүс, эмэгтэйчүүд гэх мэт нийгмийн бүлгийн хувьд эрхээ эдлэх, хамгаалуулах нь олон саад бэрхшээлтэй тулгардаг. Иймээс хүйсийн ялгаатай байдлыг нарийн судалж ойлгох нь чухал ач холбогдолтой.

Тулгуур 2: Төлөөлөл бүхий, эзэх хариуцлагатай үйл явц, институц

Үнэлгээний хоёр дахь тулгуур бол орон нутгийн түвшинд ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг хамгаалахад чухал үүрэгтэй институц, үйл явцад хийх үнэлгээ бөгөөд ардчилсан үйл явц, институцын төлөөлөл чадвар, эгэх хариуцлагатай байх зарчимд үнэлгээ хийхэд чиглэнэ. Тиймээс орон нутгийн ардчиллын төлөв байдал, чанарын үнэлгээ нь орон нутгийн хөгжилд ардчилсан институцын оруулсан хувь нэмэр, иргэдийг төлөөлөл үүргээ хангалттай гүйцэтгэж байгаа эсэх, орон нутгийн засаг захиргаанд ажиллаж буй албан хаагчдын эгэх хариуцлага зэргийг нарийвчлан судлах, үнэлэх учиртай.

Үйл явц

Ардчилсан нийгмийн тогтолцоонд иргэд өөрийг нь тодорхой хугацаанд төлөөлөл улс төрийг сонгож, сонгуульд саналаа өгөх нь улс төрийн үйл явцад оролцох үндсэн хэлбэрийн нэг байдаг. Энэ нь иргэд өөрсдийн сонгосон улс төрч, төлөөлөгчид олон нийтийн өмнөөс шийдвэр гаргах, төрийн бодлогод хяналт тавих эрхийг олгож байгаа явдал юм. Тиймээс сонгууль бол иргэд ардчилсан улс төрийн үйл явцад оролцох боломжийг олгодог үндсэн платформ болдог.

Орон нутгийн сонгууль нь төрийн байгууллага, төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойрхон авчирдаг, орон нутгийн иргэдийн өмнө тулгарч буй асуудал, хэрэгцээ шаардлагыг ойлгох боломжийг төлөөлөгчид ойлгуулахад илүү хялбар гэдэг утгаараа илүү үр дүнтэй байдаг. Гэвч бодит байдал дээр улс төр, санхүүгийн болон засаг захиргааны эрх мэдлийн төвлөрлийг сааруулж чадсан эсэхээс орон нутгийн сонгууль үр нөлөөтэй, ач холбогдол өндөртэй байх эсэх нь шууд хамаарна.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, боломж сонгуулийн тогтолцооноос тодорхой хэмжээнд хамаардаг. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл дэлхий нийтээр бага байгаа өнөө цагт орон нутгийн болон үндэсний хэмжээнд шийдвэр гаргах үйл явц дахь хүйсийн тэнцвэрт бус байдлыг арилгахад чиглэсэн олон нааштай санаачилга хэрэгжүүлж байгаагийн нэг бол сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг хуульчлан баталгаажуулах явдал юм. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог хангах, шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэнцвэрт байдлыг хангах гурван төрлийн квот байдаг ба эдгээр нь жагсаалтаар сонгогдох эмэгтэйчүүдийн хувь, хуулийн дагуу сонгуульд нэр дэвшигчдийн дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувь, улс төрийн намын гишүүдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь юм (ихэнхдээ сайн дурын үндсэн дээр).²⁵

Үүний нэгэн адилаар сонгуулийн тогтолцоо нь нийгмийн цөөнх, эмзэг бүлгийн төлөөллийн хэрэгцээ, шаардлагыг тусгасан, нөлөөлөхүйц байх учиртай. Орон нутгийн сонгуулийн хуулийн холбогдох заалтад цөөнхийн бүлэг, сөрөг хүчний намын төлөөлөлд зориулсан босго зэргийг багтаах нь зүйтэй.

Ардчилсан нийгэмд иргэдийн оролцоог институцын хэлбэрт оруулснаар бодлого боловсруулах, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх гэх мэт бүхий л үйл явцад иргэд чухал үүрэгтэй оролцож, хөгжлийн бодлогын талаар өөрсдийн үзэл бодол, сонголтыг илэрхийлэх боломжтой байдаг. Ийнхүү институцжсэн хэлбэрт шилжсэнээр иргэдийн төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, эгэх хариуцлагад тавих хяналт сайжирч, үүний дүнд төрөөс үзүүлдэг үйлчилгээ иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, шуурхай болж эхэлдэг. Үүнд харилцан зөвшилцөх замаар засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, төсөв боловсруулах зэрэг үйл ажиллагаа багтахаас гадна шууд ардчиллын²⁶ нэг хэлбэр болох санал хураалт явуулах, иргэдийн санаачилгыг дэмжих, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэй уялдан гарч ирсэн цахим ардчиллын хэлбэрүүд мөн багтана. Төрийн байгууллагууд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэдийн үзэл бодол, ашиг сонирхлыг судалж болно. Институцчилсан иргэдийн оролцоо гэдэгт зөвлөлдөх уулзалт, сонсгол, хороо, иргэдийн оролцоотой төсөв зэрэг иргэдтэй зөвлөлдөх тэдний санаа бодлыг тусгах олон арга хэлбэр багтана.

Гэхдээ иргэдийн оролцоог институцчилэх нь зарим тохиолдолд төдийлөн үр дүнд хүрдэггүй, зайлшгүй хамруулах ёстой орон нутгийн жинхэнэ иргэдийг бус, цөөн тооны байгууллагын оролцоог дэмжих тохиолдол байдаг. Жишээлбэл, орон нутгийн засаг захиргаанаас албан ёсоор зохион байгуулдаг хэлэлцүүлэг, мэтгэлцээнд зөвхөн хэсэг бүлэг хүмүүс эсвэл орон нутгийн тодорхой хэдэн байгууллагыг хамруулдаг. Иргэд ч энэ төрлийн хэлэлцүүлэг, мэтгэлцээний талаар төдийлөн ойлголтгүй байдгаас гадна албан бус байдлаар зохион байгуулсан уулзалт, арга хэмжээнд илүү түлхүү оролцох сонирхолтой байдаг ажээ (Тулгуур 3 харах).

Институцууд

Ихэнх улс оронд улс төрийн эрх мэдлийг орон нутгийн түвшинд гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлдэг.

Улс төрийн эрх мэдэл хэрэгжүүлэгч байгууллага нь бүсийн болон орон нутгийн түвшинд дараах бүтэцтэй байдаг: гүйцэтгэх эрх мэдэл хэрэгжүүлэгч (захиргааны) нь аймаг, орон нутгийн захирагч, засаг дарга, хууль тогтоох эрх мэдэл хэрэгжүүлэгч нь орон нутгийн парламент, зөвлөл байдаг.²⁷ Хууль сахиулах алба буюу цэрэг, цагдаа, зэвсэгт хүчний байгууллагууд нь ихэнх тохиолдолд гүйцэтгэх эрх мэдэл хэрэгжүүлэгч институцын харьяанд үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагуудын эрх үүрэг, хариуцлагыг холбогдох хууль, тогтоомжинд тусгайлан заасан байдаг ч тэдгээрийн хэрэгжилт ямар түвшинд байгаа, иргэдийн хүлээлт, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа, иргэдийн хүсэл сонирхлыг хангалттай түвшинд төлөөлж, эгэх хариуцлагатай хандаж байгаа эсэхийг гагцхүү бодит байдал харуулна. Улс төрийн эдгээр институцын үйл ажиллагаанд орон нутгийн шүүх байгууллага болон зөрчил, мөргөлдөөнийг орон нутгийн түвшинд

шийддэг бусад байгууллага дэмжлэг үзүүлэх бөгөөд эдгээр байгууллага нь эрүүгийн хэрэг, хүчирхийлэл, зөрчил, маргааныг аль болох хүч хэрэглэхгүй, аль нэг талыг илт хамгаалахгүй, бие даасан, хараат бус байдлаар шийдвэрлэх үүрэгтэй (Тулгуур 1 – Хууль дээдлэх ёс гэсэн хэсэгт багтсан). Дээр дурдсан хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай хамтран эдгээр байгууллага нь орон нутагт эрх мэдлийн тэгш хуваарилалт, хүчний тэнцвэрт байдлыг хангах институцыг бий болгодог. Мөн түүнчлэн, зэвсэгт хүчний үйл ажиллагаанд иргэний хяналт тавих үүргийг гүйцэтгэдэг.

Үйл ажиллагаа нь жигдэрсэн, нэр хүндтэй улс төрийн нам орон нутгийн ардчиллын хөгжлийн салшгүй нэг хэсэг байдаг. Угтаа улс төрийн намууд орон нутаг дахь иргэдийн ижил төстэй үзэл бодол, ашиг сонирхлыг төлөөлөх, тэдгээр иргэдийг нэгтгэж, үзэл бодол, санаа бодлыг нь орон нутгийн бодлого, хөтөлбөрт тусгуулахад голлон анхаарах учиртай. Улс төрийн намын орон нутаг дахь төлөөлөл бол намын үндэсний хэмжээний бодлого, үйл ажиллагааны үндсийг бий болгодог гол тулгуур юм. Сонгуулийн кампанит ажлын үеэр сонгогчидтой харилцах, нэр дэвшигчдийг сонгох, шинэ гишүүн элсүүлэх, төрийн албанд ажиллах намын гишүүдээ мэргэшүүлэх, үндэсний болон орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулах зэрэг чухал үүрэг, хариуцлагыг намын орон нутаг дахь салбар хүлээдэг. Улс төрийн намууд иргэд, сонгогчидтой харилцах, тэдний санаа бодлыг сонсох, шуурхай хандах тал дээр харилцан адилаар байдаг.

Улс төрийн намын төлөөлөл байхгүй, эсвэл идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй орон нутагт улс төрийн байгууллагын өөр хэлбэр, үйл ажиллагаа идэвхжиж эхэлдэг. Үүнд улс төрийн бүлэглэлүүд, эсвэл зэрэг албан ёсоор улс төрийн намын хэлбэрт шилжээгүй боловч улс төрд өөрсдийн төлөөллийг оруулахад голлон анхаарч ажилладаг.

Орон нутгийн түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг улс төрийн институцууд байгаа нь эдгээр институцын үйл ажиллагаа нь ардчилсан зарчмын дагуу явагдаж, ардчилсан үр дүн авчирна гэсэн үг биш юм. Улс төрийн институцын үйл ажиллагаа ардчилсан байх нь улс төрийн тогтолцоо, сонгууль, төвлөрлийг сааруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчин, улс төрийн намын хууль, дотоод дүрэм журам, нөөц бололцоо, эерэг ба сөрөг гадны нөлөөлөл, чадавх, эмзэг нийгмийн бүлгийн асуудал, хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Сонгуульд нэр дэвшигч иргэд, сонгогчидтой хувийн шугамаар харилцах нь зарим тохиолдолд иргэд, сонгогчдын итгэлийг олж авахад илүү хялбар болгодгоос гадна тэдний өмнө тулгарч буй асуудал, хэрэгцээ шаардлагыг ойлгоход тусалдаг. Хэдий тийм боловч зарим тохиолдолд энэ нь сонгуулийн кампанит ажлыг ивээн тэтгэх сүлжээ үүсгэх буюу хүчирхийллийг өдөөж болдог. Энэ асуудал орон нутагт төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад байгууллагуудад ч мөн хамаатай. Үүнд орон нутгийн зөвлөлийн гишүүд, захирагч, шүүгч, цагдаагийн ажилтан, улс төрийн намын дарга гэх мэт төрийн албан хаагчид бүгд хамаарна. Энэ нь төрийн албан хаагчдын

ард, нийтийн өмнө хүлээсэн эрх үүргийн шударга, нэгдмэл байдлыг хангахтай шууд холбоотой асуудал юм. Олон нийтийн шударга байдал бол хээл хахууль өгөх, сонгуульд ивээн тэтгэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ашиг хонжоо хөөх зэрэг олон асуудалтай холбоотой бөгөөд орон нутгийн ардчиллын хөгжилд төрийн албан хаагчид итгэх иргэдийн итгэл чухал байр суурь эзэлдэг.²⁸

Орон нутгийн засгийн газрыг уламжлалт болон орчин үеийн институцын аль алинд нь шигтгэх боломжтой. Орон нутгийн ардчиллын хөгжилд нөлөө үзүүлдэг институц бол уламжлалт, заншлын болон шашны байгууллага байдаг. Тэр дундаа тухайн орон нутгийн тодорхой нэг бүлэг, уугуул иргэд, консерватив нийгмийн бүлэгт хамаарах уламжлал, заншлын болон шашны байгууллага чухал үүрэгтэй. Зарим улсад уламжлалт, заншлын институцууд бараг үгүй болж, орон нутгийн ардчиллын хөгжилд нөлөөлөхгүй болсон байхад зарим оронд шинэ нийгэм, улс төрийн нөхцөл байдалд зохицож, хувьсан өөрчлөгдсөн ч орон нутгийн иргэдийн дунд нөлөөтэй, хүчтэй хэвээр үлдсэн уламжлалт институцууд байдаг.

Уламжлалт, заншлын институцууд нь ихэнхдээ албан бус зохион байгуулалттай байж болох ч орон нутгийн засгийн газрын нэг хэсэг байх тохиолдол ч байдаг. Засгийн газрын бүтцэд эдгээр шашны болон заншлын байгууллага багтсан нөхцөлд орчин үеийн болон уламжлалт шинж чанар хоорондын ялгаа багасч, шашны удирдагч, тухайн орон нутгийг төлөөлөх улс төрч болох тохиолдол байна.

Гэхдээ уламжлалт буюу заншлын институц, орчин цагийн ардчилсан засаглалын институцтэй нэгдэх үйл явц зарим тохиолдолд тогтворгүй байдал бий болгодог.³⁰ Жишээлбэл, уламжлалт институцууд орон нутгийн хөгжлийг сааруулж, үндэстэн ястны хоорондын тэмцлийг даамжруулж, эмэгтэйчүүд, үндэстэн ястны цөөнх, шашны бүлгийн төлөөллийг улс төрийн үйл явцад оролцуулахгүй хязгаарлах гэх мэт. Гэхдээ уламжлалт институцууд иргэдийн дунд мэдээлэл солилцох, хуваалцах, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх зэрэг эерэг үр дүн бүхий үйл ажиллагаа явуулах платформ болох тохиолдол ч бий.

Орон нутгийн институцууд орчин цагийн, уламжлалт, шашны институцын аль нь ч байсан эмэгтэй, эрэгтэй, залуу болон ахмад настнууд, үндэсний цөөнх, нийгмийн эмзэг бүлэгт бүгдэд нь адил тэгш хандаж, төрийн үйлчилгээг хүргэдэг байх нь чухал.

Тулгуур 3: Иргэдийн санаачилга, оролцоо

ОнАТБ үнэлгээний гурав дахь гол тулгуур бол иргэдийн идэвхтэй оролцоог хангах механизм, сувгийг тодорхойлох явдал юм. Үнэлгээний хоёр дахь тулгуурын хүрээнд иргэдийн улс төрийн идэвх, оролцоог хангах, нэмэгдүүлэхэд ардчилсан институц, үйл явцын үзүүлэх үр нөлөө, үүрэг хариуцлагыг судалсан бол энэ тулгуур асуудлын хүрээнд ардчилсан нийгэм, улс төрийн үйл явцад оролцох, иргэний эрх үүргээ биелүүлэхэд чиглэсэн иргэдийн зүгээс гаргах идэвх, санаачилгад үнэлгээ хийх юм.

Идэвхтэй иргэн, иргэншил хэмээх ойлголт нь юуны түрүүнд иргэд ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагаа хуулийн дагуу хамгаалуулах, эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, зохион байгуулалтад орох эрхтэй байхыг шаарддаг (Тулгуур 1 авч үзсэн). Энэ асуудал өөрсдийн онцлог шинж байдлын улмаас эрх ашиг, хэрэгцээ шаардлагаа хамгаалуулах боломжгүй нөхцөлд орсон нийгмийн цөөнхийг бүрдүүлэгч этгээдүүдэд илүү хамааралтай юм. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хамгаалах явдал ихэнх улс оронд хуулиар баталгаажсан байдаг. Гэвч хуулиар баталгаажсан энэхүү эрх, эрх чөлөөг дээдлэх, хамгаалах асуудал амьдрал дээр, иргэд хоорондын болон иргэд, орон нутгийн засаг захиргаа хооронд үүсдэг өдөр тутмын харилцааны явцад жинхэнэ утгаар биелэлээ олж байх ёстой. Өөрөөр хэлбэл, иргэн, орон нутгийн байгууллага хоорондын харилцааны босоо тогтолцоо, иргэд хоорондын хэвтээ харилцааны явцад иргэдийн эрх, эрх чөлөөг дээдлэх, хамгаалах асуудал биелэлээ олдог.

“Жинхэнэ утгаараа ардчилал гэдэг бол төрийн үйл хэрэгт иргэд оролцож, төр нь иргэн бүрт адил тэгш хандахыг хэлдэг. Тогтсон хугацаанд сонгууль зохион байгуулах нь төр, иргэн хоорондын харилцаа, харилцан ойлголцлыг илүү хөгжүүлэх хамгийн боломжит үйл явц байдаг. Гэхдээ мэдээж ардчиллыг илүү дэлгэрүүлэхийн тулд зөвхөн сонгуулийн үеэр бус бусад үед иргэн, ардчилсан нийгэм хоорондын харилцааг улам сайжруулах алхмуудыг хийх нь зүйтэй.”

*Бэнжамин Голдфранк*³¹

Иргэд нийгмийн харилцаанд идэвх, санаачилгатай оролцох нь ардчилсан үйл явцыг орон нутгийн түвшинд илүү бодитой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл, бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг байх бөгөөд ардчилсан институцын мөн чанар иргэдийн эрх, эрх чөлөөг хэрхэн дээдлэн хамгаалж байгаагаас шууд шалтгаалдаг.³² Тэр утгаараа иргэдийн идэвхтэй оролцоо гэдэг ямар түвшинд нөлөө үзүүлэх эсэхээс үл хамааран ардчиллын хөгжил, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Орон нутгийн үйл хэрэгт иргэдийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх, үр дүнтэй байлгахын тулд юуны өмнө иргэдийг мэдээлэл авах, шийдвэр гаргагч этгээд болон шийдвэр гаргах үйл явцын талаар мэдээлэлтэй болох боломжоор хангах нь чухал. Одоо цагт иргэд хотын төв талбай, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт олон нийтийн газарт цуглахаас гадна мэдээллийн технологи ашиглан цахим хэлэлцүүлэг, уулзалтаар дамжуулан харилцан санаа бодлоо солилцдог болжээ.

Иргэдийн идэвхтэй оролцоог илэрхийлэх дараах хэлбэрүүд байдаг:

- Сайн дурын оролцоо;
- Иргэний нийгмийн үйл ажиллагаа;
- Гудамжны эсэргүүцэл;
- Үнэ төлбөргүй үйлчилгээ;
- Төрийн бус зөвлөлдөх форум;
- Интернэт платформ;
- Иргэний хөдөлгөөн;
- Өргөдөл, нэхэмжлэх гаргах (Гарын үсэг цуглуулах);
- Нийтийн кампанит ажил.

Иргэдийн оролцоо, улс төрийн идэвхтэй үйл ажиллагааны дээрх хэлбэрүүдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, бүх нийтийн эсэргүүцэл зохион байгуулах нэгдэх гэх мэт мөн багтана. Иргэдийн идэвх, оролцооны эдгээр хэлбэрүүд нь орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, хувийн салбар болон хөгжлийн дэмжлэг үзүүлдэг байгууллагуудын дэмжлэгийг шаарддаг.

Иргэний нийгмийн байгууллага болон бусад бүх төрлийн сайн дурын байгууллагын сүлжээ нь иргэдийн ашиг сонирхлоо хамгаалах, орон нутгийн хөгжлийн бодлогод нөлөөлөх байдлаар төрийн байгууллагатай динамик харилцаа холбоо тогтоох, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Орон нутгийн түвшинд эдгээр байгууллагуудын сүлжээ идэвхтэй байх нь орон нутгийн захиргааны үйл ажиллагааны хариу шуурхай байдлыг хангах, иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн төрийн үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэхэд хяналт тавихад мөн чухал ач холбогдолтой.³³

Иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг илүү хүчтэй илэрхийлдэг иргэний хөдөлгөөн энэ утгаараа орон нутгийн түвшинд чухал үүрэг гүйцэтгэнэ. Иргэний хөдөлгөөн зарим тохиолдолд улс төрийн намын үйл ажиллагаатай адил түвшинд байдаг бол зарим тохиолдолд газрын эзэд, мал аж ахуй, газар тариалан эрхлэгчид, бизнесийн ашиг сонирхлоор нэгдэгсэд, хүчирхэг элит гэр бүл зэрэг орон нутгийн түвшинд нөлөө бүхий, эрх мэдэлтэй хэсэг бүлэг хүмүүсийн орон нутгийн иргэдийн ашиг сонирхол, дуу хоолойг төлөөлсөн тэмцэл, хөдөлгөөний хэлбэрээр илэрдэг.

Бүх нийтийн оролцоо гэдэг бол иргэд, олон нийтийн өмнөөс шийдвэр гаргаж, тэдний өмнөөс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, удирдаж буй удирдагчдад хяналт тавихад чиглэсэн иргэдийн хичээл зүтгэл, оролдлого юм. Гэхдээ иргэд гагцхүү хангалттай сайн мэдээлэлтэй байгаа нөхцөлд улс төрийн үйл хэрэгт идэвхтэй оролцож чадна. Тиймээс иргэд мэдээ, мэдээлэл авах эрхээр хангагдсан эсэх, эрхтэй бол шаардлагатай мэдээ, мэдээллээ олж авч чаддаг эсэх нь ардчиллын чанарт үнэлгээ хийхэд зайлшгүй анхаарах ёстой үзүүлэлт болдог.

Бие даасан, олон талын үзэл бодол, байр суурийг тэнцвэртэйгээр илэрхийлж чаддаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл (үүнд хэвлэмэл, өргөн

нийгэд тархсан нэвтрүүлэг, цахим мэдээллийн хэрэгсэл багтана) нь олон нийтийн оролцоог дэмжих чухал платформ байх боломжтойн дээр мэдээлэл хуваалцах хамгийн тохиромжтой хэрэгсэл юм. Нийгмийн “хоточ нохой” гэгддэг хараат бус сэтгүүлчид бол орон нутгийн засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чухал үүрэгтэй бөгөөд ардчиллын сул тал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны доголдол, сонгуулийн булхай, хээл хахууль гэх мэт нийгмийн сөрөг үзэгдлийг нийгэд ил болгоход голлох үүрэгтэй билээ. Гэвч бодит байдал дээр дэлхийн олон оронд хэвлэл мэдээллийн хэрэгсэл жинхэнэ утгаараа бие даасан, хараат бус эсвэл нийгмийн бүх хэсэгт хүрч чаддаггүй билээ. Тиймээс нийгмийн бүх хэсэг, бүлэгт хүрдэг орон нутгийн болон олон улсын мэдээ, мэдээллийн ямар суваг байдгийг тодорхойлох, хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан, хараат бус байдал ямар түвшинд байгааг судлах нь чухал ач холбогдолтой.

Өнгөрөгч хэдэн жилийн хугацаанд гар утасны технологи, тэр дундаа нийгмийн сүлжээ иргэдэд үзэл бодлоо шууд илэрхийлэх боломжийг олгож эхэллээ. Эдгээр арга хэрэгсэл нь зөвхөн мэдээлэл хүлээн авдаг, идэвхгүй нэгэн байсан иргэдийн хувьд үзэл бодлоо шуурхай илэрхийлэх боломж олгож байгаа учир үнэлж баршгүй ач тустай. Гэхдээ нийгмийн сүлжээ, цахим хэлэлцүүлгийн үеэр яригдсан аливаа асуудал бодлого боловсруулагчдад шууд нөлөөлнө гэж хэлэх боломжгүй бөгөөд аливаа зөрчил, мөргөлдөөнийг эхлүүлэх шалтаг, хэрэгсэл байж таарахгүй. Нийгмийн сүлжээ орон нутгийн иргэдэд улс төрийн ашиг сонирхол, үзэл бодлоо чөлөөтэй, шуурхай илэрхийлэх боломжийг нээж өгснөөс гадна үзэл бодлоо хилийн чанадад ч илэрхийлэх боломжийг олгож байна.

Хайрцаг 2.5

Оролцоонд суурилсан ардчилал – Кап Хайтиен хот

Хойд Гайтигийн удирдах газарт 2010 онд хийсэн ардчиллын үнэлгээгээр ОнАТБ, оролцоонд суурилсан ардчиллын давуу болон сул талуудыг дараах байдлаар тодорхойлжээ

СУЛ ТАЛ	ДАВУУ ТАЛ
<ul style="list-style-type: none"> • Шашны удирдагч, иргэний нийгмийн байгууллага, хувийн салбар гэх мэт үндсэн тоглогчидтой албан ёсны зөвлөлдөх үйл явц гэж байхгүй. • Шийдвэр гаргах үйл явцад залуучууд, эмэгтэйчүүд болон нийгмийн бусад эмзэг бүлгийн оролцоог дэмжих бодлого байхгүй. • Иргэний нийгмийн байгууллага хооронд эв нэгдэл муутай • Тогтмол хийдэг уулзалт байхгүй • Нийтийн байгууллагуудыг улс төрийн зорилгоор ялангуяа сонгуулийн үеэр ашигладаг • Олон улсын байгууллагуудын оролцоо их • Сонгогдсон албан тушаалтныг сонсох хүсэл сонирхол байхгүй, нээлттэй бус • Шийдвэр гаргах үйл явцад сөрөг хүчний оролцоо байхгүй • Хотын захирагч иргэдтэйгээ ойр бус, хүлээн авдаггүй • Төрийн байгууллагын ил тод байдал хангалтгүй • Захирагчийн ажлын алба нь бусад газруудтайгаа бараг хамтарч ажилладаггүй, • Захирагчийн ажлын алба, Худалдаа аж үйлдвэрийн танхим хоорондын харилцаа муу • Иргэдээс ирэх санал гомдлыг хүлээн авах шийдвэрлэх албан ёсны тогтолцоо байхгүй • Төр, хувийн хэвшлийн түншлэлийн туршлага багатай, байгааа цөөн тооны түншлэл үр дүн, удирдлага муутай • Нийтийн ба орон нутгийн ТББ хооронд хамтын ажиллагаа байхгүй, зөвхөн нийтийн ба олон улсын ТББ хооронд идэвхтэй харилцаа байдаг • Иргэдийг нэгтгэх, нэг хүч болгох чадвар байхгүй 	<ul style="list-style-type: none"> • ИНБ-ын төлөөлөл, сүлжээ өргөн • Хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд сүмийн гүйцэтгэх үүрэг, оролцоо их, сүм – орон нутгийн захиргааны төлөөллөөс бүрдсэн хороотой • Орон нутгийн түвшинд нөлөөтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг, орон нутагт болж буй бүх асуудлыг хамарч, нийтэд мэдээлдэг • Хэвлэл мэдээллийг төрөөс удирдах нь бага, улс төрийн намын нөлөө байхгүй • Нийтийг хамарсан асуудалд ТББ-ын үүрэг, оролцоо, нөлөө их • Гадаадын санхүүгийн ивээн тэтгэгчдийн нөлөө их • Сөрөг хүчний нам байр сууриа чөлөөтэй илэрхийлдэг • Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдтэй мэдээлэл хуваалцдаг • Цахим хуудсаар дамжуулан төрийн байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх оролдлого хийгдсэн, сонгогдсоноос хойш эхний 100 хоногт хийсэн ажлын тайлан гаргах гэх мэт • Олон улсын ТББ-ын зүгээс талуудын хооронд диалог бий болгохыг оролддог • Иргэдийн оролцоо, санаачилгад суурилсан төлөвлөлтийг амжилттай хийсэн туршлагатай • Иргэний нийгэм үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үйл ажиллагаа явуулах боломжоор бүрэн хангагдсан

2.4. Салбар хоорондын асуудал

Дээр дурдсан гурван тулгуур асуудалд дүн шинжилгээ хийснээр ардчиллын төлөв байдлын үнэлгээний хүрээний ерөнхий загвар бий болох боловч дараах асуудлуудыг мөн анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Хүйсийн тэгш байдал;
- Нийгмийн нягтрал, ялгаатай байдал;
- Зөрчил, аюулгүй байдал;
- Ардчилал ба хөгжил.

Эдгээр асуудлыг доор хураангуйлан тайлбарласан болно.

Хүйсийн тэгш байдал

Эмэгтэй, эрэгтэй хүйсийн тэгш байдал гэдэг³⁶ нь ардчиллын хөгжлийн салшгүй хэсэг бөгөөд төрийн байгууллага орон нутгийн түвшинд олон нийтийг төлөөлж, шуурхай хариуцлагатай ажиллаж чадах эсэхийг илтгэх урьдчилсан нөхцөл болдог. Тиймээс шийдвэр гаргах үйл явцад хүйсийн бүх хэлбэрийг төлөөлөх нийгмийн бүлгийг оролцуулах нь чухал. Юуны өмнө энэ нь ардчиллын үндсэн эрх, эрх чөлөө байдаг бол хоёрдугаарт, орон нутгийн бодлого, хөтөлбөр нь сонгогчдын эрх ашгийг хамгаалж, хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэж байдаг. Тиймээс орон нутгийн түвшинд ардчиллын үнэлгээ хийх явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн улс төрийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог судлах, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн (жишээлбэл эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртэгчийн хувиар) үр нөлөө эмэгтэй, эрэгтэй иргэдэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх нь чухал ач холбогдолтой.

Орон нутгийн захиргаа, төрийн байгууллага бол эмэгтэйчүүдийн улс төрд орох хамгийн ойр, тохиромжтой эхлэлийн цэг гэж хүмүүс ойлгодог. Учир нь эмэгтэйчүүд илүү дээд түвшинд улс төрд оролцох, төрийн албан тушаалд өрсөлдөх нь гэр бүлээсээ хол байх цаг хугацаа, кампанит ажилд зарцуулах хөрөнгө мөнгө гэх мэт асуудлаас гадна улс төрийн өрсөлдөөнд орж байсан туршлага, нам дотроос нэр дэвшигчидтэй өрсөлдөх чадвар гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалсан хязгаарлалтууд байдаг.³⁷ Гэхдээ орон нутгийн түвшинд эмэгтэйчүүд улс төрд оролцоход бүтцийн шинж чанартай хүчин зүйлс, хүйсийн ялгаатай байдал зэргээс үүдэлтэй олон саад бэрхшээл тулгардаг. Үүнд:³⁸

- Эрэгтэй, эмэгтэй хүйсийн хоорондын хүчний тэнцвэрт бус байдал;
- Хувийн болон төрийн байгууллагад хүчтэй хэвээр байгаа жендерийн хэвшмэл үзэл;
- Нийгэм, эдийн засгийн байдал, орлогын тэгш бус байдал;
- Нийгмийн идэвхгүй байдал;
- Эцгийн эрхэт нийгмийн байгуулал;
- Хуулиар олгогдсон эрх, бодит байдал дахь боломж хоорондын зөрүү;
- Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт;
- Бичиг үсэг тайлагдалт, боловсролын байдал дахь хүйсийн ялгаатай байдал;
- Улс төрийн нам дотор амжилт олох боломж эмэгтэй, эрэгтэй гишүүдэд тэгш бус; санхүүгийн болон бусад хөдлөх хөрөнгө эзэмших боломж байхгүй;
- Хүйсийн тэнцвэрт байдлыг дэмжих төрийн бодлого сул.

Эдгээр саад бэрхшээлийн улмаас төрийн болон хувийн салбарт жендерт суурилсан ялгаварлан гадуурхалт байсаар байна.

Хайрцаг 2.6

Орон нутгийн засгийн газар дахь эмэгтэйчүүд-Дэлхийн тунхаг

Энэ тунхгийг 1998 онд баталсан бөгөөд³⁹ энэ баримт бичигт “орон нутгийн засаг захиргаа бол үндэсний засгийн газрын нэг хэсэг бөгөөд олон нийтгүй хамгийн ойр байдаг нэгж юм. Тиймээс орон нутагт тогтвортой хөгжлийг хангахын тулд эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг ашиглан, тэднийг орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад оролцуулах нь хамгийн зөв сонголт” гэж тэмдэглэсэн байдаг.”

Нийгмийн нягтрал, ялгаатай байдал

Нийгмийн нягтрал, ялгаатай байдал хэмээх ойлголтууд нь орон нутгийн ардчиллын хөгжилд чухал ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсгүүд бөгөөд тэр дундаа тухайн улсын иргэн бус, гадны цагаач хүн ам олноор хил орчмын газар болон томоохон хотуудад суурьшсан байдгийг харгалзан үзэхэд нэн чухал болно.

Олон улс оронд улс төрийн байгуулал, дэглэм өөрчлөгдөж, ардчиллыг шинээр болон сэргээн босгох үйл явц өрнөсний дүнд өөр хоорондоо ялгаатай нийгмийн олон бүлэг улс орны нийт хүн амыг бүрдүүлэх болжээ. Нийгмийн бүлэг хоорондын ялгаатай шинж байдал хэмээх ойлголт нь нэг талаас шашин, үндэс угсаа, хүйс болон бэлгийн чиг хандлага, хэл, соёл, үүрэг хариуцлага, нас, нийгмийн анги давхарга, газар зүйн байршлын хувьд ялгаатай хүн амын онцлог байдлыг илэрхийлдэг бол нөгөө утгаараа орон нутгийн засаг захиргааны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын талаар нийгмийн бүлэг бүр өөр ойлголт, төсөөлөл, хүлээлттэй байх тэрхүү ялгааг мөн илэрхийлдэг. Судалгааны үр дүнгээс харахад өөр хоорондоо ялгаатай нийгмийн

бүлэг ихтэй улсад дотоодын зөрчил, үл ойлголцол гарах магадлал илүү өндөр, сорилт бэрхшээл илүү их тулгардаг гэсэн дүн байдаг.⁴⁰ Нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлын улмаас шинэ, эрчээ авсан цагаачдын урсгал, нутгаа орхин дүрвэсэн үндэсний болон шашны цөөнх, дүрвэгсэд улс үндэстнүүдийн хүн ам зүйн бүтцэд нөлөөлж, өөрчлөх чиг хандлага ажиглагдах болсноос гадна орон нутгийн түвшинд ардчиллыг хөгжүүлэх үйл явцад шинэ сорилт бэрхшээлийг бий болгож эхэлсэн юм.

Үүнд захиргааны болон үзэд бодлын зөрүүтэй байдлаас үүсэх сорилт бэрхшээлийн аль аль нь багтах бөгөөд энэхүү сорилт бэрхшээлийг даван туулах нь улс орнуудын хувьд зөвхөн аливаа зөрчил, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх бус шударга, хүртээмжтэй байх ардчилсан нийгмийн үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс ОнАТБ үнэлгээ хийхэд хүртээмжтэй, олныг хамарсан, олон соёл, иргэншлийг өөртөө багтаасан ардчилсан үйл явцыг онцгойлон авч үзэх, улмаар холбогдох мэдээллийг боломжит түвшинд дэлгэрэнгүй цуглуулж, тайлагнах, өөр хоорондоо ялгаатай нийгмийн бүлгийн хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг сонсож, шуурхай ажиллах орон нутгийн бодлого боловсруулахыг дэмжихэд тусгайлан анхаарах ёстой.

Хайрцаг 2.7

Мэдээллийг дэлгэрүүлэх: Сэрэмжлүүлэх тайлбар

Нийгмийн цөөнх, тусгааарлагдсан бүлгийн яс үндэс, нийгмийн давхарга, шашин шүтлэгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх нь тухайн нийгмийн бүлэг ямар шалтгааны улмаас ялгаварлан гадуурхалтад өртсөнийг тодорхойлох боломжийг олгодог. Ихэнх тохиолдолд нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байж тэдний талаар олон нийтэд мэдээлэх, ил болгох боломж бүрдэнэ. Ийм мэдээлэл байхгүй нөхцөлд нийгмийн цөөнх, эмзэг бүлгийн хэрэгцээ, шаардлагыг үл анхаарсан, нийгмийн олонх хэсгийн хэрэгцээнд үндэслэсэн бодлого, хөтөлбөр боловсруулах эрсдэл нэмэгдэнэ. Хоёр талдаа иртэй хутга гэдэг шиг энэ төрлийн мэдээллийг төрийн эрх барьж буй субъект буруу ашиглан, нийгмийн цөөнхийг шахан зайлуулах, илүү гадуурхах бодлого явуулж, нөхцөл байдлыг улам хурцатгах эрсдэл бас бий. Үндэс угсаа, шашин шүтлэг, уламжлалд суурилсан бодлого боловсруулах үйл явц нь иргэдийн тэгш оролцоог хангахад чухал үүрэгтэй боловч хэт үндсэрхэгжих, нутгархах үзэл, бодлогыг мөн дэлгэрүүлэх аюултай. Цаашлаад нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн бүлэгт хамаарах иргэд өөрсдөө энэ бүлэгт хамаарч байгаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Нийгмийн эмзэг бүлэг, цөөнхөд хамаарахгүй гэж өөрийгөө дүгнэх хүн гарч болох бөгөөд энэ нь зүйн хэрэг юм. Тиймээс үнэлгээ хийж буй багийн гишүүд нас, хүйс зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн хүн ам зүйн онцлог шинжээс бусад онцлог шинж байдлын талаар судлах, мэдээлэл ашиглах, иргэдтэй ярилцах явцдаа үргэлж анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үнэлгээний явцад цуглуулсан мэдээллийг ашиглах, дэлгэрүүлэх нь хэр эрсдэлтэй болох, давуу тал нь сул тал, эрсдлээс их байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй.

Нийгмийн бүлэг хоорондын нэгдмэл байдал хийгээд онцлог шинж байдлыг хэрхэн зөв томъёолох, зөв зохицлыг бий болгох энгийн, хялбар арга зам, бэлэн хариулт байхгүй бөгөөд ардчилсан улс орон бүр энэ асуудлыг өөр өөрийн замаар шийдвэрлэдэг. Ихэнх улс орон нийгмийн тодорхой бүлэг хүн амыг ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглосон байдаг бөгөөд улс төр, эдийн засаг, иргэний эрхийг баталгаажуулсан байдаг. Гэвч хуулиар баталгаажсан эдгээр эрх, эрх чөлөө бодит байдалд хэрхэн хэрэгжиж, эрх зүйн орчныг хэрхэн тайлбарлаж, хүний эрхийг хэрхэн хүндэлж байгааг үнэлэх шаардлага байсаар байна.

Зөрчил, аюулгүй байдал

Бүлэг 2.2- т дэлгэрэнгүй тайлбарласны нэгэн адилаар орон нутгийн түвшинд ардчиллын хөгжлийг дэмжихэд иргэдийн аюулгүй асуудал чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ хэсэгт хүний аюулгүй байдалд заналхийлж, аюул учруулж болзошгүй хүчин зүйлийг үнэлгээний явцад түлхүү судлах, ойлгох анхаарах талаар тайлбарлах болно. Өөрөөр хэлбэл зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдлын асуудлыг зөвхөн нөхцөл байдлын дүн шинжилгээний явцад бус үнэлгээний бүх шатанд анхаарч судлах шаардлагатайг энэ хэсэгт сануулж байгаа юм.

Хүний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд аюул учруулж болохуйц хүчин зүйлсийг тодорхойлсны дараа (нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд), эдгээр хүчин зүйл орон нутгийн ардчиллын хөгжилд хэрхэн нөлөө үзүүлэхийг судлах нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, хүчирхийлэл үйлдэх, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэх нь ардчилсан үйл явц, институцын үйл ажиллагааны нэгдмэл байдалд аюул учруулж болзошгүй. Хууль бус тоглогчид улс төрийн эрх мэдэлтнүүдэд дарамт үзүүлж, улмаар орон нутгийн хөгжлийн бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж, иргэдийн сонголтод шууд болон шууд бусаар нөлөөлж, хуулийн хэрэгжилтэнд саад учруулах замаар эрх зүйт төрийн зарчмыг алдагдуулахад хүргэдэг.⁴¹

Орон нутаг дахь ардчилсан үйл явц, институт нь онолын хувьд шаардлагатай эрх мэдэл, эх үүсвэр, хүчин чадалтай нөхцөлд ардчиллын хөгжилд заналхийлж буй хүчирхийлэл, гэмт хэргийн шинжтэй аливаа хөндлөнгийн оролцоог хязгаарлаж, орон нутагт аюулгүй байдлыг сахин хамгаалж, зөрчил маргааныг шийдвэрлэх, зохицуулах механизмтай байдаг. Тиймээс ардчиллын төлөв байдлын үнэлгээний явцад орон нутгийн ардчилсан институцын энэхүү эрх мэдэл бодит байдалд хэрэгжиж байгаа эсэхийг нарийвчлан судалж, учир шалтгааныг тодохойлох оролдлого хийх ёстой. Гэхдээ орон нутгийн түвшинд бий болдог зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдлын асуудлыг судлахдаа эрх мэдлийн тогтолцоо, шударга ёсны зарчмыг анхааралтай авч үзэх хэрэгтэй. Учир нь зарим улсад шударга ёс тогтоох уламжлалт механизм нь аливаа төрлийн зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй оролцдог.

Ардчилал, аюулгүй байдал хоорондын харилцаа бодит байдал дээр илүү төвөгтэй байдаг тул ардчиллын төлөв байдал, ардчиллын чанарт үнэлгээ хийх явцад ардчилал, зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдал хоорондын энэхүү ярвигтай харилцааг заавал хөндөж байх хэрэгтэй.⁴²

Ардчилал ба хөгжил



Орон нутгийн иргэд, сонгогчдын дунд ардчилал, хөгжил хэмээх хоёр ойлголтыг анхнаасаа харилцан холбоотой байсан мэтээр ойлгох явдал түгээмэл байдаг. Ардчилсан нийгэм нь зөвхөн сайн сайхан зүйл гэдэг утгаараа бус ардчиллыг сонгосноор нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдрал илүү чанаржина гэсэн хүлээлт иргэдийн дунд түгээмэл байдаг тул иргэд ардчиллыг дэмждэг. Иргэд ардчилсан засаг төртэй байснаар тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг хурдан, шуурхай үзүүлж чадна гэж найдаж, хүлээдэг.

Ардчилалд дэлхий даяар үр нөлөөтэй, байнгын дэмжлэг үзүүлсээр ирсэн ч иргэд, олон нийтийн дунд ардчиллын чанарт сэтгэл хангалуун бус байгаа нь иргэд ардчиллын чанарыг зөвхөн тодорхой давтамжтайгаар, боломж гарсан сонгуулийн үед үнэлдэг бус харин бодит нөхцөл байдал, үр дүнд үндэслэн үнэлгээ хийдэгийг харуулж байна.⁴³

Өдгөө дэлхийн улс орнуудын өмнө тулгарч буй хамгийн чухал сорилын нэг бол ардчилал ба хөгжил хоорондын харилцааны асуудал юм. Ардчилсан нийгэм рүү шилжих тэрхүү шилжилтийн үйл явц нь эдийн засаг, нийгмийн ямар нэг ашиг тус агуулахгүй байгаа нь олон орон, бүс нутгийн хувьд шийдвэрлэх шаардлагатай асуудал болоод байна. Мөн түүнчлэн эдийн засгийн хөгжлийн үйл явц, гадны хүчин зүйл нь ардчилсан үйл явцын хөгжилд сөргөөр нөлөөлж ганхуулах эрсдэл дагуулж байна. Ардчилал хэмээх ойлголт нь өөрөө иргэдийн хүлээлт, хүсэл эрмэлзлийг ойлгох, тэдний хэрэгцээ шаардлагыг хангаж байж түүнээсээ хүч чадал, тогтвортой байдлын эх үндсээ бүрдүүлдэг бөгөөд ингэснээр нийгмийн бүх бүлгийн төлөөллийг хамруулсан тогтвортой хөгжлийг бий болгож чаддаг байна.⁴⁴

Ардчилсан улс төрийн үйл явц нь иргэдийн хүлээлт, хүсэл зоригийг хөгжлийн бодлого, хөтөлбөр болгон боловсруулж, хэрэгжүүлэх замаар иргэдийн өдөр тутмын амьдралыг сайжруулах үүрэг хүлээдэг. Ардчилсан институцын үйл ажиллагаа нийгэм, эдийн засгийн салбарт суларч, үр нөлөөгөө алдах нь ардчиллын чанарт муугаар нөлөөлдөг. Тиймээс орон нутгийн засаг захиргаа хүний эрхийг хүндэтгэн хамгаалах, иргэдийн хэрэгцээ шаардлага, бодит байдлыг ойлгох, шаардлагатай арга хэмжээг шуурхай авах чадавхтай, эрх мэдэлтэй удирдлагатай байх нь чухал. Үүний тулд юуны өмнө бүтцийн шинж чанартай зарим өөрчлөлт, зохицуулалт хийх шаардлага гардаг бөгөөд бодит байдал дээрх иргэдийн улс төрийн бүрэн оролцоо буюу зөвхөн сонгуульд санал өгч төлөөллөө сонгох бус, иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг

сайжруулах үүрэг хүлээн сонгогдсон төлөөлөгчийн эхлүүлсэн үйл хэрэг, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт үнэлгээ хийх, орон нутгийн удирдлагыг илүү хүчирхэг, үр бүтээлтэй ажиллахад нөлөөлөхийг мөн шаарддаг.⁴⁵



БҮЛЭГ 3

Үнэлгээг хэрхэн
гүйцэтгэх тухай

Үнэлгээг хэрхэн гүйцэтгэх тухай

Орон нутгийн иргэдийн санал, санаачилгад түшиглэсэн хөгжлийн бодлого, өөрчлөлт шинэчлэлийг дэмжих зорилготой ОнАТБ үнэлгээний гол цөм нь иргэд, олон нийт юм. Эцэстээ энэхүү үнэлгээ нь шинэчлэлд чиглэсэн байх бөгөөд ардчиллын чанарт үнэлэлт хийснээр орон нутгийн ардчиллын хөгжлийг эрчимжүүлэх боломжийг иргэдэд олгодог байх ёстой.

Үнэлгээ гэдэг нь бүх талын байр суурь, үзэл бодлыг тусгасан харилцан яриа, хэлэлцүүлэг болон судалгааг нэгтгэсэн хоёр талт үйл явц юм. Тиймээс үнэлгээнд шаардагдах судалгаа, шинжилгээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй, стандартын дагуу явуулж, орон нутгийн эмэгтэй, эрэгтэй иргэдийн тэгш, идэвхтэй оролцоог үнэлгээний бүх шатанд хангаж ажиллах шаардлагатай.

ОнАТБ-д үнэлэлт, дүгнэлт хийх сонирхолтой нийгмийн аль ч бүлгийн төлөөлөл энэхүү үнэлгээг санаачлан эхлүүлэх боломжтой. Ардчиллын төлөв байдлын үнэлгээг шинжлэх ухааны байгууллага, орон нутгийн хөгжлийн зөвлөл, төрийн албан хаагчид, хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн идэвхтэн, цөөнхийн бүлгийн төлөөлөл гэх мэт олон байгууллага явуулах боломжтой.

Иргэдийн оролцоог аль болох өргөн хүрээнд хангаснаар үнэлгээг илүү чанартай хийж орон нутгийн түвшинд шаардлагатай шинэчлэлийг эхлүүлэх, нөлөө үзүүлэх боломж нэмэгдэнэ. Мөн түүнчлэн, мэргэжлийн түвшинд судалгаа хийх, орон нутгийн иргэдийн төлөөлөл, тэр дундаа нийгмийн ялгаатай бүлгийн төлөөллийг идэвхтэй оролцуулах хооронд тэнцвэрт байдлыг бий болгох нь чухал.

Үнэлгээ хийх үндсэн алхам, шийдлүүдийг дараах найман үе шатанд хувааж хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү дараалал нь үнэлгээний ажлын бэлтгэл, гүйцэтгэл, тайлагнах үйл явц тус бүрийг нарийвчлан бэлтгэхэд чухал ач холбогдолтой.

Зураг 3.1. Үнэлгээний алхамууд



3.1. Бэлтгэл хангах, хугацаагаа сонгох, түншлэл бий болгох

Үнэлгээний эхний алхам бол бэлтгэл шат бөгөөд энэ шатанд үнэлгээ хийх орон нутгийн мэдээлэл, үнэлгээний зорилго, ашиг тус, цаг хугацаа, шинэчлэлийн үйл явцад оролцогчдын түншлэл, хамтын ажиллагааг нарийвчлан судлах, магадлах ажлууд хийгдэнэ.

ОНАТБ үнэлгээний аргачлалын ашиг тус

Үнэлгээг эхлүүлэхээс өмнө энэ чиглэлээр урьд өмнө хийгдсэн судалгаа, ардчиллын үнэлгээ, одоо хийгдэж буй судалгаа, үнэлгээний байгаа эсэхийг нягтлан үзэж, уг ОНАТБ үнэлгээг хийснээр гарах ашиг тусыг тодорхойлох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ОНАТБ ижил төрлийн судалгаа, үнэлгээтэй давхцахгүй, харин нэмэлт байдлаар хийгдэж болно. Үнэлгээний энэ шатанд дараах асуудлуудад тусгайлан анхаарах хэрэгтэй:

- Орон нутгийн түвшинд ардчиллын болон засаглалын ямар үнэлгээ урьд өмнө хийгдэж байсан бэ?
- Энэ чиглэлд судалгаа, шинжилгээний ямар ажлууд хийгдэж байсан бэ?
- Орон нутгийн зүгээс санаачлан тухайлсан дүн шинжилгээ хийсэн эсэх
- Судалгааны үндсэн чиглэл, сэдэв юу байсан?
- Судалгааг аль байгууллага гүйцэтгэсэн?
- Судалгааны зорилго
- Судалгаанд ашигласан аргачлал, аргазүй, хандлага
- Судалгааны аргазүйг хэрхэн ашигласан тухай
- Судалгааны үр дүн
- Судалгаа, үнэлгээний явцад орхигдсон, нэмж судлах шаардлагатай ямар асуудлууд байсан.

Эл дурдсан асуудлуудыг судалснаар урьд өмнө хийсэн судалгаанд энэхүү үнэлгээ ямар хувь нэмэр, ашиг тустай, хэрэгцээтэйг тодорхойлох, цаашлаад орон нутгийн ардчиллын хөгжилд хэрхэн эерэг нөлөө үзүүлэх боломжтойг судлах зорилготой юм. ОНАТБ нь олон нийтийн дунд ерөнхий мэдээлэл өгч ухамсар дээшлүүлэх, улмаар иргэд, олон нийтийн дунд улс төр, хөгжлийн бодлого, засгийн газрын хөтөлбөр болон орон нутгийн түвшинд өөрчлөлт, шинэчлэлт хийх зэрэг асуудлаар хэлэлцүүлэг, харилцан яриа өрнүүлэх зорилгыг агуулж болно. Ихэнх тохиолдолд үнэлгээ хийж буй байгууллага эдгээр зорилгыг үнэлгээний ажлынхаа үндсэн хүрээ болгон тодорхойлдог.

Бенчмарк тогтоох

Үнэлгээний дараагийн шатанд бенчмарк буюу харьцуулалт хийх суурь жишиг үзүүлэлтүүдийг тодорхойлно. Нэгдүгээрт, цаг хугацааны үзүүлэлтийг тодорхойлох шаардлагатай. Хамрах цаг

хугацааг тодорхойлоходоо засгийн газрын бүрэлдэхүүн солигдох, сонгууль зохион байгуулах, шинэ Үндсэн хууль эсвэл төвлөрлийг сааруулах бодлогын хүрээ батлах гэх мэт цаг үеийн чухал үйл явдал өрнөх цаг хугацааг анхаарч болно. Хоёрдугаарт, үнэлгээний үндсийг тодорхойлоход шаардагдах суурь үзүүлэлтүүд юм. Гэхдээ тухайн орон нутагт урьд өмнө ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийгдэж байгаагүй тохиолдолд суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох нь төдийлөн амар бус байдаг. Тиймээс дараах дөрвөн мэдээлэл, судалгааны эх сурвалжийг ашиглан холбогдох үзүүлэлтийг боловсруулах боломжтой:

- i. Олон нийтийн санаа бодлын тандах судалгаа,** орон нутгийн ардчилал ба/эсвэл засаглалын үйл ажиллагааны талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа.
 - Давуу тал: орон нутгийн ардчиллын талаарх иргэдийн санаа бодол, хүлээлтийг ойлгох, мэдэх.
 - Сул тал: судалгааны үр дүнг хоёр талтай гэж шүүмжлэх магадлалтай; урьд өмнө хийгдэж байгаагүй тохиолдолд нөөц бололцоо шаардагдах.
- ii. Орон нутгийн стандартууд,** нутгийн захиргааны зүгээс тодорхойлсон бодлогын зорилго, зорилтууд.
 - Давуу тал: хууль ёсны байдал, тодорхойлоход хялбар, өртөг багатай.
 - Сул тал: иргэд, олон нийт, сөрөг хүчний үзэл бодлыг төдийлөн тусгадаггүй.
- iii. Үндэсний стандартууд,** Үндсэн хууль, энх тайвны гэрээ гэх мэт суурь баримт бичгийн хүрээнд баталгаажсан бүх нийтийн норм, дүрэм журам гэх мэт.
 - Давуу тал: хууль ёсны байдал, тодорхойлоход хялбар, өртөг багатай.
 - Сул тал: иргэд, орон нутгийн засаг захиргааны зүгээс хүлээн зөвшөөрч баталсан нөхцөлд л ашиглаж болно.
- iv. Сайн засаглалын олон улсын стандарт,** тухайлбал НҮБ-ын сайн засаглалын зарчмууд.
 - Давуу тал: нийгэд хүлээн зөвшөөрөгдсөн, сайн туршлагад суурилсан.
 - Сул тал: иргэд, нутгийн захиргааны зүгээс хүлээн зөвшөөрч батлах шаардлагатай.

Үнэлгээний хугацаа

Үнэлгээ нь өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжих мөн чанартай тул улс төрийн хөгжлийн үүднээс үнэлгээ явуулах цаг хугацааг тодорхойлох нь орон нутгийн эрх баригчдын дунд орон нутгийн ардчиллыг сайжруулахад чухал ач холбогдолтой байдаг.

Сонгууль, улс төрийн өөрчлөлт зэрэг үйл явдал үнэлгээний үйл явцад нөлөөлөх магадлалтай бол үнэлгээ нь эргээд сонгуулийн үр дүн, орон нутгийн шинж чанартай шинэчлэлийн үйл явцад ч нөлөөлөх эрсдэлтэй. Жишээ нь сонгуулийн кампанит ажил ид дундаа явагдаж, улс төрчид сонгуульд бэлтгэж байх үед ОнАТБ хийх нь оновчгүй бөгөөд сонгууль дуусаж нөхцөл байдал тайван болсон үед хийх нь илүү тохиромжтой бөгөөд янз бүрийн оролцогчдыг оролцуулахад хялбар байдаг. Харин улс төрийн тогтолцооны шилжилтийн үе буюу Үндсэн хууль эсвэл төвлөрлийг сааруулах бодлогын шинэчлэл хийх цаг үетэй давхцуулан ОнАТБ төлөвлөх нь үнэлгээний үр дүнг иргэд олон нийтэд хүргэх, улс төрийн мэтгэлцээнд ашиглах гэх мэт давуу талтай.

Түншлэлийн замаар шинэчлэгчдийг татан оролцуулах

ОнАТБ үнэлгээ хийж буй субъект тухайн орон нутагт шаардлагатай өөрчлөлт хийх эрх мэдэлгүй байвч тухайн улс, орон нутаг ардчилсан өөрчлөлт, хөгжлийн шинэ гарц, бодлогын шинэчлэлийг эхлүүлж чадах эрх мэдэлтэй байгууллага, албан тушаалтанд нөлөөлөх, тэдэнтэй хамтран ажиллах боломжтой. Гэхдээ шинэчлэлийг эхлүүлэгч талуудын оролцоог үнэлгээний эхний шатанд нэмэгдүүлэх нь хэт яарсан бөгөөд эрсдэлтэй алхам болно. Төрийн байгууллага, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, орон нутгийн эрх ашгийг хамгаалсан байгууллагууд, жендер, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага болон хувийн салбарын төлөөллийн оролцоо анхнаасаа их байх тусам өөрчлөлт шинэчлэл хийх боломж илүү нээлттэй байж, хариуцлагатай хандах боломж нэмэгддэг. Тиймээс үнэлгээний бүх шатанд хамтран ажиллах талуудыг сонгохдоо үнэлгээний төгсгөлд хэрэгжүүлэхийг зорьсон өөрчлөлт, шинэчлэлийн зорилготойгоо уялдуулж сонголтоо хийх нь зүйтэй.

Ардчиллын чанар, төлөв байдалд үнэлгээ хийх талаар холбогдох талуудад мэдээлэл хүргэж, харилцан зөвшилцөж, тэдний төлөөллөөс үнэлгээний төлөвлөлтийн шатанд оролцуулах нь зарим нөхцөлд давуу талтай. Тухайлбал, шаардагдах нөөц бололцоо, эх үүсвэрийг тодорхойлох, мэдээллийн олон эх сурвалжтай болох, тодорхой салбаруудаар мэргэшсэн мэргэжлийн судлаач, эрдэмтэдтэй холбогдох зэрэг давуу талтай. Холбогдох талуудыг үнэлгээний ажилд татан оролцуулах нэг арга зам бол зөвлөх багийн бүрэлдэхүүнд орж ажиллахыг санал болгох явдал юм. (Бүлэг 3.2 – ыг харарх).

Шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх

Үнэлгээний бэлтгэл шатанд зайлшгүй хийгдэх ёстой нэг ажил бол шаардлагатай цаг хугацаа, санхүүгийн болон хүний нөөцийн эх үүсвэрийг бүрдүүлэх явдал юм. Боломжит эх үүсвэрийн хэмжээг тодорхойлсноор үнэлгээний хамрах хүрээ, судалгааны ажлын хэмжээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтойн дээр нэмэлт санхүүжилтийг төлөвлөхөд хялбар болдог.

Хайрцаг 3.1

Санхүүжилт босгох

Үнэлгээ хийхэд шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн холбоод, судалгааны тэтгэлэг, засгийн газрын хөтөлбөр, үндэсний болон олон улсын байгууллагуудын хөгжлийн сан зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлэх боломжтой. Санхүүжилт гагцхүү дотоодын эх үүсвэрээс гарсан нөхцөлд ардчиллын төлөв байдлын үнэлгээг илүү хариуцлагатай, бодитой хийх нөхцөл бүрддэг. Гэхдээ орон нутгийн нөхцөл байдлаас хамаарч дотоод эх үүсвэрээс санхүүжих боломж, бололцоо харилцан адилгүй байдаг.


3.2. Үнэлгээ хийх байгууллага

Үнэлгээ хийх шийдвэр нэгэнт гарсан тохиолдолд дараагийн шатанд хийх үндсэн ажил бол үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий багийг байгуулах юм. Багийн бүрэлдэхүүнд судалгааны ажлын туршлагатай мэргэжилтнүүдээс гадна зөвшилцөх, мэтгэлцэх, хэлэлцүүлэг өрнүүлэх чадавхтай мэргэжилтний төлөөллийг мөн багтааж тэнцвэрт байдлыг хангах ёстой.

Үнэлгээ хийх баг удирдлага, зохион байгуулалт хариуцсан бүтэцтэй байх бөгөөд (а) үнэлгээний үндсэн баг (б) зөвлөх баг гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Удирдлага, зохион байгуулалт хариуцсан багийн үндсэн үүрэг бол үнэлгээний ажлын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах, төслийн нийт менежментийг нэгдсэн зохицуулалтаар хангахад чиглэгдэнэ. Үнэлгээг хоёр болон түүнээс дээш тооны байгууллага хамтран гүйцэтгэж байгаа нөхцөлд энэ багийн гүйцэтгэх үүрэг чухал, хариуцлага өндөр байна. Тиймээс баг тус бүрийн мандат, хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагаагаа тайлагнах хэлбэр зэргийг анхнаасаа ойлгомжтой, дэлгэрэнгүй тодорхойлох хэрэгтэй.

Үнэлгээний үндсэн баг болон зөвлөх багийн бүрэлдэхүүнд мэргэжлийн ур чадвар, туршлага бүхий эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөллийг тэгш хангах нь зүйтэй.

Зураг 3.2. Иргэдийн оролцооны үе



Үнэлгээ хийх үндсэн баг: ОНАТБ-ын үнэлгээний хөдөлгөөгч хүч

Үндсэн баг нь ардчиллын төлөв байдлын үнэлгээний хүрээнд хийгдэх судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх, үнэлгээний бүх шатанд оролцогч талуудтай зөвшилцөх замаар орон нутгийн иргэдтэй холбогдох, харилцах, үнэлгээний ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй. Үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүн улс орон бүрт өөр өөр байх боловч үнэлгээний үндсэн багийг бүрдүүлэхэд анхаарч үзэх шаардлагатай дараах хэдэн асуудал байдаг.

- **Багийн гишүүдийн тоо, бүрэлдэхүүн**

Ихэнх улс оронд үнэлгээний үндсэн баг бүтэн цагаар ажиллах гишүүдийн тоо 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Энэ багт төслийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах үүрэг бүхий багийн ахлагч эсвэл төслийн менежер ажиллах ёстой бөгөөд тодорхой асуудал хариуцсан судлаачид, холбогдох мэргэжилтнүүд багтана. Мэдээлэл цуглуулах, олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх судалгааны туслах ажилтан гэх мэт нэмэлт хүний нөөц шаардлагатай тохиолдолд богино хугацаагаар гэрээт ажилтнаар ажилуулах боломжтой. Багийн гишүүдийн дунд хүйсийн тэнцвэрт байдлыг мөн хангах нь зүйтэй.

- **Салбар хоорондын шинжлэх ухаан, оролцогч талуудын төлөөллөөс бүрдэх баг**

Үнэлгээний үйл явц, холбогдох судалгаа шинжилгээнд шинжлэх ухааны холбогдох салбаруудыг аль болох өргөнөөр хамруулах, ур чадвар, мэдлэг туршлагатай судлаачдыг түлхүү ажиллуулах нь чухал. Үнэлгээ явуулах үндсэн багийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, туршлага нь үнэлгээний явцад зайлшгүй судлах шаардлагатай салбаруудад хамаарах (жишээ нь: эрх зүйт төр, нийгэм, эдийн засаг, соёлын эрх, төвлөрлийг сааруулах, сонгууль гэх мэт) мэдлэг, мэдээлэл, мэргэшлийн ур чадвартай нийцэж байвал онолын үүднээс хамгийн зөв шийдэл болох юм. Үндсэн багийн бүрэлдэхүүнд жендер, нийгмийн цөөнхийн чиглэлээр ажилласан, судалгааны туршлагатай мэргэжилтэн байх нь чухал. Судлах сэдвийн агуулгаас хамаараад мэргэжлийн судлаачдыг мөн нэмэлтээр ажиллуулах боломжтой. Үнэлгээ хийх үндсэн багийн бүрэлдэхүүнийг дээр дурдсаны дагуу бүх талын мэдлэг, ур чадвартай судлаач, мэргэжилтнүүдээс бүрдүүлэх боломжгүй тохиолдолд зөвлөх багт холбогдох чиглэлийн мэдлэг, туршлага хуримтлуулсан хүн ажиллуулах нь зүйтэй.

- **Судалгааны ур чадвар**

Баг тус бүрт судалгааны ур чадвар эзэмшсэн, тэр дундаа статистикийн дүн шинжилгээ хийдэг туршлагатай, ур чадвартай гишүүд байх ёстой. Эдгээр гишүүдийн үндсэн үүрэг бол судалгааны загвар боловсруулах, судалгаа явуулах, судалгааны үр дүнг судлаачдын өнцгөөс нарийвчлан гаргах, судалгааны чанарт тусгайлан анхаарах явдал юм. Мөн түүнчлэн судалгааны стандарт, үнэлгээний сегмент тус бүрийн чанарын баталгаа, мэдээллийн дүн шинжилгээ, судалгааны үр дүнг баталгаажуулах, эцсийн тайлан боловсруулахад хувь нэмрээ оруулах ёстой.

- **Хэлэлцүүлэг идэвхжүүлэгчийн туршлага**

Баг тус бүрт иргэд, олон нийт, холбогдох талууд хооронд үр дүнтэй, зохион байгуулалт сайтай хэлэлцүүлэг зохион байгуулах ур чадвар эзэмшсэн туршлагатай гишүүн байх нь зүйтэй. Эдгээр гишүүдийн үндсэн үүрэгт үнэлгээний бүх шатанд иргэд, олон нийт, оролцогч талуудтай хийх аливаа төрлийн хэлэлцүүлэг, ярилцлагыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, шаардлагатай зөвлөмж зөвлөгөө өгөх зэрэг багтахаас гадна эдгээр хэлэлцүүлэг, ярилцлагад орон нутгийн эрэгтэй, эмэгтэй гишүүд, нийгмийн цөөнхийн төлөөллийг тэнцвэртэй хангах, хамруулахад мөн анхаарч ажиллах ёстой. Иргэд, олон нийтийн дунд явуулах хэлэлцүүлэг бол ардчиллын төлөв байдлын үнэлгээний чухал бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд энэхүү хэлэлцүүлгээр дамжуулан холбогдох салбарын мэдээлэл цуглуулах, мэдээллээ баталгаажуулах боломж бүрддэг.

- **Баг доторх хөдөлмөрийн хуваарь, үүрэг хариуцлага**

Багийн гишүүдийн үүрэг хариуцлага, хөдөлмөрийн хуваарилалтыг хэрхэн хийх, багийн ахлагч хэн байх вэ гэдгийг энэ шатанд шийдэх нь зүйтэй. Юуны өмнө үндсэн багийн гишүүн тус бүрийн ажиллах хугацаа, тэр дундаа үнэлгээний бүх шатанд дуустал ажиллах боломжтой эсэхийг нягтлах хэрэгтэй. Түүний дараа гишүүн тус бүр үнэлгээний аль үе шатанд, ямар ажлыг, хэдий хугацаанд

хийж гүйцэтгэх боломжтойг тодорхойлно. Ажлын ачааллыг тэнцүү хуваарилж, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд манлайлах, уриалах үүргийг багийн бүх гишүүдийн дунд хувааж, харилцан хамаарлыг боломжит түвшинд бууруулж, багийн ахлагч тодорхой шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй үед, багийн гишүүд орлож, ажлын явц, үр дүнд сөргөөр нөлөөлөх аливаа эрсдлийг бууруулж ажиллах нь зүйтэй. Зарим ажлын аутсорсинг буюу гадны байгууллагаар шууд гүйцэтгүүлсэн тохиолдолд, тухайн мэргэжилтний жишээ нь жендерийн мэргэжилтний гүйцэтгэж буй судалгаа, шинжилгээ нь нийт үнэлгээний нэг хэсэг байх бөгөөд шаардлагатай нөхцөлд үнэлгээний бусад үе шатуудад ч ажиллах байдлаар зохицуулалт хийх нь зүйтэй.

Зөвлөх баг: шинэчлэлийн төлөөх түншлэл бий болгох

Үнэлгээ хийх үндсэн багаас гадна шинжлэх ухааны холбогдох салбаруудын төлөөллийг багтаасан, оролцогч талуудын төлөөлөл бүхий зөвлөх баг бүрдүүлэх нь нэн чухал. Зөвлөх багийг үнэлгээ хийх орон нутгийн иргэдийн төлөөлөл гэж үзэж болох ч үнэлгээний үндсэн агуулга, нийгэм, улс төрийн цар хүрээ, аспектыг давхар судлах, хэлэлцэх чухал субъект байх юм. Зөвлөх багийн үндсэн үүрэг хариуцлагад үндсэн багийн үйл ажиллагааг мэргэжлийн хувьд удирдан чиглүүлэх, үнэлгээний бүх шатанд гарсан тайлангийн төслийг хянах, санал зөвлөмж боловсруулах зэрэг багтана.

- **Багийн хэмжээ, бүрэлдэхүүн**

Зөвлөх багийн нийт гишүүд 10-15 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нийгмийн бүх салбарыг төлөөлсөн, орон нутгийн байгууллага, сонгогчдын төлөөллийг багтаасан байх ёстой. Зөвлөх багийн гишүүд нь тодорхой асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, түүнийгээ холбогдох талуудад хүргүүлэх, тайлбарлах, гүйцэтгүүлэх эрх мэдэлтэй, судалгааны ур чадвар эзэмшсэн, туршлагатай, асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж чаддаг, шинэчлэлд чиглэсэн, нийгмийн цөөнхийг төлөөлсөн хүмүүс байх учиртай. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн дунд үнэлгээний багийг удирдлан чиглүүлэх үүрэг хүлээсэн нэг хэсэг, үнэлгээнээс гарах үр дүнг нийтэд танилцуулах, сурталчлах, улмаар өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлэх үүрэг бүхий багийн гишүүд гэж байх бөгөөд гишүүдийн тоо тэнцвэртэй байх нь зүйтэй. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд шаардагдах ур чадвар, туршлага хуримтлуулсан эмэгтэй, эрэгтэй гишүүдийн тэгш төлөөллийг бий болгох нь зүйтэй. Зөвлөх багийн гишүүд нь үнэлгээний бүх шатны үйл ажиллагаанд тогтмол, хариуцлагатай оролцох ёстой.

- **Оролцогч талууд**

Зөвлөх багийн гишүүдийн үүрэг зөвхөн судалгаа, шинжилгээ, үнэлгээний үр дүнг баталгаажуулах бус эцсийн тайлан гарсны дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээнд төвлөрөх ёстой. Тиймээс, зөвлөх багийн бүрэлдэхүүнд үнэлгээний үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах байгууллага, хувь хүмүүс тухайлбал хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрийн нам, бүлэглэлүүд, иргэний нийгмийн

байгууллагууд, төрийн бус байгууллага, засгийн газрын холбогдох институт, шинжлэх ухааны байгууллагуудаас төлөөлөл оруулах нь зүйтэй.

Тиймээс юуны өмнө үнэлгээний хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг ашиглах зорилготой бүлгүүдийг тодорхойлох, оролцогч талуудын дүн шинжилгээ хийх шаардлагатай. Шинжлэх ухааны олон салбарын төлөөлөл, газарзүйн байршлын хувьд өөр орон нутгийн төлөөлөл оруулах нь үнэлгээний үр дүнг илүү бодитой, хууль ёсны болгох ба өөрчлөлт, шинэчлэлийг тууштай эхлүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Хайрцаг 3.2

Сайн туршлага: Зөвлөлийн гишүүдийг татан оролцуулах

Орон нутгийн зөвлөл үнэлгээний үйл явц, үр дүнг эзэмших үүднээс Танзани улсад (2013 онд) ОнАТБ хийсэн баг үнэлгээний эхний шатнаас эхлэн орон нутгийн зөвлөлийн төлөөллийг зөвлөх багийн бүрэлдэхүүнд оруулж орон нутгийн зөвлөл ОнАТБ хариуцан ажиллах ажилтныг томилсон байна. Ингэснээр орон нутгийн зөвлөлийн төлөөлөл үнэлгээний төлөвлөлтөөс эхлэн хэрэгжиж дуусах хүртэлх бүх үе шатанд идэвхтэй оролцоотой байх үүрэг хүлээсэн юм. Орон нутгийн зөвлөлийн энэхүү ажилтан нь зөвлөлийн гишүүд дунд холбогдох асуудлаар хэлэлцүүлэг явуулах, үнэлгээнээс гарах зөвлөмж, үр дүнг баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажиллажээ.

- **Тогтмол, тууштай хамтын ажиллагаа**

Зөвлөх багийн гишүүд судалгаа, шинжилгээний ажилд заавал оролцох шаардлагагүй боловч үнэлгээний бүх үе шатанд энэ талаар холбогдох мэдээллийг бүрэн авах нь судалгааны ажлын чанар, найдвартай байдлыг хангах, нийт үнэлгээний үр дүнг баталгаажуулахад чухал ач холбогдолтой. Энэ нь үнэлгээ хийх үндсэн багтай хамтран мэдээлэл солилцох, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулна гэсэн үг юм. Зөвлөх багийн гишүүд хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэрэг олон арга хэмжээнд идэвхтэй оролцож техникийн дэмжлэг үзүүлж ажиллах нь зүйтэй.

3.3. Үнэлгээний загвар, ажлын төлөвлөгөө

Үнэлгээний загвар боловсруулах энэ шатанд ОнАТБ хүрээг тодорхойлох, задаргаа хийх талаар үндсэн баг, зөвлөх багийн гишүүдийг хамруулсан дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай болдог. Тиймээс энэ шатанд шаардлагатай эх үүсвэр, цаг хугацаа зайлшгүй зарцуулж байж, үнэлгээг амжилттай хийх үндэс бүрдэнэ.

Хайрцаг 3.3

Үнэлгээний загварын үзүүлэлтүүд

Үнэлгээний загварт орж болох үндсэн элементүүдэд дараах асуудлууд багтдаг агаад зөвхөн үүгээр хязгаарлаж болохгүй:

- Судалгааны аргазүй, мэдээлэл цуглуулах арга, мэдээллийн эх сурвалж, судалгаанд хамрагдах бүлэг, респондентуудыг тодорхойлох.
- Ойлголт, ухагдахуун, үзэл баримтлалын нэгдсэн ойлголттой байх, өөр утгаар хэрэглэгдэх онцгой тохиолдлуудыг тайлбарлах.
- Асуулгын хуудсыг шинэчлэх, үнэлгээний асуултуудыг тухайн орон нутгийн онцлог шинжид тохируулан өөрчлөхдөө жэндер, нийгмийн ялгаатай бүлгүүд, зөрчил мөргөлдөөн зэрэг эмзэг асуудлуудад болгоомжтой хандах.
- Асуулгын хуудас болон холбогдох бусад баримт бичгүүдийг тухайн орны хэл руу хөрвүүлэх.
- Үнэлгээний үе шат тус бүрт тусгайлан харилцах оролцогч талуудыг тодорхойлох, үүнд: үнэлгээний эцсийн үр дүнг хэрэглэх бүлэг, олон нийт гэх мэт.
- Иргэд, олон нийттэй хийх хэлэлцүүлэг, мэтгэлцээний хамрах хүрээ, аргачлал зэргийг урьдчилан тодорхойлох.
- Иргэд, олон нийтийн хэлэлцүүлэг, харилцан ярилцлагын загварыг боловсруулж гарсан үр дүнг судалгааны ажлын аль хэсэгт хэрхэн ашиглахыг урьдчилан тодорхойлох.
- Хэлэлцүүлэг өрнүүлэх арга зам, бэлтгэл.
- Үнэлгээний тайлангийн формат, тайлан бичих хэл, тайлангийн үр дүн тархаалтын стратегиэ тодорхойлох, шийдвэрлэх.
- Олон нийттэй харилцах, олон нийтэд сурталчлах стратеги боловсруулах. Үүнд үнэлгээний тайлангийн төсөл, урьдчилсан үр дүнг баталгаажуулах зорилгоор хийсэн семинар, уулзалтуудын мэдээлэл, тархаалтын бодлого, үйл ажиллагаа зэрэг багтана.
- Сурталчилгааны стратегийн хэрэгжилтийн урьдчилсан үр дүнг тоймлох (жишээ нь: стратегийн түншүүдээ тодорхойлж, тэдэнд шаардлагатай мэдээлэл өгч, хамтран ажиллах; орон нутгийн ардчиллын үнэлгээнээс гарах үр дүнг бодлого хөтөлбөр боловсруулахад ашиглах).
- Орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийхэд шаардлагатай үзүүлэлтүүдийг хэрхэн, ямар түвшинд боловсруулах тухай хэлэлцэх, ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх энэ ажлыг орон нутгийн түвшинд тогтмол хийдэг ажил болгож чадах эсэх.

Үнэлгээний загвар боловсруулах энэ үе шат бол багийн гишүүн бүр хүлээх үүрэг хариуцлагын талаар нэгдсэн ойлголттой болох, хүлээсэн үүрэг, хариуцлагаа хэрхэн үр дүнтэй гүйцэтгэх вэ гэдгээ тодорхойлох хамгийн чухал, шийдвэрлэх үе шат юм. Хэдийгээр үнэлгээний загварыг хамгийн эхний шатанд боловсруулах нь онолын хувьд хамгийн оновчтой боловч бодит байдалд үнэлгээний загвар, хүрээг үе шат бүрт засаж сайжруулж, ажиллах шаардлагатай байдаг.

Хайрцаг 3.4

Иргэдийн хэлэлцүүлэг: Боломж, арга хэрэгслээ тодорхойлох нь

Иргэд, олон нийтийн дунд явуулах хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг ямар хэлбэрээр, ямар түвшинд зохион байгуулах нь ОнАТБ агуулга, хамрах хүрээнээс шууд хамаарна. Хөдөөгийн жижиг суурин, тосгонд иргэдийн оролцоотой хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах нь том хотод олон хүн хамруулж, хэлэлцүүлэг зохион байгуулахаас өөр байдаг. Өөрөөр хэлбэр 8-12 хүнтэй бүлгийн ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, 100-200 хүнтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах нь арга, хэлбэрийн хувьд ялгаатай. Мэдээлэл цуглуулах зорилгоор хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, судалгаа, шинжилгээ, тайлангийн үр дүнг баталгаажуулах зорилгоор зохион байгуулах уулзалт, хэлэлцүүлэг бүр бүтэц, зохион байгуулалт, арга хэлбэрийн хувьд ялгаатай. Тиймээс үнэлгээний загвар боловсруулах шатанд иргэд, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах бол зохион байгуулалтын олон хувилбар, сонголтуудыг судлах, энэ талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй. Хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг Ардчилсан хэлэлцүүлгийн гарын авлага (2007)⁴⁶ – аас авах боломжтой.

Асуулгын хуудсыг шинэчлэн боловсруулах

ОнАТБ нь орон нутгийн ардчиллын чанарт дүн шинжилгээ хийх арга зүйн үндсэн хүрээг тодорхойлсон бүтэц юм. Тиймээс дөрөвдүгээр бүлэгт орсон сэдэв, чиглүүлэх асуултууд нь бүгд ардчиллын үнэлгээг эхлүүлэх жишиг асуултууд бөгөөд үнэлгээний баг ОнАТБ үндсэн зорилго, чиг шугам, зарчим, үнэт зүйлээс хазайлгүйгээр тухайн орон нутгийн онцлог, шинж байдалд нийцүүлэн эдгээр сэдэв, асуултуудыг өөрчлөх, дэлгэрүүлэх боломжтой.

Үнэлгээний асуултуудыг орон нутгийн онцлог шинж, байдалд тохируулан өөрчлөхдөө дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй:

- Орон нутгийн хэл, бүх нийтээр ойлгодог ухагдахуун, ойлголт тодорхойлолтыг ашиглах.
- Хэл зүйн дүрэм, хэлний онцлогт нийцүүлэх, жендерийн мэдрэмжтэй асуултууд боловсруулах.⁴⁷

- Үнэлгээний явцад ашиглагдах нэр томъёо, ойлголтууд нийгмийн бүх бүлгийн хүмүүст ойлгомжтой байгаа эсэхийг нягтлах.
- Ойлголт, нэр томъёо нь төвийг сахисан, орон нутгийн чанартай эмзэг асуудлуудад тусгайлан анхаарсан байх.
- Үнэлгээний асуултууд нь ардчиллын төлөв байдлын үнэлгээний үндсэн зарчим, үнэт зүйлсийг илэрхийлж байгаа эсэхийг нягтлах.

Асуулгын хуудсанд байгаа асуултууд нь үнэлгээний асуултуудаас ялгаатай байдаг. Учир нь асуулгын хуудас ашиглан ярилцлага хийж, судалгаанд хамрагдаж буй хүний ардчилсан үйл явц, зарчмын талаарх олж авсан мэдлэг, мэдээлэлд нийцүүлэн ярилцлагын асуултуудыг асуудаг бөгөөд харьцангуй дэлгэрэнгүй, тодорхой байдаг. Бүх асуулт, хэлэлцүүлгийн сэдвүүд нийтэд ойлгомжтой, энгийн агуулгатай байх ёстой бөгөөд судалгаанд оролцож буй хүний асуусан асуулт, тодруулганд үнэлгээний баг хариулт өгч, дэмжиж ажиллах нь зүйтэй.

Ажлын төлөвлөгөө гаргах, төсөв, хугацааг тодорхойлох

Аливаа төсөл хөтөлбөрийн нэгэн адил ардчиллын үнэлгээний төсөв, ажлын төлөвлөгөөг бодитой, оновчтой боловсруулснаар үнэлгээний ажил илүү үр дүнтэй, амжилттай болж чадна. Ажлын төлөвлөгөөгөө оновчтой, бодитой гаргаж чадвал үнэлгээ эхлэхээс өмнө, үнэлгээний шатанд болон үнэлгээ хийж дуусах гээд бүх үе шатанд илүү зардал гаргах, цаг хугацаа дэмий үрэх эрсдлийг бууруулах боломжтой бөгөөд орон нутгийн сонгууль гэх мэт үнэлгээний үр дүнд нөлөөлөхүйц улс төр, нийгмийн үйл явдлуудыг урьдчилан тооцоолоход тустай. Эдгээр эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд үнэлгээний баг ажлын бүх үе шатыг хамарсан нарийвчилсан ажлын төлөвлөгөө боловсруулах ба үүнд үе шат бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шаардлагатай төсөв, хэрэгжүүлэх хугацаа зэргийг дэлгэрэнгүй оруулсан байна. Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөнд үр дүнг тархаах, олон нийтэд хүргэх, сурталчилах гэх мэт үнэлгээний дараа хийгдэх ажлуудыг мөн тусгасан байх ёстой. Үндсэн баг ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан анхны хувилбарыг зөвлөлдөх багийн гишүүдтэй хуваалцаж, тэдний санал, зөвлөмжийг тусган шинэчлэх нь зүйтэй.

Зураг 3.3. Ажлын төлөвлөгөөний чухал хэсгүүд: Зорилго, үйл ажиллагаа, хугацаа, төсөв

Төслийн нэр: Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээ Х			
Үнэлгээний зорилго: Үнэлгээг улс төрийн ямар үйл явцаар дамжуулан ямар зорилгоор, хэн, хэрхэн ашиглах			
ҮЕ ШАТ	АЛХАМ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	НИЙТ ЗАРДАЛ*
1. Бэлтгэл ажил, хугацаа төлөвлөх, түншлэл бий болгох	Хэрэгцээ, шаардлага, үнэт зүйлс, харьцуулах үзүүлэлтийн суурь судалгаа хийх	Үнэлгээ эхлэхээс өмнө	*Орон нутгийн өртөг, зардлаас хамаарна
	Цаг хугацаа, санхүү, хүний нөөцийн эх үүсвэр бүрдүүлэх, санхүүжилт босгох		
	Оролцогч талууд, хамтран ажиллах талуудтай уулзалт зохион байгуулах		
	Бусад үйл ажиллагаа: ...		
2. Үнэлгээ хийх байгууллага	Зохион байгуулалт, удирдлагын бүтэц бий болгох		
	Үнэлгээний үндсэн болон зөвлөх багийн уулзалтууд		
	Бусад үйл ажиллагаа: ...		
3. Үнэлгээний загвар, ажлын төлөвлөгөө, олон нийтэд танилцуулах	Үнэлгээний хүрээ, загварыг эцэслэн тохирох		
	Асуулгын хуудсыг шинэчлэх		
	Ажлын төлөвлөгөө, төсөв, хугацааг тодорхойлох		
	Холбогдох бүлэг, байгууллагуудтай зөвлөлдөх уулзалт/ хэлэлцүүлэг зохион байгуулах		
	Бусад үйл ажиллагаа: ...		
	Нийтэд танилцуулах: Үнэлгээний албан ёсны нээлт	1 – дүгээр сар	
4. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	Мэдээлэл цуглуулах (арга, аргачлалаа тодорхой бичих)	1-3 дугаар сар	
	Үндсэн болон зөвлөх багийн уулзалтууд	1-5 дугаар сар	
	Холбогдох талуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	2-5 дугаар сар	
	Мэдээллийн дүн шинжилгээ, тайлбар, тайлангийн үр дүнг дэлгэрэнгүй тайлбарлах	4-5 дугаар сар	
	Бусад үйл ажиллагаа: ...		

5. Зөвлөмж, тайлан боловсруулах	Тайлангийн төсөл боловсруулах	5-6 дугаар сар	
	Үндсэн болон зөвлөх багийн уулзалтууд	6 дугаар сар	
	Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг эцэслэн тохирох	6 дугаар сар	
	Холбогдох талуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	6 дугаар сар	
	Бусад үйл ажиллагаа: ...		
6. Үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинар	Үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинар орон нутгийн түвшний хэлэлцүүлэг	7 дугаар сар	
	Үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинар хэлэлцүүлгийг үндэсний түвшинд зохион байгуулах	7 дугаар сар	
	Семинар, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг тусган эцсийн тайлан боловсруулах	8 дугаар сар	
	Бусад үйл ажиллагаа: ...		
7. Хэвлэмэл материал, тархаалт, сурталчилгааны стратеги	Нийтэд ойлгомжтой хэлбэрээр ном товхимол, мэдээлэл түгээх материал хэвлэлд бэлтгэх,	9-12 дугаар сар	
	Үнэлгээний тайланг нийтэд танилцуулах	10 дугаар сар	
	Үнэлгээний үр дүн, холбогдох зөвлөмжийг нийтэд хүргэх, тархаах, хэлэлцүүлэг өрнүүлэх	9-12 дугаар сар	
	Сурталчилгааны арга хэмжээ/ шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	9-12 дугаар сар үнэлгээний дараа	
	Бусад үйл ажиллагаа: ...		
8. Үнэлгээ, үзүүлэлт боловсруулах, дараагийн алхам	Үйл явц, үр дүнгийн үнэлгээ	12 дугаар сар, үнэлгээний дараа	
	Үзүүлэлтийг боловсруулах		
	Орон нутгийн ардчиллын үнэлгээг институтчлэх төлөвлөгөө		
	Бусад шаардлагатай арга хэмжээ...		

АСДҮОУХ-ийн хийж гүйцэтгэсэн ОнАТБ-н туршлагаас харахад бүтэн цагаар ажиллах таван гишүүн, туслах судлаачид бүхий бүрэлдэхүүнтэй үндсэн баг ажиллах тохиолдолд ОнАТБ-г дунджаар 12 сарын хугацаанд хийж гүйцэтгэх боломжтой.

Үүнээс бага хугацаанд хийсэн үнэлгээний тохиолдолд үр дүн төдийлөн бодитой бус, зарим чухал асуудлыг судалж амжихгүй байх магадлал өндөр. Энэ нь гэхдээ ОнАТБ үнэлгээг цахим хэлбэрээр эсвэл шуурхай үнэлгээ хэлбэрээр хийж болохгүй гэсэн үг биш.

Үнэлгээ хийх хугацаа нь санхүүгийн нөөц бололцоо, хүний нөөц, газарзүйн байршил, хамрах хүрээ зэргээс шалтгаална.

Өртөг зардал, төсвийн хэмжээ мөн үнэлгээний үйл явц, хамрах хүрээ ямар түвшинд байхаас хамаарна, тиймээс урьдчилсан байдлаар төсвийн тооцоо хийх шаардлага гарвал орон нутгийн түвшинд харьцуулсан зардлын тооцоо хийх нь гарч болзошгүй зардлыг тооцоход тустай. Зардлын тооцооны дийлэнх хэсэг нь судлаачдын цалин, мэдээлэл цуглуулах, том хэмжээний судалгаа зохион байгуулах, орон нутагт томилолтоор ажиллах, үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинар, олон нийтэд танилцуулах уулзалт, тайлан, мэдээлэл түгээх материал хэвлэх, тараах зэрэг үйл ажиллагаанд зарцуулагдана. Тиймээс эдгээр зардлыг нарийн тооцож, төсөвт оруулах нь чухал.

Зардлын хэмжээг бууруулах, аль болох өртөг, зардал багатай хийх нь үнэлгээ хийж буй бүх багийн хувьд чухал асуудал байдаг. Зардлаа хэмнэх хэд хэдэн арга байна. Үнэлгээний явцад хамтран ажиллах байгууллагуудаас мөнгөн бус хэлбэрээр дэмжлэг авах боломжтой. Жишээлбэл үнэлгээ хийх явцад, орон нутгийн зөвлөлийн зүгээс уулзалт, семинар зохион байгуулах танхим, өрөө гаргаж өгөх боломжтой. Хүний нөөцийн хувьд их сургуультай хамтран ажиллах нөхцөлд сургуулийн зүгээс сайн дурын оюутнууд томилон, мэргэжлийн судлаачид, эрдэмтдэд туслах судлаачаар ажиллуулах байдлаар дэмжлэг үзүүлж болно. Зочид буудлын хурлын танхим түрээслэн арга хэмжээ зохион байгуулснаас илүү сургалтын төв, сургуулийн хурлын танхим зэрэг газруудыг түрээслэх нь илүү өртөг багатай байдаг. Зардлын тооцоо хийхдээ үнийн харьцуулсан мэдээлэл цуглуулах хэрэгтэй.

Ажлын төлөвлөгөө эцэслэхээс өмнө төсөвлөсөн зардлын нийт хэмжээг өсгөх эрсдэлтэй үйл ажиллагаа тус бүрийг тодорхойлох хэрэгтэй бөгөөд нийт үнэлгээний ажлыг хойш татах, эсвэл төлөвлөснөөс илүү хугацаа шаардах магадлалтай ажлуудыг төлөвлөхдөө тусгайлан анхаарах хэрэгтэй хэд хэдэн хүчин зүйл, үйл явцдал байдаг. Үүнд юуны түрүүнд улс төрийн үйл явдал багтана. Ардчиллын үнэлгээнд нөлөөлж болохуйц улс төрийн аливаа үйл явдлыг аль болох эрт шатанд тооцоолох нь холбогдох шийдлийг шуурхай олж, үнэлгээний хэрэгжилтийн шатанд хэрэгжүүлэх боломж олгодог.

Нутгийн нөхцөл байдалд шинжилгээ хийх нь ОнАТБ үнэлгээний хамгийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг байдаг бөгөөд үнэлгээний үр дүнг нийтэд танилцуулахаас гадна ардчиллын чанар, төлөв байдлын үнэлгээг тогтмол хугацаанд хийх, хяналт үнэлгээ явуулдаг практик бий болгох, суурь үзүүлэлт боловсруулахад чухал үүрэгтэй. Үнэлгээ хийж буй багт тулгардаг нэг түгээмэл бэрхшээл бол үйл ажиллагаагаа бодитой төлөвлөх, нөхцөл байдлын дүн шинжилгээ болон ардчиллын үнэлгээнд чухал шаардлагатай мэдээлэл хооронд тэнцвэрт байдлыг хангах явдал байдаг. Энэ тохиолдолд үнэлгээний гурван тулгуур сэдвийн хүрээнд гол

анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй бөгөөд нөхцөл байдлын дүн шинжилгээ бол зөвхөн шаардлагатай суурь мэдээллийг цуглуулах үйл явц юм.

Хайрцаг 3.5

ОНАТБ олныг хамарсан илүү хүртээмжтэй гүйцэтгэх – зөвлөгөө

Орон нутгийн хүн амын онцлог шинж, байдлыг ойлгох: Тухайн орон нутагт амьдарч буй өөр хоорондоо ялгаатай хүн амын бүлэг тус бүрийг хамруулах боломж бололцоог судлах, үнэлгээний загварт тусгах, хүн амын ялгаатай шинж байдал тухайлбал хүйс, ажил мэргэжил, нийгэм-эдийн засгийн давхарга, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, үндэстэн, нутгийн уугуул иргэд гэх мэт шинж байдал ардчиллын төлөв байдлын үнэлгээний үйл явц, үр дүнд хэрхэн нөлөөлөх вэ гэдэгт дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

Үнэлгээний олныг хамарсан үйл явц: Нийгмийн цөөнхийн төлөөллийг үнэлгээний бүх үе шатанд оролцуулж, тэдний дуу хоолойг сонсох, өөрөөр хэлбэл үнэлгээний асуултуудыг боловсруулахаас үнэлгээний эцсийн тайлан, зөвлөмж боловсруулах үе шаг хүртэлх бүх үе шатуудад цөөнхийн төлөөллийг оролцуулахад анхаарч ажиллах хэрэгтэй.

Багийн ялгаатай бүрэлдэхүүн: Үнэлгээний үндсэн болон зөвлөх багийн бүрэлдэхүүнд хүйсийн тэгш төлөөллийг хангаж ажиллах хэрэгтэй. Зөвлөх багийн гишүүд дунд нийгмийн олон янз бүлгийн төлөөлөл оруулах, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, ахмад настнууд, шашны урсгалуудын төлөөлөл, нутгийн уугуул иргэд, үндэстэн ястны төлөөлөл багтах ёстой.

Судалгааны арга, аргачлалын төрөл: Үндсэн болон зөвлөх багийн гишүүд судалгааны шатанд тухайн орон нутгийн иргэд, хүн амыг бүрэн хэмжээнд төлөөлж чадахуйц мэдээлэл цуглуулах аргазүй, аргачлалыг судалгаандаа нэвтрүүлэх хэрэгтэй. Тухайлбал, албан ёсны тооллого, цагаач, иргэний бичиг баримтгүй учраас судалгаанд хамрагдалгүй үлдсэн хүн амын тодорхой бүлэг эсвэл бичиг үсэг тайлагдаагүй иргэдийн үзэл бодол, байр суурийг тодорхойлохын тулд ганцаарчилсан ярилцлага, зорилтот бүлгийн ярилцлага гэх мэт чанарын судалгааны аргуудыг ашиглах боломжтой. Ингэснээр тоон болон чанарын судалгааны аргыг хослуулах боломж бүрдэх юм.

Орон нутгийн хэл дээр материал хэрэглэх, орчуулах: Хэл, соёлын хувьд өөр бүлгийг төлөөлсөн, тухайн үндэсний цөөнхийн хэл, аялгаар ярьж чаддаг хүний үнэлгээний багт оруулах нь зүйтэй. Тиймээс төсвийн тооцоо хийхдээ энэ зардлыг хангалттай сайн тусгах хэрэгтэй.

Тусгай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх: Үнэлгээний холбогдох шатанд нийгмийн зарим бүлгийн оролцоог хангахын тулд тэдний тусгай хэрэгцээ, шаардлагыг хангах шаардлага гардаг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдийн оролцоог

Хайрцаг [үрг.]

хангахын тулд аливаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа тэргэнцэртэй хүн чөлөөтэй нэвтрэх боломжтой байр, танхим сонгох, дохионы хэл мэддэг туслах ажилтан байлцуулах гэх мэт тусгай хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тооцох хэрэгтэй.

Нууцлал: Хууль бус цагаач, иргэний бичиг баримтгүй хүмүүс гэх мэт нийгмийн олон янз бүлгийг төлөөлөх хүмүүстэй уулзалт, ярилцлага зохион байгуулахдаа хувь хүний нууцыг хадгалахтай холбогдсон хууль, дүрэм, журмыг нарийн баримтлах ёстой.

Холбогдох мэдээллийг задлах: Мэдээллийг хүйсээр задлан ангилах нь зайлшгүй хийгдэх ёстой ажлын нэг мөн. Харин судалгааны мэдээллийг бодлого боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх зорилгоор хүн ам зүйн бүлэг, ялгаатай шинж байдлаар нь ангилан задлах нь тусгайлан анхаарах ёстой асуудал юм. Өөрөөр хэлбэл хувь хүнтэй холбоотой мэдээллийг ийнхүү задлан шинжлэхийн давуу болон сул талыг харьцуулан үзэж, нарийн тооцсоны үндсэн дээр шийдвэр гаргах хэрэгтэй (хайрцаг 2.7-д орсон сэрэмжлүүлэх мэдээллийг харах).

Олон нийтэд танилцуулах

Төлөвлөлтийн шатанд хийгдэх албан ёсны олон нийтэд танилцуулах үйл ажиллагаа нь уг үнэлгээний талаар олон нийтийн ойлголт мэдээллийг сайжруулах зорилготой. Үнэлгээний багийн гишүүд, гол оролцогч талууд, хэвлэл мэдээллийнхэн оролцсон нийтийн арга хэмжээг зохион байгуулдаг. Энэхүү албан ёсны нээлтийг хийснээр иргэдийн дунд үнэлгээний талаар өргөн хүрээний ойлголтыг өгч, энэ асуудлаар холбоо тогтоох зорилго хэрэгжиж эхэлдэг.

3.4. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх

Энэ хэсэгт ардчиллын үнэлгээний гол үйл явцтай холбоотой асуудлыг авч үзэх ба мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг ажил хийгддэг.⁴⁸

Мэдээлэл цуглуулах арга техникийг сонгох

Орон нутгийн ардчиллын үнэлгээг хийхдээ чанарын болон тоон мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх аргуудыг аль алиныг нь хэрэглэх боломжтой. Чанарын судалгааны олон аргууд, тухайлбал, ганцаарчилсан ярилцлага, оролцооны ажиглалт, болсон явдлын талаар мэдээлэл авах, фокус бүлгийн ярилцлага, үндэсний хэмжээний семинар, орон нутгийн түвшинд хурал зохион байгуулах зэргээр ардчиллын талаарх иргэдийн ойлголт, туршлага, цаашлаад ямар төрлийн шинэчлэлийг хийх шаардлагатай байгаа талаар мэдээллийг олж авах боломжтой. Нийтийн цахим эх сурвалж гэдэг нь ямар нэгэн сэдэв, ажил дээр цахим хэлбэрээр төлбөртэй ба төлбөргүйгээр

олон бүлэг хүмүүсийн мэдлэг, туршлагаа хуваалцсаны үндсэн дээр мэдээлэл олж авах аргыг хэлдэг бөгөөд судалгааны салбарт мэдээлэл олж авах, хөрвүүлэх, дүн шинжилгээ хийх зэрэгт энэ аргыг өргөн хэрэглэх болсон.

Ардчиллын тодорхой зураглалыг гаргах зорилгоор тогтолцооны тулгууруудаас өөр өөр үзүүлэлтийг сонгон авч чанарын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх байдлаар чанарын судалгааны аргад нэмэлтээр ашиглаж болдог. Тоон болон чанарын аргуудыг хослуулах нь аливаа үнэлгээнд тулгардаг хязгаарлагдмал эх сурвалжид багтаан ардчиллын туршлагын талаарх дүр зураглалыг аль болох баялаг, бодитоор дүрслэн гаргах зорилготой.

Тоон судалгааны арга нь зарим тохиолдолд чанарын судалгааны арга дээр нэмэлт байдлаар хэрэглэгдэж болдог. 2002 онд Өмнөд Африкийн зүүн хэсэгт хийгдсэн ОнАТБ үнэлгээний нэг бүрэлдэхүүн хэсэг нь 22 хотын захирагчдын дунд хийсэн судалгаа байсан бөгөөд уг судалгаагаар тэдний удирдаж буй хотод нь тулгарч буй засаглалын асуудал, засаглалын үйл явцад орон нутгийн ардчилал хэрэгждэг арга замыг тодорхойлсон байна. ММАБ дахь ОнАТБ үнэлгээнд 4000 гаруй иргэнийг, Египтэд 500 иргэдийг тус тус судалгаанд хамруулсан байна. Эдгээр судалгаанд ОнАТБ үнэлгээний эхний хувилбарын зарим асуултуудыг ашигласан. Судалгааны ажил өртөг, зардал ихтэй байдаг учраас судлаачид байгаа мэдээллээ ашиглан, нэмэлт санхүүжилт олох, гол оролцогч талууд нэг дор цугларсан ямар нэгэн арга хэмжээний үеэр судалгааг авах зэрэг аргуудыг хэрэглэдэг.⁵⁰

Хайрцаг 3.6

Арабын ертөнцийн Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээ: Египт, Иордан, Морокко, Йемен улсуудын зарим туршлагаас

2010 онд “*Арабын ертөнцийн Орон нутгийн түвшин дэх ардчилал*”⁵¹ гэсэн судалгааны тайлан гарсан бөгөөд энэ тайланд газар дээр нь үнэлгээ хийж буй судлаачдын багт тулгардаг саад бэрхшээлүүдийг дэлгэн гаргасан байдаг.

Зарим багийн хувьд тухайн үнэлгээнд шаардлагатай мэдээлэл нь олддоггүй эсвэл байгаа мэдээлэл нь эрх бүхий байгууллагаар баталгаажуулаагүй байдаг зэргээс шалтгаалаад үнэлгээнд шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг олж авахад бэрхшээлтэй байсан талаар дурдсан байна. Жишээлбэл, санхүүгийн болоод удирдлагын авлигын талаар мэдээлэл цуглуулах нөхцөлд мэдээлэл ил тод бус, мэдээллийн систем сул хөгжсөнөөс үүдэлтэй бэрхшээл тулгардаг болох нь батлагдсан байна. Иймээс зарим судлаачдын баг албан бус аргаар мэдээлэл цуглуулах аргыг хэрэглэж, орон нутгийн засаг захиргааны нэгжийн судалгааны багийн гаргасан тооцооллыг ихэвчлэн ашиглахад хүрсэн. Захиргааны болон хамгааллалтын шинжтэй хориг эсвэл үнэлгээний багаас өгсөн асуултанд орон нутгийн зөвлөл, эрх бүхий байгууллага удаж байж хариу өгдөг зэрэг өөр бусад тулгардаг бэрхшээлүүдийг дурдсан байна. Зарим орон нутаг, байгууллагын хувьд хэрэгцээтэй байгаа хөгжлийн асуудлыг эрэмбэлэх тал дээр нэгдсэн саналд хүрээгүй

Хайрцаг [үрг.]

байх тохиолдолд гардаг ба “Бид чухам юуг хүсч байна вэ?” гэсэн асуултанд хариулахад бэлэн бус байдаг.

Гэсэн хэдий ч эл саад, бэрхшээлүүдээс үл хамааран, аливаа үнэлгээг гүйцэтгэх явцад эсвэл үндэсний хурал, цуглааны үеэр тайлангийн үр дүнг ардчиллын шинэчлэлийн хөтөлбөрт хэрэглэх шаардлагатайг шийдвэр гаргагчид, албан болон албан бус олон салбарын оролцогч талууд удаа дараа тэмдэглэж байв.

ОнАТБ нь ямарч судалгааны аргыг ганцхан зөв аргачлал хэмээн үздэггүй ба үнэлгээг гүйцэтгэгчид судалгааны өөрсдийн гэсэн арга барилыг боловсруулан ажилладаг. Үндсэн үнэлгээний баг нь мэдээлэл цуглуулах арга хэлбэрийг сонгох талаар эцсийн шийдвэрийг гаргаж, мэргэжилтнүүдийн багийн зүгээс өгөх санал, зөвлөмжийг тусгах эсэхийг харгалзан үзэх үүрэгтэй байдаг.

Мэдээлэл цуглуулах техник бүр нь аль болох оролцоог хангасан мэдээлэл цуглуулах үндсэн нэг зорилттой байдаг. Түүнчлэн, үнэлгээг гүйцэтгэгчид нь мэдээлэл цуглуулах аргачлал олон хэлбэртэй байх, өөр өөр аргаар цуглуулсан мэдээллийн гурвалжин үүсгэх, мөн жендерийн мэдрэмжтэй, задаргаа бүхий мэдээлэл цуглуулах нь чухал болохыг анхаарах хэрэгтэй. Нас, орлого, шашин шүтлэг, угсаатан зүй, хүйсийн ялгаа зэрэг нийгмийн өөр өөр ангиллын талаар асуудлыг хөндөх нь ихээхэн шүүмжлэлд өртдөг (Хайрцаг 2.7-г харар).

Хайрцаг 3.7

Бичиг баримтын судалгааг хийх

Бичиг баримтын судалгаа гэж ном зохиол, мэдээлэл, үндэсний аудитын тайлан, олон улсын болон үндэсний статистик, иргэдийн гомдол шийдвэрлэх байгууллагын тайлан, хүний эрхийн байгууллагын тайлан, мэргэжлийн холбоодын боловсруулсан түншийн үнэлгээ, шинжлэх ухааны байгууллагын судалгаа, хяналт үнэлгээний байгууллагын ажиглалт, дүгнэлтүүд, тусгай илтгэгчдийн тайлан, сонгуулийн ажиглалтын дүгнэлт, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарын хяналт, дүгнэлт зэрэг бэлэн мэдээллийг ашиглаж гүйцэтгэхийг хэлдэг. Гэхдээ бодит байдал дээр орон нутгийн нэгжийн талаарх мэдээллийг цахим хэлбэрээр хайж олж авна гэдэг бэрхшээлтэй байдаг. Энэ нь үндэсний болон орон нутгийн түвшний мэдээллийн эх сурвалж болоод ОнАТБ ямар чухал болохыг онцлон харуулж байгаа юм.

Ардчиллын төлөв байдлын үнэлгээний талаар цахим хуудас зэрэг эх сурвалжаас холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр олж авах боломжтой. <<http://www.idea.int/>>.

Мэдээллийг тайлбарлах, дүн шинжилгээ хийх, дэлгэрүүлж бичих

Цуглуулж, бэлтгэсэн материалаа дараалалд оруулах нь “түүхээ ярих” нийт үйл ажиллагааны нэг хэсэг болдог учраас энэ үе шат нь тайлангийн агуулгыг бичих үйл явцтай давхцаж болно. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон түүхийн дүрслэлийг бий болгох явцад 2 асуудал урган гарч ирэх ханлагатай байдаг. Нэгдүгээрт, өөр өөр эх сурвалжаас цуглуулсан мэдээллүүд нь хоорондоо нийцэхгүй байх эсвэл давхцах тохиолдлууд гарч ирэх ба энэ асуудал болон зөрчлийг шийдвэрлэхийн тулд нэмэлт мөрдлөгө, судалгаа хийх хэрэгтэй болно. Хоёрдугаарт, бодит баримтад дутагдаад байгаа зүйл, завсардал гарч болох бөгөөд баримт, мэдээллийг бүрэн болгохын тулд нэмэлт мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох шаардлагатай болдог.

- **Ном зүйг бичих**

Ном зүйг бичих хамгийн хялбар арга бол ОнАТБ бүтцээс хэсэг тус бүрээр нь салган авч стандарт ном зүйн хайлтыг хийх явдал юм. Засгийн газрын байгууллагын цахим эх сурвалж, албан ёсны статистикийн үйлчилгээ, санал хураах байгууллага, ТББ, мэдээний тайлан зэрэг нь илүү олдоцтой байдаг.

- **Мэдээллийг ялгаж ангилах**

Туршлагаас харахад мэдээллийн эх сурвалжууд нь үнэлгээний бүтцийн тодорхой хэсэгт бүхлээрээ хамааралтай байхгүй ч түүн доторх 1-ээс илүү асуултад хамаатай байдаг. Ихэнх мэдээллийн эх сурвалжууд нь нэгээс илүү асуултад хариулагдахуйц мэдээлэлтэй байдаг учраас хэсэг хэсгээр нь ажиллахыг зөвлөдөг. Дүн шинжилгээ хийх болон мэдээллийн гурван талт байдлыг хангах зорилгоор хамгийн тохиромжтой мэдээллийн эх сурвалжийг сонгон ашиглах нь үнэлгээний багийн үүрэг юм.

- **Нэгж хэсгүүдийг эрэмбэлэн ангилах**

Энэ бол цуглуулсан материалыг ангилах үе шат бөгөөд тухайн асуудал хэдий төвөгтэй байлаа ч түүний талаар илүү тодорхой түүхийг бичих эсвэл зураглал гаргах боломжийг олгодог. Энэ үе шатанд асуулганд тусгасан ардчиллын үнэ цэнэтэй холбоотой асуулт болон анхан шатны асуултуудаа эргэн харах нь зүйтэй. Ингэвэл нэгж хэсгүүд нь ерөнхий үнэлгээний хүрээнд хамгийн сайн гэж харагдах байдлаараа сэдэв, түүхийнхээ эрэмбэ, ач холбогдлоороо ангилагдах боломжтой. Үнэлгээний асуултын хариултын талаар бодох нэг арга бол баримтыг зохион байгуулсан, хураангуйлсан шүүмж хийж үзэх явдал юм. Энэ нь шүүмжийг илүү системтэй аргаар дэлгэрүүлж, тайлбарлах боломжийг олгодог.

- **Мэдээлэл, дүгнэлт, үзэл бодлын зөрүүтэй байдлыг хүлээн зөвшөөрөх**

Бодит байдал дээр, үнэлгээний явцад цуглуулсан мэдээ, мэдээлэл, үр дүнг нэгтгэх, тайлан зөвлөмж боловсруулах нь төдийлөн хялбар биш бөгөөд багийн гишүүд хооронд үзэл бодлын зөрчил үүсэх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд үзэл бодлын зөрүүтэй байдлаа нээлттэй илэрхийлж, тайлангийн холбогдох хэсэгт агуулга, дүгнэлт,

үр дүн, үзэл бодлын хувьд зөрүүтэй мэдээллийн эх сурвалжийг тодорхой бичих (жишээ нь: засгийн газрын/ бие даасан судалгааны байгууллагын эх сурвалж гэх мэт); үзэл бодол, байр суурийн хувьд зөрүүтэй байгаа асуудлын нөхцөл байдлыг дүн шинжилгээ болон үнэлгээний тайландаа тусгаж ажиллах нь зүйтэй.

Хэд хэдэн эх үүсвэрээс мэдээлэл цуглуулах, зөвлөгөө өгөх багийг зөвлөх үүргийнх нь дагуу ажиллуулах, семинарын явцад зарим маргаантай асуудал дэвшүүлэн хэлэлцүүлэх зэрэг аргууд нь үнэлгээний үндсэн багт зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргахад хялбар болдог байна.

3.5. Тайлан бичих, зөвлөмж боловсруулах

Дээр дурдсан үнэлгээний үе шатуудын дараа үндсэн тайлан бичих үе шаг эхэлнэ. Энэ шатанд тайлангийн загвар, хэмжээ, дагалдах хавсралтууд гэх мэт асуудлаар эцсийн шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болдог.

Тайлангийн төсөл бичих

Эцсийн тайлан нь зөвхөн үнэлгээнд хамрагдсан орон нутаг дахь ардчиллын төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний үндсэн үр дүнг тайлагнахад чиглэнэ. Гэхдээ хэд хэдэн орон нутагт ардчиллын чанар, төлөв байдлын үнэлгээ хийсэн байж болно. Энэ тохиолдолд орон нутгийн засаг захиргаа тус бүрээр тусгайлсан гэхдээ харьцангуй богино тайлан боловсруулж, эдгээрийг нэгтгэсэн үндэсний хэмжээний нэг тайлан боловсруулж болно. Ийнхүү хэд хэдэн орон нутагт ардчиллын төлөв байдлын үнэлгээг зэрэг хийх нь зөвхөн орон нутгийн түвшинд тулгарч буй асуудлыг тодорхойлж, холбогдох зөвлөмж боловсруулах бус, бусад орон нутагт мөн тулгарч буй нийтлэг бэрхшээлийг тодорхойлж, орон нутгийн засаг захиргаад хамтран асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог. Тиймээс тайлангийн төсөл бичихэд үнэлгээний бүх шатанд хийсэн судалгаа, цуглуулсан мэдээ, мэдээлэл, дүн шинжилгээг нэгтгэн, үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинарын үеэр хэлэлцүүлж, баталгаажуулах урьдчилсан дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулах хэрэгтэй. Тайланд ург, дэлгэрэнгүй бичвэр бүхий мэдээллийг жирийн уншигчдад ойлгомжтой, хялбаршуулсан хэлбэрээр бичих, хүснэгт, хураангуй, эшлэл, жишээ, хувийн түүх зэргийг багтаах хэрэгтэй. Хүснэгтээр илэрхийлсэн мэдээллийг задалж, дэлгэрэнгүй хэлбэрээр үзүүлэх хэрэгтэй. Тайлангийн танилцуулга хэсэгт үнэлгээг хийх болсон шалтгаан, ардчиллын төлөв байдлын үнэлгээ нь тухайн орон нутгийн онцлог, шинж байдлыг хэрхэн тусгасныг тайлбарлах, ардчилсан хөгжил, улс төр, соёлын уламжлалт харилцаа, хамтын ажиллагаа, үйл явцын талаар хийгдсэн сүүлийн үеийн судалгааны тойм зэргийг дурдах хэрэгтэй.

ОнАТБ-г үнэлэх ажлын үндсэн зорилгын нэг бол ардчиллын сул болон давуу талыг тодорхойлох, орон нутгийн ардчиллын чанарыг сайжруулахад чиглэсэн, нотолгоонд суурилсан санал, зөвлөмж боловсруулахад оршино. Үнэлгээний үндсэн үр дүнд, зөвлөмжүүдийг нэгтгэн, тайлангийн товч, хураангуй хувилбар боловсруулах нь илүү өргөн хүрээнд олон уншигчдад хүргэх нэг хэлбэр юм.

Зөвлөмж боловсруулах

Орон нутгийн ардчиллын үнэлгээний үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулахад дараах зөвлөлгөөг анхаарч ажиллах нь зүйтэй.⁵²

1. Орон нутгийн түвшинд ардчиллын хөгжлийг дэмжихэд чиглэсэн нэн тэргүүний тулгамдсан асуудлыг тодорхойлох, асуудлыг дунд болон урт хугацаанд шийдвэрлэх бодит шийдлийг шуурхай боловсруулах.
2. Нутгийн засаг захиргаа, иргэд олон нийт өөрсдийн нөөц бололцоогоор шийдвэрлэх боломжтой асуудлууд хийгээд холбогдох талуудын оролцоо, дэмжлэг туслалцаа шаардлагатай асуудлыг тус тусад нь тодорхойлох.
3. Зөвхөн сул тал, тулгамдсан асуудлуудыг анхаарах бус давуу талуудыг нь онцлох, түүнд үндэслэн холбогдох санал, зөвлөмж боловсруулах.
4. Хувь хүний зан төлвийн хувьд өөрчлөлт шаардсан асуудал, институцын түвшинд өөрчлөлт шаардсан асуудал, бодлогын шинж чанартай өөрчлөлт шаардсан асуудал гэх мэт байдлаар асуудлуудыг ангилах.
5. Үнэлгээний үр дүнд үндэслэн боловсруулсан аливаа санал, зөвлөмж нь асуудлыг системтэй, нэгдсэн байдлаар шийдвэрлэх арга зам, нөөц бололцоог тодорхой тайлбарласан байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээг шууд жагсаан бичих бус асуудал бий болсон шалтгаан, нөхцөл зэргийг тодорхойлж, улс төрийн хүчин, иргэний нийгмийн байгууллага болон жирийн иргэдийн оролцоотойгоор цогцоор шийдвэрлэх арга замыг тодруулах нь илүү үр дүнтэй.
6. Засаглалын бүх түвшинд тохирсон бодлогын зөвлөмж боловсруулах (жишээ нь: орон нутаг, бүс нутаг, үндэсний түвшинд гэх мэт).
7. Санал, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын дараалал, цаг хугацааг харуулсан ерөнхий зураглал бий болгох, ардчиллын төлөв байдал, хөгжил дэвшилд хяналт, мониторинг хийх арга, аргачлал боловсруулах (үүнд нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлууд, холбогдох шийдлүүд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг багтана.

Богино, дунд, урт хугацааны шийдлүүдийг тодорхойлох

Орон нутгийн түвшинд хэрэгжүүлж болох үйл ажиллагаа, зөвлөмж нь хэрэгжүүлж болохуйц, амьдралд ойрхон, цаг хугацаа, өртөг зардлын хувьд орон нутгийн нөөц бололцоонд тохирсон байх ёстой. Тиймээс үнэлгээний хүрээнд гарах санал, зөвлөмжүүдийг дараах байдлаар боловсруулах нь тохиромжтой.

Богино хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжүүд

Үүнд бодлого, хууль эрх зүйн орчны томоохон боловч цөөн өөрчлөлт шаардсан, өртөг зардал багатай, шууд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаа, шийдлүүд багтана.

Дунд хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжүүд

Үүнд бодлого, хууль эрх зүйн болон засаг захиргааны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт, шинэчлэлт хийхийг шаардсан, харьцангуй их өртөг зардал шаардсан арга хэмжээ, үйл ажиллагаа багтана.

Урт хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжүүд

Орон нутгийн хэмжээнд бүтцийн томоохон өөрчлөлт, шинэчлэл хийх, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, их хэмжээний өртөг, зардал шаардсан, захиргааны болон санхүүгийн шинэчлэл хийхэд чиглэсэн үйл ажиллагаа үүнд хамаарна.

Үнэлгээний үр дүнг баталгаажуулах семинарт танилцуулахаас өмнө тайлангийн төслийг зөвлөх багийн гишүүдэд танилцуулж, холбогдох засвар, өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй.

Хайрцаг 3.8

Кап-Хайтиэн хотын ардчиллын үнэлгээ, холбогдох зөвлөмжүүд

2010 онд Гайти улсын Кап-Хайтиен хотод орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээг хийжээ. Тус үнэлгээний ажлын явцад оролцооны ардчиллыг хөгжүүлэх чиглэлээр дараах гурван зөвлөмжийг боловсруулсан байна:

Богино хугацаанд хэрэгжүүлэх

Ил тод байдал: Орон нутгийн захиргаанд төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах үүрэг хүлээлгэх.

Нээлттэй байдал: Улс төрийн үзэл суртал, анги давхарга, шашин шүтлэг болон нийгмийн бусад хүчин зүйлийн нөлөөнөөс ангид менежментийн төлөвлөгөө боловсруулах

Иргэд, олон нийтийг сонсох: Орон нутгийн захиргааны зүгээс авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн арга хэмжээ, гаргасан санал санаачилга, чухал шийдвэрүүдийг нэгтгэж, сар тутам нягтлан үзэх

Дайчилгааны үйл ажиллагаа: Иргэний боловсрол олгох кампанит ажил зохион байгуулах, орон нутгийн засаглалыг хөгжүүлэхэд иргэдийн оролцоог дэмжих үйл ажиллагаа

Хариуцлагатай байдал: Хотын захиргаанд төлөх ёстой татвар төлөлт (зөвшөөрөл, гэх мэт).

Хайрцаг [үрг.]

Дунд хугацаанд

Шударга байдал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг нийгмийн тогтолцоонд нэгтгэх суурь баазыг бий болгох гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, үйлчлүүлэх таатай орчин бүрдүүлэх.

Нээлттэй байдал: Хотын захирагчийн албаны бүтцэд орон нутгийн ардчиллыг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа, иргэд, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх үйлчилгээ бий болгох.

Ил тод байдал: Нийгмийн бүх салбарыг төлөөлсөн иргэдийн хороог сайн дурын үндсэн дээр байгуулж, орон нутгийн засаг захиргааны зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, санал санаачилгын хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоо бий болгох.

Дайчилгааны үйл ажиллагаа: Зөрчил, маргаан шийдвэрлэх, байгаль орчин хамгаалах, түүхэн дурсгалт газруудыг хамгаалах, орон нутгийн аялал жуулчлал хөгжүүлэх, ядуу иргэдэд нийгмийн халамж үзүүлэх зэрэг чиглэлээр сайн дурын үйл ажиллагаа явуулдаг иргэний хороодын үйл ажиллагааг нэгтгэх.

Урт хугацаанд

Дайчилгааны үйл ажиллагаа: Орон нутгийн хөгжил, ажил эрхлэлтийг дэмжихэд хувийн салбар хувь нэмрээ оруулах, шаардлагатай арга хэмжээг авах.

Дайчилгааны үйл ажиллагаа: Иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн захиргаатай хамтран бодитой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

3.6. Үр дүнг баталгаажуулах семинар ба тайлан эцэслэх

Үр дүнг баталгаажуулан семинарын үеэр гол оролцогч талууд тайлангийн эхний хувилбарыг шүүмжлэлтэйгээр хэлэлцдэг. Энэхүү үр дүнг баталгаажуулах семинарууд нь үнэлгээний ерөнхий дүн шинжилгээ, үр дүнг орон нутгийн нэгжийн төлөөлөл эцэслэхээс өмнө хийгдэх учиртай. Улс төр, иргэний нийгэм, нийгмийн цөөнхийн бүлгээс тайлбар авах болоод хэвлэл мэдээллийнхнийг оролцуулах нь үнэлгээний тайлангийн чанар, онцлог байдал, нөлөөллийг нэмэгдүүлж байдаг. Семинарт олон салбарын төлөөлөл болсон оролцогч талуудыг хамруулах нь ашигтай байдаг ба үнэлгээнд оролцогчдын тоо нэмэгдсэнээр илүү өргөн хүрээний, олон төрлийн байр суурийг харуулдаг. Улмаар ОнАТБ-ын тайлангийн үндэслэгээ, жам ёсны шинжийг нэмэгдүүлнэ.

Үр дүнг баталгаажуулах семинарыг зохион байгуулах

Үр дүнг баталгаажуулах семинарыг ихэвчлэн орон нутгийн түвшинд зохион байгуулдаг. Гэхдээ орон нутгийн ажилчдаас гадна семинарыг зохион байгуулагчид нь орон нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөлөл, хөрш дүүргийн төлөөлөл, улс төрийн намуудын төлөөлөл, үндэсний удирдагчид, иргэдийн гомдол барагдуулах албаны төлөөлөл зэрэг үндэсний түвшний илүү олон оролцогч талуудыг хамруулах давуу талтай байдаг. Зарим тохиолдолд үндэсний түвшний үр дүнгийн баталгаажуулалтын семинарыг зохион байгуулах шаардалагатай болдог. Тухайлбал, орон нутгийн нэгжийн хэд хэдэн төлөөллийг нэгэн зэрэг үнэлгээнд хамруулсан тохиолдолд Үндэсний түвшний ардчиллын үнэлгээний дүр зураг үүгээр илэрхийлэгдэж болох юм.

Үр дүнгийн баталгаажуулалт нь тайлангийн эхний хувилбар дээр залруулга, тодруулга хийх, нэмж сайжруулах санал гаргах, эсвэл үнэлгээнд хэрэглэсэн аргачлалын талаар эсэргүүцэл илэрхийлэх зэрэг санал зөвлөмж, тайлбарыг авах зорилготой. Үр дүнгийн баталгаажуулалтын семинарыг өгөөжтэй болгохын тулд уулзалтын хөтөлбөр, тодорхой чиглүүлэх асуултуудыг боловсруулахаас эхлээд идэвхтэй зохицуулалт, жендерийн мэдрэмжтэй аргачлал, салбарын болоод бүлгийн олон төрлүүд, улс төрийн хөдөлгөөн, хурлын тэмдэглэл хөтлөх (зарим оролцогч тэмдэглэлд дурдуулах хүсэлгүй байдгийг хүндлэх хэрэгтэй), албан бус хэлэлцүүлэг явуулах газрыг сонгох зэрэг олон асуудлыг сайтар бодож, оновчтой зохион байгуулах хэрэгтэй. Энэ бол багийн гишүүд бүрэн санал нийцсэн байх ёстой гэсэн үг биш бөгөөд аливаа ОнАТБ-ын үнэлгээний тайланд саналын зөрүүтэй хувилбарууд болон цөөнхийн бүлгийн саналыг дурдах тодорхой орон зай гаргах нь зүйтэй гэсэн санаа юм.

Үнэлгээний тайланг эцэслэх

Үр дүнг баталгаажуулах семинараас өгсөн зөвлөмж, дүгнэлт, шүүмжийг үндэслэн (ихэвчлэн 1-с олон удаа зохион байгуулагддаг) тайланг эцэслэн боловсруулдаг. Тиймээс үр дүнг баталгаажуулах семинаруудаас гаргасан зөвлөмжийг эцсийн тайландаа тусгах хангалттай цаг хугацааг төлөвлөх нь зүйтэй.

3.7. Хэвлэн нийтлэх, түгээх, шинэчлэлийн төлөөх ухуулга, сурталчилгааны ажил

ОнАТБ нь шинэчлэл-үйл ажиллагаанд чиглэсэн үнэлгээний тогтолцоо юм. Үнэлгээний үр дүн нь дан ганц орон нутгийн ардчиллын чанарт нөлөөлж буй асуудлын талаар иргэдэд мэдээлэл өгөх бус орон нутаг дахь ардчилсан шинэчлэлийг эхлүүлэх эсвэл орон нутгийн нэгжийн хүрээнд боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх цэг нь болж байх ёстой. Ийм ч утгаараа, нэгдүгээрт, тайлангийн дүгнэлт нь хүнд ойлгомжтой, шийдвэр гаргагч, иргэдийн бүлгүүд авч хэрэглэхэд боломжтой,

хүртээмжтэй байдлаар нийтэд түгээгдэх ёстой. Хоёрдугаарт, ардчилсан үйл явцыг сайжруулах талаар зөвлөмж дүн шинжилгээг орон нутгийн иргэдийн дунд тархаан дэлгэрүүлэх нь чухал байдаг. Гэхдээ бодит шинэчлэлийг хийх боломжийг нэмэгдүүлэхийн тулд үнэлгээний тайланд зайлшгүй сайжруулах шаардлагатай гэж дурдсан бодлогын стратегийн сурталчилгаатай хавсарч мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

Хэвлэгдэн гарах бүтээлийн форматыг сонгох

Мэдээллийг зорилтот үзэгчиддээ хүргэх хэлбэрийг сонгох нь маш чухал асуудал. Зорилтот үзэгчдээс хамаараад тайлангийн хураангуй, сэдэвчилсэн тайлан эсвэл баримтат хуудас, хэвлэлийн мэдээ, тайлангийн хялбаршуулсан хувилбар зэрэг хэлбэрүүдээс сонгож болно. Эдгээр нийтлэл нь үнэлгээний гол дүгнэлтийг агуулсан байх хэрэгтэй ба орон нутгийн олон хэл дээр бэлтгэгдсэн байх хэрэгтэй. Ингэснээр нийгэмд байгаа өөр өөр бүлгүүд үүнийг уншиж ойлгох боломжтой болно. Энэ материалыг хэвлэн тараахаас гадна зөөлөн хэлбэрээр буюу цахим ертөнцөд мөн байршуулах нь зүйтэй.

Мэдээлэл түгээх болон сурталчилгааны стратегийг хэрэгжүүлэх

Олон нийтэд зорилсан материалыг бэлтгэн хүргэсний дараагаар үнэлгээнд хамрагдсан орон нутгийнханд зориулан орон нутгийн болоод үндэсний түвшинд нийтийг хамарсан нээлтийн арга хэмжээг зохион байгуулах нь мэдээлэл түгээх сайн арга замуудын нэг юм. Тайлангийн талаар олон нийтийг хамарсан нээлтийн арга хэмжээ зохион байгуулахдаа орон нутгийн зорилтот иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийнхнийг оролцуулах хэрэгтэй.

Энэ шатанд үнэлгээний тайланд орсон үндсэн үр дүн, холбогдох санал зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулах замаар олон нийттэй хуваалцах, богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны зөвлөмжийг холбогдох талуудад мэдээлж, тэдний дэмжлэгийг авах ажлуудыг гүйцэтгэнэ.

Өөрөөр хэлбэл, энэ шатанд мэдээлэл түгээх ажлыг зорилтот бүлэгт илүү чиглүүлэх, орон нутгийн болон үндэсний түвшинд хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулагчидтай түлхүү хамтран ажиллаж, тэдний анхаарлыг татах, улмаар шаардагдах шинэчлэлийн үйл явцыг эхлүүлэхэд дэмжлэг авахад анхаарч ажиллах нь чухал.

Үнэлгээний үр дүнг тархаах үйл ажиллагаа нь зөвхөн нэг удаагийн хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах, тайлан хэвлэх зэргээр хязгаарлагдах учиргүй бөгөөд мэдээлэл тархаалтын олон арга хэрэгслийг ашиглах хэрэгтэй. Үүнд:

- Улс төрийн намын орон нутаг дахь төлөөлөл, манлайлагчид, залуучуудын төлөөлөл, эмэгтэйчүүдийн байгууллага, тинк танк судалгааны байгууллагуудад зориулсан товч уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Орон нутгийн зөвлөлийн гишүүд, хотын захирагч, орон нутгийн засаг захиргаааны ажилтнууд оролцсон нээлттэй сонголт.
- Орон нутгийн судлаач, бодлогын шинжилгээ хийдэг эрдэмтэдтэй уулзалт зохион байгуулах.
- Иргэний боловсролыг дэмжих, төвлөрлийг сааруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага болон үндэсний засгийн газрын холбогдох байгууллагатай тайлангийн үр дүн хуваалцах.

Мэдээлэл тархаах, ухуулга сурталчилгаа хийх арга замыг сонгохдоо тухайн орон нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, иргэд олон нийтэд илүү хүрсэн хэвлэл мэдээллийн сувгийг түлхүү ашиглах нь зүйтэй. Дээр дурдсаны дагуу үнэлгээний үр дүнг олон нийтэд хүргэх, ухуулга сурталчилгаа явуулах стратегийн гол зорилго нь орон нутаг, бүс нутаг, үндэсний түвшинд шийдвэр гаргагч талуудад үнэлгээний үр дүнг хүргэх, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөхөд оршино. Ухуулга сурталчилгааны ажлыг үнэлгээ хийсэн багийн гишүүд дунд явуулах, үр дүнг багийн гишүүдэд, орон нутгийн засаг захиргаанд харьяалагддаг бусад газар, хэлтсийн албан хаагчдад танилцуулах нь мөн чухал ач холбогдолтой.

Үнэлгээний эцсийн үр дүнг нийгмийн цөөнх, эмзэг бүлгийн төлөөлөлд хүргэх, мэдээлэл ажлыг тусгайлан зохион байгуулах хэрэгтэй.

Мэдээлэл түгээх, ухуулга сурталчилгаа явуулах хамгийн сайн стратегийг хэрэгжүүлсэн ч улс төрийн нөхцөл байдал хэрхэн эргэхийг бид таамаглаж чадахгүй. Улс төрийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж, ямар шинэ боломж, бололцоо гарч ирнэ тэр хэмжээгээр шинэ асуудал, саад бэрхшээл тулгардаг.⁵⁴ Тиймээс үнэлгээг эцэслэн дуусгаснаас хойш хэсэг хугацааны дараа зөвлөмжийн дагуу хийж амжилттай гүйцэтгэсэн ажлууд юу байв, ямар арга хэмжээг ямар хэлбэрээр зохион байгуулж, сайжруулах боломж байсан, дараагийн үнэлгээнд тусгайлан анхаарах шаардлагатай ямар асуудлууд байгааг тодорхойлох нь чухал ач холбогдолтой.

Хайрцаг 3.9

Шинэчлэлийг хэрхэн сурталчлах вэ?

Ухуулга сурталчилгаа гэдэг бол шинэ санаа, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иргэд, олон нийтэд аль болох өргөн хүрээтэй хүргэх, мэдээлэх үйл явц юм. Энэхүү үйл явцын туршид тулгамдсан асуудлаар иргэдэд мэдээлэл өгөх, тэдний анхаарлыг татах, асуудлыг шийдвэрлэх гарц, шийдлийг олоход иргэдээс дэмжлэг авах ажлууд хийгддэг. Тиймээс ухуулга сурталчилгааны ажлын үндсэн зорилго бол бодлого, хөтөлбөрт шаардагдах өөрчлөлт, шинэчлэлийг авчрахад оршино.⁵⁵ Ухуулга, сурталчилгааны төлөвлөгөө гаргах нь дараах алхмуудаас бүрдэнэ:⁵⁶

Нэгдүгээр алхам: Асуудлыг ойлгож тодорхойлох
ОнАТБ гол зөвлөмж дүгнэлт нь юу вэ?

Хоёрдугаар алхам: Зорилтот хүртээгчдийг тодорхойлох
Шийдвэр гаргах түвшний, нийгэмд нөлөө үзүүлэх хүмүүс хэн байж болох вэ?

Гуравдугаар алхам: Мэдээллээ боловсруулах
Яагаад шинэчлэл, өөрчлөлтийг хийх хэрэгтэй вэ? Энэ нь орон нутгийн түвшний ардчиллыг хэрхэн сайжруулах вэ?

Дөрөвдүгээр алхам: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Олон нийтэд боловсруулсан мэдээллээ түгээхэд хэвлэл мэдээлэл, ухуулга сурталчилгаа, лобби хийх ямар үйл ажиллагааг хэрэглэх вэ?

Тавдугаар алхам: Орон нутгийн иргэд ба хамтрагч талуудыг идэвхжүүлэх

Шаардлагатай шинэчлэлийг хийхийн тулд орон нутгийн иргэдийн дэмжлэгийг олж авахад ОнАТБ-ын хамтрагчид яаж туслах вэ?

Зургаадугаар алхам: Мониторинг үнэлгээ

Улс төр, нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт, амжилт, алдаа дутагдал юу байсан вэ?

3.8. Үнэлгээ ба дараагийн алхмууд

Энэ шатанд үнэлгээний үйл явцыг бүхэлд нь үнэлэх, хяналт тавих ажлыг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, үнэлгээний явцад зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн үр нөлөөг ажиглах, өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлэх санаачилгуудыг энэ шатанд үнэлэх юм.

Дахин харах, няглах, үнэлгээгээ дүгнэх


Үнэлгээний үйл явцыг бүхэлд нь үнэлэх, нягтлан шалгах үйл явцад үндсэн болон зөвлөх багийн бүх гишүүдийг хамруулсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, үнэлгээний хэрэгжилтийг дүгнэх ажлууд хийгдэнэ. Энэ төрлийн уулзалтуудын гол зорилго нь хэрэгжилтийн явцад үр дүнтэй, амжилттай хэрэгжсэн ажлууд юу байв, ямар ажлуудыг илүү сайн хийх боломж, бололцоо байсан эсэхийг эргэн харах, дараагийн үнэлгээнд анхаарвал зохих асуудал, сургамж, туршлага зэргийг тодорхойлоход оршино.

Дараагийн шатанд үнэлгээний явцад тодорхойлсон богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг эргэн харах ажил хийгдэнэ. Энэ ажлын хүрээнд үнэлгээ хийсэн цаг үеэс хойш тухайн орон нутагт өрнөсөн улс төрийн үйл явцыг судлах, мэдээлэл түгээх, ухуулга сурталчилгаа явуулахтай холбоотой боловсруулсан санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн хангасан, амжилттай хэрэгжсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгнө. Мөн түүнчлэн, энд бусад эх сурвалж, судалгааны үр дүнг харьцуулан судлах, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад тавих иргэдийн хяналт, мониторингийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх ажил багтана.

Орон нутгийн үзүүлэлт боловсруулах, ОНАТБ-г институтчилэх

ОНАТБ үнэлгээний явцад боловсруулсан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд тавих иргэний хяналтыг орон нутгийн удирдах байгууллагатай хамтран гүйцэтгэхээр тохиролцож болно. Магадгүй орон нутгийн удирдах байгууллагын зүгээс орон нутгийн ардчиллын төлөв байдлыг үнэлэх, хөгжлийн стратеги зорилтуудаа тодорхойлох үүднээс багц үзүүлэлтүүд боловсруулах, хэрэгжилтийн төлөвлөгөө гаргах, үнэлгээний үйл явцыг бүхэлд нь институтчилэх (жишээ нь ОНАТБ үнэлгээг дөрвөн жил тутамд нэг хийх гэх мэт) зэрэг үйл ажиллагааг иргэдтэй хамтран гүйцэтгэх шийдвэр гаргаж болно.

Зураг 3.4. Шинэчлэлийн мөчлөг



БҮЛЭГ 4

**ОнАТБ үнэлгээний
аргачлал ба асуултууд**

ОнАТБ үнэлгээний аргачлал ба асуултууд

ҮНДСЭН ЗАРЧМУУД:

Нийтийн хяналт, эрх тэгш байдал

ҮНЭТ ЗҮЙЛС:

Төлөөлөл - Оролцоо - Зөвшөөрөл–Эгэх хариуцлага–Хариу шуурхай байдал–

Ил тод байдал–Хууль ёсны байдал–Эв нэгдэл

ТУЛГУУР 1: ИРГЭНИЙ ХАРЪЯАЛАЛ, ТЭГШ ЭРХ, ШУДАРГА ЁС	ТУЛГУУР 2: ТӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ, ЭГЭХ ХАРИУЦЛАГАТАЙ ОРОН НУТГИЙН ИНСТИТУЦ БА ҮЙЛ ЯВЦ	ТУЛГУУР 3 : ИРГЭДИЙН САНААЧИЛГА БА ОРОЛЦОО
<p>1.1 Орон нутгийн түвшин дэх иргэний харъяалал Нийтлэг асуулт: Орон нутгийн байгууллага үйл ажиллагаандаа тухайн газар нутгийн иргэдийг хэрхэн хамруулдаг, тэр дундаа иргэдийн амьдралд нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад хэр оролцуулдаг вэ?</p> <p>1.2 Иргэний болон улс төрийн эрх Нийтлэг асуулт: Орон нутагт хүн бүрийн иргэний болон улс төрийн эрхийг ижил түвшинд хүндэтгэн, дээдлэх асуудал ямар түвшинд байдаг вэ?</p>	<p>2.1 Сонгууль ба орон нутаг дахь шууд ардчиллын механизмууд Нийтлэг асуулт: Сонгууль болон шууд ардчиллын механизмууд нутгийн удирдлагын байгууллага, бодлогод хяналт тавих боломжийг ямар түвшинд иргэдэд олгодог вэ?</p> <p>2.2 Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Нийтлэг асуулт: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ардчиллын төлөөлөх эрх, үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байна вэ?</p>	<p>3.1 Иргэдийн идэвхтэй оролцоо Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд олон нийтийг хамарсан үйл явдал, арга хэмжээнд иргэдийн идэвхтэй, тогтмол, бүрэн оролцоо байдаг уу?</p> <p>3.2 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд ардчиллын үнэт зүйлсийг хадгалах, түүний тогтвортой байдлыг хангахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр үр нөлөөтэй ажилладаг вэ?</p>

ТУЛГУУР 1: ИРГЭНИЙ ХАРЪАЛАЛ, ТЭГШ ЭРХ, ШУДАРГА ЁС [үрг..]	ТУЛГУУР 2: ТӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ, ЭГЭХ ХАРИУЦЛАГАТАЙ ОРОН НУТГИЙН ИНСТИТУЦ БА ҮЙЛ ЯВЦ [үрг..]	ТУЛГУУР 3: ИРГЭДИЙН САНААЧИЛГА БА ОРОЛЦОО
<p>1.3 Нийгэм, эдийн засаг, улс төрийн эрх Нийтлэг асуулт: Хүн бүр эдийн засаг, нийгмийн болон соёлын эрхээ орон нутгийн түвшинд ижил түвшинд эдэлж чадаж байгаа эсэх, иргэний эрхийг хүндэтгэх асуудал ямар түвшинд байна вэ?</p> <p>1.4 Хууль дээдлэх ёс ба шүүхийн хүртээмжтэй байдал Нийтлэг асуулт: Хууль, шүүхийн байгууллагаар эрхээ хамгаалуулах боломж орон нутгийн засгийн газар болон иргэдийн хувьд хэр адил тэгш, баталгаатай байдаг вэ?</p>	<p>2.3 Улс төрийн намууд Нийтлэг асуулт: Улс төрийн намууд орон нутгийн түвшинд гүйцэтгэх ёстой ардчилсан үүргээ хэр сайн гүйцэтгэж байна вэ?</p> <p>2.4 Нутгийн захиргааны байгууллагууд Нийтлэг асуулт: Нутгийн захиргааны байгууллагууд орон нутгийн хүн амдүйлчлэхдээ хэр эгэх хариуцлагатай, шуурхай байдаг вэ?</p> <p>2.5 Заншлын болон уламжлалт институцууд Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд ардчиллын чанар, хэвийн үйл ажиллагаанд уламжлалт засаглалын институц болон тогтолцоо ямар түвшинд нөлөө үзүүлдэг вэ?</p>	
<p>НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ</p> <p>i. Түүх, газарзүй, нийгэм-эдийн засаг, хүн амзүйн тоон мэдээлэл Нийтлэг асуулт: Ардчиллын төлөв байдлыг ойлгоход чухал ач холбогдолтой, тухайн орон нутагт хамаарах түүх, газарзүйн болон нийгэм, эдийн засгийн ямар онцлог шинж, нөхцөл байдал байна вэ?</p> <p>ii. Орон нутгийн засгийн газрын нөлөө Нийтлэг асуулт: Орон нутгийн засгийн газар, улс орны засаглалын институцын бүтцэд ямар үүрэг, нөлөөтэй байдаг вэ?</p> <p>iii. Хүний аюулгүй байдал Нийтлэг асуулт: Хүний аюулгүй байдлын асуудал орон нутагт ямар түвшинд хангагдсан байдаг вэ?</p>		

Үнэлгээний аргачлал нь улс орон бүрийн онцлогт тохирсон байх ёстой учир асуултууд ч мөн хэтэрхий нарийвчилсан байж болохгүй. Энэхүү гарын авлагын гол зорилго нь үнэлгээний хүрээг аль болох ерөнхий бүтэцтэй байлгах, орон нутгийн нөхцөл байдалд тохирсон асуултуудыг оруулах, онцлог шинж байдлыг тусгахад чиглэдэг.

Гэхдээ ардчилсан зарчим, үнэт зүйлс, үнэлгээний асуултууд хооронд бодит логик уялдаа зайлшгүй байх ёстой.

- Ардчилсан зарчим, үнэт зүйлс нь шууд болон шууд бус хэлбэрээр одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжид тусгагдан, эрх зүйн тогтолцоогоор хамгаалагдсан байх ёстой.
- Үндсэн зарчим, үнэт зүйлс нь орон нутаг дахь байгууллага, үйл явцын ардчилсан чанарыг тодорхойлдог бөгөөд үйл ажиллагаанд тусгалаа олсон байдаг.
- Ардчиллын зарчим, үнэт зүйлс орон нутгийн иргэдэд таашаагдан хэрэглэгддэг, ардчиллыг илүү бодитой, амьд байлгахад дэмжлэг үзүүлдэг.

Орон нутгийн ардчиллын үнэлгээнд ашиглагддаг нийтлэг зарчим, үнэт зүйлс нь харьцангуй ерөнхий, төвлөрсөн байдаг тул үнэлгээний асуултуудыг боловсруулахдаа дээр дурдсан ардчиллын зарчим, үнэт зүйлсийг илэрхийлсэн асуулт боловсруулах нь чухал. Жишээлбэл: “Танай зөвлөлийн гишүүдийн дунд улс төрийн олон талт үзэл бодол хэр их байдаг талаар асуумаар байна, учир нь улс төрийн олон талт үзэл бодол байх нь бүх талын төлөөлөл (үнэт зүйл) байна гэсэн үг юм, бүх талын төлөөлөл байгаа нөхцөлд иргэд, олон нийтийн хяналт, тэгш байдал (зарчим) бий болох урьдчилсан нөхцөл бүрдэнэ гэсэн үг юм)”.

Доорх хүснэгтээр үнэлгээний асуултуудад хэрхэн бодитой, бүтэн хариулт авах талаар арга зүйн тайлбар оруулсан болно. Асуулт тус бүрт хамаарах хууль, бодлого, эрх зүйн ямар зохицуулалт байдгийг судлах, хоёрдугаар эдгээр хууль, дүрэм, бодлогын хэрэгжилт орон нутгийн түвшинд ямар байгааг харьцуулан харах нь зүйтэй. Урьдчилсан байдлаар үр дүнг тодорхойлохын тулд эерэг болон сөрөг үзүүлэлтүүдийг хамтад нь боловсруулах хэрэгтэй. Ингэснээр зөвхөн хариулт бүрт шаардлагатай нотолгоог бий болгоод зогсохгүй орон нутгийн түвшинд үзүүлэлт боловсруулах ажлыг эхлүүлэхэд чухал ач холбогдолтой. Эдгээр үзүүлэлтийг чанарын судалгааны суурь үзүүлэлт болгон ашиглах боломжтойн дээр ардчиллын төлөв байдлын үнэлгээний ахиц дэвшлийг үнэлэх, саад бэрхшээл, ухралт, бууралтыг хэмжихэд ашиглаж болно.

Жишээ: Судлах, анхаарах асуудлууд			
Хууль, бодлого, орон нутгийн зохицуулалт	Практик	Сөрөг үзүүлэлтүүд	Эерэг үзүүлэлтүүд
<i>Нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн төлөөлөл, оролцоог хангахад чиглэсэн хууль эрх зүй, бодлогын болон институтын хүрээг нягтлан үзэх.</i>	<i>Эдгээр хууль, бодлого, зохицуулалт нь орон нутгийн түвшинд хэрхэн шударга, аль нэг талыг бус, бүх нийтийг тэгш төлөөлж байгааг судлах, нийгмийн эмзэг бүлгийн төлөөлөл, оролцоонд ямар нөлөө үзүүлж байгааг судлах.</i>	<i>Шууд болон шууд бус хэлбэрээр хууль зөрчин, нийгмийн аль нэг бүлгийг гадуурхах бодлого барьсан эсэхийг судлах, нотолгоо цуглуулах.</i>	<i>Нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийг төлөөлөн орон нутгийн зөвлөлд ажилладаг хүмүүсийн тоо, улс төрийн намууд, шүүх, төрийн албаны ажилтнуудын талаар мэдээлэл цуглуулах.</i>

Тулгуур 1: ИРГЭНИЙ ХАРЪЯАЛАЛ, ТЭГШ ЭРХ, ШУДАРГА ЁС

1.1. Орон нутгийн түвшин дэх иргэний харъяалал

Нийтлэг асуулт: Орон нутгийн байгууллага үйл ажиллагаандаа тухайн газар нутгийн иргэдийг хэрхэн хамруулдаг, тэр дундаа иргэдийн амьдралд нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад хэр оролцуулдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 1.1.1. Иргэний харъяалал хэмээх ойлголтыг орон нутгийн түвшинд хэрхэн тайлбарлаж, тодорхойлж байна вэ?
- 1.1.2. Тухайн орон нутагт оршин сууж буй иргэдийн өмнө тулгамдсан асуудал, тэдний ашиг сонирхол, эрхийн асуудлыг адил түвшинд харгалзан үздэг үү?
- 1.1.3. Орон нутагт амьдарч буй иргэд үндэс угсаа, нас, оршин суугаа газар, хүйс, бэлгийн чиг хандлага, угсаа гарал, арьсны өнгө болон шашны итгэл үнэмшил, улс төрийн үзэл бодол, хэл яриа болон бусад нөхцөл байдалд үндэслэсэн аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж чаддаг уу?
- 1.1.4. Орон нутгийн иргэд нийгмийн өдөр тутмын харилцаанд оролцоходоо аливаа төрлийн хязгаарлалт, ялгаварлан гадуурхах байдалтай тулгардаггүй, эрх чөлөөтэй оролцож чаддаг уу (тухайлбал, төрсний гэрчилгээ байхгүй, бичиг баримт байхгүй шилжин ирэгсэд, харъяалалгүй иргэн, дүрвэгсэд, улс төрийн орогнол хайгч этгээд, нутаг заагдсан хүмүүс гэх мэт)?

- 1.1.5. Өмч хөрөнгийн эзэмшил, эцэг эх болох, хүүхдийн иргэний харьяалал, нийгмийн харилцаа, амьдралд оролцох, төлөөлөх гэх мэт нийт иргэдийн эдлэх ёстой эрхийг эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш эдэлж чадаж байна уу?
- 1.1.6. Тухайн орон нутагт амьдарч буй залуучууд, өндөр настнууд нийгмийн бүх төрлийн үйлчилгээ, арга хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, бүрэн хамрагдаж чаддаг уу?
- 1.1.7. Хэл, соёл, шашны итгэл үнэмшлийн хувьд ялгаатай нийгмийн бүлэг, цөөнхийн эрх ашгийг орон нутагт ямар түвшинд хүлээн зөвшөөрсөн байдаг вэ?
- 1.1.8. Орон нутгийн засгийн газар нийгмийн ялгаатай анги давхарга, хуваагдал, бусад ялгаатай шинж байдалд үндэслэсэн аливаа төрлийн зөрчил, мөргөлдөөнөөс ангид байж чаддаг уу?

1.2. Иргэний болон улс төрийн эрх

Нийтлэг асуулт: Орон нутагт хүн бүрийн иргэний болон улс төрийн эрхийг ижил түвшинд хүндэтгэн, дээдлэх асуудал ямар түвшинд байдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 1.2.1. Иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөг Үндсэн хууль, бусад хууль болон орон нутгийн тогтоол, шийдвэрт ямар түвшинд баталгаажуулсан байдаг вэ?
- 1.2.2. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, зохион байгуулалтанд орох эрх ямар түвшинд хамгаалагдсан байдаг вэ?
- 1.2.3. Уламжлалт хэл, соёл, шашны итгэл үнэмшлээ дагах, мөрдөх эрх чөлөө хэр баталгаажсан байдаг вэ?
- 1.2.4. Нийгмийн бусад хэм хэмжээ, хязгаарлалт зэрэг нь иргэний болон улс төрийн эрхээ эдлэх боломжид ямар түвшинд хэрхэн нөлөөлдөг вэ?
- 1.2.5. Иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж эрэгтэй, эмэгтэй хүтүүст адил тэгш байдаг уу?
- 1.2.6. Орон нутгийн иргэд удирдлага, эрх барьж байгаа бүлгийн эсрэг байр сууриа илэрхийлэх эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж байдаг эсэх, хавчлага, дарамт шахалтаас ангид байж чаддаг уу?
- 1.2.7. Нийгмийн эмзэг бүлэг, үндэсний цөөнх, нутгийн уугуул иргэд, шилжин ирэгсэд болон дүрвэгсэд гэх мэт нийгмийн онцлогтой анги давхаргад хамаарах хүмүүсийн иргэний болон улс төрийн эрхээ эдлэх боломжийг орон нутгийн зүгээс ямар түвшинд дэмждэг вэ?

1.3. Нийгэм, эдийн засаг, соёлын эрх

Нийтлэг асуулт: Хүн бүр эдийн засаг, нийгмийн болон соёлын эрхээ орон нутгийн түвшинд ижил түвшинд эдэлж чадаж байгаа эсэх, иргэний эрхийг хүндэтгэх асуудал ямар түвшинд байна вэ?

Үнэлгээний асуултууд:

- 1.3.1. Үндсэн хууль болон үндэсний бусад хууль тогтоомжийн дагуу иргэний эдийн засаг, нийгэм, соёлын эрх ямар түвшинд баталгаажсан байдаг вэ?
- 1.3.2. Боловсрол эзэмших, ажил эрхлэх, нийгмийн даатгалд хамрагдах зэрэг эрхээ хүн бүр аливаа төрлийн ялгаварлан гадуурхалд өртөлгүйгээр эдэлж чаддаг уу?
- 1.3.3. Хангалттай хоол хүнс хэрэглэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, орон байранд амьдрах, цэвэр ус хэрэглэх зэрэг хүний үндсэн хэрэгцээ ямар түвшинд хангагдсан байдаг вэ, бүх хүнийг хамарч чаддаг уу?
- 1.3.4. Хувь хүн бүр дээр дурдсан үндсэн хэрэгцээгээ хангуулах зорилгоор орон нутгийн удирдлагад шаардлага, хүсэлт тавьж чаддаг эсэх, энэхүү шаардлага нь нийгмийн хэв журам, хязгаарлалтуудаас ангид байж чаддаг эсэх?
- 1.3.5. Дээр дурдсан үндсэн эрхээ эдлэхэд эмэгтэй, эрэгтэй хүн бүр ижил нөхцөл, боломжоор хангагдаж чадаж байна уу?
- 1.3.6. Иргэдийн дээр дурдсан эрхийг эдлүүлэхэд орон нутгийн байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа иргэдийн сэтгэлд хэр нийцдэг вэ?
- 1.3.7. Нийгмийн эмзэг бүлэг, үндэсний цөөнх, нутгийн уугуул иргэд, шилжин ирэгсэд болон дүрвэгсэд гэх мэт нийгмийн онцлогтой давхаргад хамаарах хүмүүсийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх боломжийг орон нутгийн зүгээс ямар түвшинд дэмждэг вэ?

1.4. Хууль дээдлэх ёс ба шүүхийн хүртээмжтэй байдал

Нийтлэг асуулт: Хууль, шүүхийн байгууллагаар эрхээ хамгаалуулах боломж нутгийн удирдлагын байгууллага болон иргэдийн хувьд хэр адил тэгш, баталгаатай байдаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 1.4.1. Хууль дээдлэх ёс орон нутагт ямар түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг вэ?
- 1.4.2. Орон нутгийн институц болон төрийн албан хаагчид хуулийн өмнө хариуцлага хүлээж, ажлын гүйцэтгэлээ ил тод хэлбэрээр тайлагнадаг уу?
- 1.4.3. Хууль сахиулах байгууллага, шүүх, хууль зүйн туслалцаа үзүүлдэг байгууллага гэх мэт байгууллагуудыг өөртөө багтаасан шүүхийн тогтолцоо нь нийгмийн бүх хэсэгт, эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш түвшинд үйлчилж, хүртээмжтэй байж чаддаг уу?

- 1.4.4. Хувь хүмүүсийн гомдол гаргах гэх мэт асуудлаар шүүхэд хандах боломж бололцоо бүрэн, тэгш хангагдсан байдаг уу?
- 1.4.5. Шүүхийн тогтолцоо нь хэр шударга ажилладаг вэ, өөр хоорондоо ялгаатай нийгмийн бүлэг, нутгийн иргэдийн итгэлийг хүлээж чаддаг уу?
- 1.4.6. Улс төр, хувийн сектор, эрүүгийн болон хууль бус үйл ажиллагаа явуулдаг тодорхой бүлэглэлүүдийн оролцоо, хээл хахууль, нөлөөлөл зэргээс шүүх, хууль сахиулах байгууллагууд ангид байж чаддаг уу?
- 1.4.7. Орон нутгийн түвшинд уламжлалт буюу ёс заншилд суурилсан шүүх тогтолцоо байдаг эсэх, хэрэв тийм бол тус тогтолцоог нийгэмд шударга ёсыг тогтоох боломжит хувилбар гэж орон нутгийн иргэд үздэг үү?
- 1.4.8. Эдгээр институт аль нэг талыг үл баримтлан хүн бүрт эрх тэгш хандах хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, ажиглалт хийх бололцоотой байдаг вэ ?
- 1.4.9. Орон нутгийн түвшинд иргэдийн гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм, албан болон албан бус институт хэр үр нөлөөтэй ажилладаг вэ?

Тулгуур 2: ТӨЛӨӨЛӨЛ БҮХИЙ, ЭГЭХ ХАРИУЦЛАГАТАЙ ОРОН НУТГИЙН ИНСТИТУЦ БА ҮЙЛ ЯВЦ

2.1. Сонгууль ба орон нутаг дахь шууд ардчиллын механизмууд

Нийтлэг асуулт: Сонгууль болон шууд ардчиллын механизмууд нутгийн захиргааны байгууллага, бодлогод хяналт тавих боломжийг ямар түвшинд иргэдэд олгодог вэ?

Үнэлгээний асуултууд:

- 2.1.1. Сонгуулийн болоод намуудын тогтолцоо сонгогчдод үр нөлөө бүхий сонголт хийх боломжийг хэр олгодог вэ, сонгогчдын саналыг хэр зэрэг адил тэгш шударгаар тоолдог вэ, „нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, захиргааны бүрэлдэхүүн иргэдийн сонголтыг хэр тусгадаг вэ?
- 2.1.2. Сонгуулийн тогтолцоо нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад аль хэр хэмжээнд захирагддаг гүйцэтгэх удирдлагыг бий болгодог уу?
- 2.1.3. Бүх нийтийн санал асуулга, иргэдтэй харилцан зөвшилцөх, иргэдийн санал, санаачилгыг сонсох зэрэг ил тод, бүх нийтийг хамарсан үйл ажиллагаанд нийгмийн бүх хэсэг, давхаргын хүмүүсийн үзэл бодлыг хэр тусгаж чаддаг вэ?
- 2.1.4. Сонгогч эсвэл сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчийн хувиар сонгуулийн үйл явцад оролцох оролцоо, боломж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд хэр адил тэгш байдаг вэ?

- 2.1.5. Сонгуульд оролцож санал өгөх эрхтэй боловч хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэг мэддэггүй, хөдөө орон нутагт амьдардаг иргэдийн хувьд сонгуулийн үйл явц, түүнтэй холбоотой мэдээ, мэдээлэл авах боломж хэр сайн байдаг вэ?
- 2.1.6. Хууль тогтоох байгууллага нийт сонгогчдын нийгмийн бүрэлдэхүүнийг хэр зэрэг тусган илэрхийлдэг вэ?
- 2.1.7. Сонгуульд санал өгөх хүмүүс, нэр дэвшигчид болон намуудыг бүртгэх үйл ажиллагаа хэр шударга, ил тод явагддаг вэ?
- 2.1.8. Улс төрийн намуудад олон нийтийн мэдээллийн хэрэгслийг адил тэгш түвшинд ашиглах боломж хэр байдаг вэ?
- 2.1.9. Сонгуулийн үйл явц авлига, хээл хахууль, гадаад хүчин зүйлийн нөлөө, оролцоо зэргээс хэр ангид байдаг вэ, сонгуулийн үр дүнгийн талаар талуудын хооронд зөрчил, маргаан гарсан нөхцөлд асуудлыг тайван замаар, холбогдох талуудад ашигтайгаар шийдвэрлэж чаддаг уу?

2.2.Орон нутгийн хууль тогтоох байгууллага

Нийтлэг асуулт: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ардчиллын төлөөлөх эрх, үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байна вэ?

Үнэлгээний асуултууд:

- 2.2.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гүйцэтгэх эрх мэдлээс хэр хараат бус байдаг вэ, парламентын гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бодлогын өөр хувилбар санал болгох боломжоор хэр хангагдсан бэ?
- 2.2.2. Хууль тогтоох байгууллага болон сонгуулиар бий болдог бусад төрийн байгууллагад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн төлөөлөл хэр адил тэгш байдаг вэ?
- 2.2.3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага орон нутгийн иргэдийн төлөөллийг хэр зөв тусгаж чаддаг вэ? Нийгмийн аль бүлэг, ямар шалтгааны улмаас илүү олон эсвэл цөөн төлөөлөлтэй байдаг вэ?
- 2.2.4. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага өөрсдийн ажлаар олон нийттэй зөвлөлдөх горим хэр өргөн хүрээтэй, ил тод байдаг вэ?
- 2.2.5. Сонгогдсон төлөөлөгчид эргээд сонгогч олондоо олдох боломж нь хэр өргөн нийтлэг байдаг вэ?
- 2.2.6. Гүйцэтгэх эрх мэдлийг хянах, эгэх хариуцлага тооцох талаарх нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх мэдэл хэр өргөн бөгөөд үр нөлөөтэй вэ?
- 2.2.7. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гишүүдийг аливаа төрлийн гадны нөлөө, авлига зэргээс ангид байлгах, хамгаалах механизм хэр үр нөлөөтэй вэ?

2.3. Улс төрийн намууд

Нийтлэг асуулт: Улс төрийн намууд орон нутгийн түвшинд гүйцэтгэх ёстой ардчилсан үүргээ хэр сайн гүйцэтгэж байна вэ?

Үнэлгээний асуултууд:

- 2.3.1. Нам байгуулах, гишүүн элсүүлэх, улс төрчдийг сургах, мөрийн хөтөлбөрийн талаар олон нийтэд хандах болон сонгуулийн өмнөх кампанит ажил явуулах, сонгуулийн уриа, тунхаг зарлах нь хэр чөлөөтэй вэ?
- 2.3.2. Улс төрийн намуудын чадавх, эх үүсвэр, дотоод журам зэрэг нь улс төрийн намын үйл ажиллагааг идэвхтэй явуулах боломжийг хэр бүрдүүлж байна вэ?
- 2.3.3. Намын бодлогыг тодорхойлж боловсруулах, нэр дэвшигчдийг сонгоход намын гишүүд хэр идэвхтэй, үр нөлөөтэй оролцдог вэ?
- 2.3.4. Намын удирдлага, манлайлал, улс төрийн намын гишүүд дунд эрэгтэй, эмэгтэй гишүүдийн төлөөлөл хэр тэнцвэртэй байдаг вэ?
- 2.3.5. Намын гишүүд, нэр дэвшигчдийн үндэс угсаа, шашин шүтлэг, хэлний хуваагдмал байдлыг намууд хэр амжилттай шийдвэрлэж, хэрхэн бүх гишүүд, дэвшигчдэд адил тэгш боломж олгож байна вэ?
- 2.3.6. Улс төрийн нам, удирдагчид иргэд, олон нийтээс санхүүгийн дэмжлэг авах тохиолдол ямар түвшинд байдаг вэ? Улс төрийн намууд гэмт хэрэг, хээл хахуулиас хэр ангид байдаг вэ?
- 2.3.7. Улс төрийн нам, улс төрчдөд итгэх итгэл орон нутгийн түвшинд ямар байдаг вэ?

2.4. Нутгийн захиргааны байгууллагууд

Нийтлэг асуулт: Орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ хэр хариуцлагатай, шуурхай ханддаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 2.4.1. Сонгуулиар байгуулагдсан засаг төрийн байгууллага нь ард түмний амьдралд нэн чухал асуудлыг хяналтандаа байлгаж, шийдвэрлэх чадвараар хэр вэ? Үүний тулд мэдээлэл, нөөцөөр хэрхангагдсан, хэр сайн зохион байгуулагдсан бэ?
- 2.4.2. Төрийн албанд ажиллаж буй иргэд ямар механизм ашиглан төрийн албанд орсон байдаг вэ? Сонгогддог уу эсвэл томилогддог уу? Сонгон шалгаруулалт мэдлэг, ур чадварт суурилдаг уу эсвэл өөр холбоо, хамаарал байдаг уу?
- 2.4.3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хараа, хяналтанд байдаг зэвсэгт хүчин, цагдаа, аюулгүй байдал сахиулах байгууллагууд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ажиглагч бүлгүүдээс хэр ангид, хол байдаг вэ?
- 2.4.4. Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд нээлттэй, хүртээмжтэй байлгахад гүйцэтгэх байгууллага хэр анхаарч ажилладаг вэ?

- 2.4.5. Засаг даргын хөтөлбөр баглах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх зэрэг үйл явц хэр нээлттэй, ил тод байдаг вэ?
- 2.4.6. Олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулах, иргэдийн оролцоог хангах механизмууд нь хэр системчлэгдсэн, өргөн хүрээг хамарсан байдаг вэ?
- 2.4.7. Төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээ хэр хүртээмжтэй, найдвартай байдаг вэ?
- 2.4.8. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд нутгийн захиргааны байгууллага хэр зэрэг эгэх хариуцлагатай ханддаг вэ?
- 2.4.9. Нутгийн захиргаанд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа хэр тэнцвэртэй вэ, захиргааны бодлого, хөтөлбөрийн жендерийн мэдрэмжтэй байдаг эсэх?

2.5.Заншлын болон уламжлалт институцууд

Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд ардчиллын чанар, хэвийн үйл ажиллагаанд уламжлалт засаглалын институт болон тогтолцоо ямар түвшинд нөлөө үзүүлдэг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 2.5.1. Уламжлалт институт, шашны байгууллагууд нь орон нутгийн иргэдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хэр чухал үүрэг, оролцоотой байдаг вэ?
- 2.5.2. Эдгээр байгууллагууд төлөөлөлөх чадварын хувьд хэр хүлээн зөвшөөрөгдсөн, ил тод байдаг вэ, орон нутгийн иргэд эдгээр байгууллагад хэр итгэл хүлээлгэдэг вэ?
- 2.5.3. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдэлд эдгээр байгууллагуудын үүрэг, нөлөө хэр их байдаг вэ?
- 2.5.4. Эдгээр байгууллагууд орон нутагт төрийн үйлчилгээг хүргэхэд ямар түвшинд дэмжлэг үзүүлдэг эсвэл саад болдог вэ?
- 2.5.5. Эдгээр байгууллагуудын шийдвэр гаргах үйл явц, үйл ажиллагаа нь жендерийн эрх тэгш байдлыг дэмжих, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн байдаг уу?
- 2.5.6. Эдгээр байгууллагын удирдлага, бүрэлдэхүүн нь тухайн орон нутаг дахь хүн амыг хүйс, нас, шашин шүтлэг, анги давхарга, яс үндэс зэргээрээ ялгаатай бүлгүүдийг ижил түвшинд төлөөлж чаддаг уу?
- 2.5.7. Засаглалын уламжлалт болон орчин үеийн институт хооронд харилцан ойлголцол, нэгдмэл байдал ямар түвшинд байдаг вэ, эдгээр байгууллагууд нь хэр тогтвортой байж чаддаг вэ?

Тулгуур 3: ИРГЭДИЙН САНААЧИЛГА БА ОРОЛЦОО

3.1. Иргэдийн идэвхтэй оролцоо

Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд олон нийтийг хамарсан үйл явдал, арга хэмжээнд иргэдийн идэвхтэй, тогтмол, бүрэн оролцоо байдаг уу?

Үнэлгээний асуултууд:

- 3.1.1. Олон нийтийг хамарсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор иргэд ганцаарчилсан болон хамтарсан хэлбэрээр арга хэмжээ авах тохиолдол хэр байдаг вэ?
- 3.1.2. Иргэний нийгмийн байгууллага, холбоод, улс төрийн хөдөлгөөн зэрэг хэлбэрээр ард иргэд эвлэлдэн нэгдэх тохиолдол хэр түгээмэл байдаг вэ?
- 3.1.3. Олонд танигдсан хүмүүс, ардын баатар, удирдагч, нийгмийн идэвхтэй гишүүд улс төрд орох тохиолдол хэр их байдаг вэ?
- 3.1.4. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулахад цэцэрлэгт хүрээлэн, нийтийн танхим, цахим платформ зэргийг хэр өргөн ашигладаг вэ, эдгээр арга хэрэгслийг ашиглан зохион байгуулсан олон нийтийн цуглаан, эсэргүүцлийн жагсаал зэргийг зогсоох, тараах зорилготой дүрэм журам ямар түвшинд үйлчилдэг вэ?
- 3.1.5. Ард иргэд өөрсдийн амьдралд нөлөөлж буй асуудал, хэрэгцээ шаардлагаа олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг, уулзалтанд оролцох үедээ хэр их илэрхийлдэг вэ?
- 3.1.6. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ярих, зохион байгуулалтанд орох зэрэг эрхээ эдлэхдээ ард иргэд аливаа төрлийн дарамт, сүрдүүлэг, дарангуйллаас ангид байж чаддаг уу?
- 3.1.7. Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах ямар хэлбэрүүд байдаг вэ, эдгээр арга хэмжээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүлээх үүрэг оролцоо ямар хэлбэрээр илэрдэг вэ?
- 3.1.8. Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн иргэдийн санал, санаачилга хэр үр дүнтэй байдаг, иргэдийн санал санаачилгын шийдвэр гаргагчид анхааралдаа авч хэрэгжүүлдэг эсэх, тухайлбал үйлчилгээ үзүүлэх асуудлаар?
- 3.1.9. Иргэдийн зүгээс гаргасан санал, санаачилга, үйл ажиллагаа нь асуудал, зөрчлийг улам хурцатгасан тохиолдол хэр их байдаг, зөрчил, маргаанаас хэрхэн урьдчилан сэргийлж эсвэл тайван замаар шийддэг үү?

3.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Нийтлэг асуулт: Орон нутгийн түвшинд ардчиллын үнэт зүйлсийг хадгалах, түүний тогтвортой байдлыг хангахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр үр нөлөөтэй ажилладаг вэ?

Үнэлгээний асуултууд:

- 3.2.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд тухайлбал, сэтгүүлч, хэвлэлийн ажилтан, туслах зэрэг хүмүүс ажлаа чөлөөтэй, аюулгүй гүйцэтгэх орчин нөхцөл хэр бүрдсэн байдаг вэ?
- 3.2.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн асуудал хэр олон талын оролцоотой байдаг вэ, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгслээс хэр хараат бус, бие даасан байж чаддаг вэ?
- 3.2.3. Орон нутаг дахь хэвлэл мэдээллийн байгууллага нь хэр биеэ даасан, шударга үйл ажиллагаа явуулдаг вэ, улс төр, бизнесийн болон бусад ашиг сонирхлоос ангид байж чаддаг уу?
- 3.2.4. Бүх нийтийг хамарсан асуудлаар орон нутгийн засаг захиргаа болон бусад эрх баригчдийн зүгээс явуулж буй үйл ажиллагааг шалгах, нягтлах зэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэр нөлөөтэй байдаг вэ?
- 3.2.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш мэдээлэл хүргэж чаддаг эсэх, жендерийн хэвшмэл ойлголтыг халах, түүнтэй тэмцэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүрэг, оролцоо хэр байдаг вэ?
- 3.2.6. Мэдээлэл авах хэрэгсэл, интернэт ард иргэдэд хэр хүртээмжтэй байдаг вэ, эдгээр мэдээллийн хэрэгсэл нь хүн бүрт адил түвшинд мэдээлэл хүргэх боломжийг нэмэгдүүлж чадах уу?
- 3.2.7. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ялгаатай үзэл бодол, байр суурийг хэр тэнцвэртэй нэвтрүүлдэг вэ, нийт хүн амын үзэл бодлыг илэрхийлж чаддаг уу, үүнд нийгмийн цөөнх, эмзэг бүлгийнхий үзэл бодол багтдаг уу?

Тайлбар зүүлт

- ¹ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн, *Орон нутгийн түвшин дэх ардчилал, АСДҮОУХ-ээс эрхлэн гаргасан гарын авлага: Оролцоо, төлөөллөл, зөрчлийн удирдлага, засаглал* (Стокгольм: АСДҮОУХ, 2001)
- ² АСДҮОУХ, *Ардчиллын үнэлгээний гарын авлага* (Гааг: Клувер Хууль, олон улс, 2002); АСДҮОУХ, *Ардчиллын төлөв байдал: Дэлхийн найман улсад хийсэн ардчиллын үнэлгээ* (Гааг: Клувер Хууль, олон улс, 2008); АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2001)
- ³ АСДҮОУХ, *Орон нутгийн ардчиллын төлөөх манлайлал: Орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх гарын авлага*, <http://www.idea.int/democracy/upload/Local_Dem_Assessment_Guide.pdf>
- ⁴ АСДҮОУХ, *АСДҮОУХ –ийн стратеги 2012–2017* (Стокгольм: АСДҮОУХ, 2012), <<http://www.idea.int/about/secretary-general/upload/idea-strategy-2012-2017.pdf>>
- ⁵ АСДҮОУХ, *АСДҮОУХ –ийн стратеги 2012–2017* (Стокгольм: АСДҮОУХ, 2012) <<http://www.idea.int/about/secretary-general/upload/idea-strategy-2012-2017.pdf>>
- ⁶ Виер Стурт, *Ардчиллын чанарт үнэлгээ хийх нь: Гарын авлага* болон Ардчиллын төлөв байдлын цахим хуудасны нээлтийн үеэр нийгэд хийсэн танилцуулга, Нью-Йорк, 2008 оны 11 сарын 13, <<http://www.idea.int/sod/upload/Stuart-Weir-2008.pdf>>
- ⁷ Орон нутаг, хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл гэдэг ойлголтоор нэг газар нутагт оршин сууж буй иргэд, олон нийтийг илэрхийлэв (<<http://www.oxforddictionaries.com/definition/english/community>>). Энэхүү үнэлгээний хувьд засаглалын бүтэц гэсэн утгыг мөн агуулж болно.
- ⁸ Орон нутгийн ардчиллын олон төрлийн асуултууд дээр суурилав, дараах холбоосоор орж харж болно. <<https://v-dem.net/>>
- ⁹ Карим Абдул Кафар, ‘Орон нутгийн улс төр дэх ялгаатай байдал, засаглал, ардчиллын хөгжилд нөлөөлөх нь: Индонез улсын жишээ’, АСДҮОУХ-ийн хэлэлцүүлгийн үеэр хийсэн танилцуулга, ‘Төрийн

- удирдлага ба засаглал: Уламжлал, өөрчлөлт’ Олон улсын хурал, Филиппины Үндэсний Их сургууль, Төрийн удирдлага, засаглалын коллеж, Манила, 2012 оны 6 сарын 27-29
- ¹⁰ Ко, Эдна Е.А., болон бусад, *Мусульман Минданао Автономит бүсэд хийсэн ардчиллын төлөв байдлын үнэлгээ*, (Филиппин: Төрийн удирдлага, засаглалын коллеж, Манила, Филиппины Дилманы Их сургууль (UP-NCPAG) Филиппины ардчилал, ислам шашин судлалын төв (PCID), 2012). Цахим хувилбарыг <<http://www.idea.int/publications/sold-armm/index.cfm>>
- ¹¹ АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 20–1, Нэгдүгээр хэсэг
- ¹² Кабээр, Найла (хян.), *Хамарсан иргэнийл: Утга агуулга, илэрхийлэл* (Лондон & Нью-Йорк: Zed Books, 2005)
- ¹³ АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 20–1, Нэгдүгээр хэсэг
- ¹⁴ АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 20–1, Нэгдүгээр хэсэг
- ¹⁵ Эдгээр үнэт зүйлсийн талаарх дэлгэрэнгүй тайлбарыг АСДҮОУХ-аас эрхлэн гаргасан, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага – аас харна уу* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 20–1, Нэгдүгээр хэсэг
- ¹⁶ Бэтхэм, Д., ‘Ардчиллын онол ба Орон нутгийн засаглал’, Кинг ба Стогэр (хян.), *Орон нутгийн ардчиллыг дахин тунгаах нь* (Лондон: Макмиллан, 1996), хх. 28-49
- ¹⁷ Ил тод & Эгэх хариуцлагатай байдлын санаачилга, <<http://www.transparency-initiative.org/about/definitions>>
- ¹⁸ Ил тод & Эгэх хариуцлагатай байдлын санаачилга, <<http://www.transparency-initiative.org/about/definitions>>
- ¹⁹ АСДҮОУХ, *Ардчилал, зөрчил мөргөлдөөн ба хүний аюулгүй байдал: 21-р зууны энх тайвны эрэл* (Стокгольм: АСДҮОУХ, 2006), х. 17
- ²⁰ Кабээр, Найла (хян.), *Хамарсан иргэнийл: Утга агуулга, илэрхийлэл* (Лондон & Нью-Йорк: Zed Books, 2005), х. xiv
- ²¹ Кабээр, Найла (хян.), *Хамарсан иргэнийл: Утга агуулга, илэрхийлэл* (Лондон & Нью-Йорк: Zed Books, 2005) х. xii
- ²² Европын Парламентын Ассемблейн Зөвлөл ‘Европ дахь ардчиллын төлөв байдал. Европын орнууд ба ардчилал, сорилт бэрхшээл: Цагаачлал, хүн амын ялгаатай тохиолдол’, Баримт 11623, 2008 оны 6 сарын 6
- ²³ АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), х. 27
- ²⁴ Томмасали, Массимо, ‘Эрх зүйт төр ба ардчилал: Бодлого, практик хоорондын зөрүү’, *НҮБ-ын мэдээ*, 49/4 (2012 оны 12 сар), <<http://www.un.org/wcm/content/site/chronicle/home/archive/issues2012/deliveringjustice/ruleoflawanddemocracy>>
- ²⁵ Дэлгэрэнгүй мэдээлэл <<http://www.quotaproject.org/>>

- 26 Дэлгэрэнгүй мэдээлэл АСДҮОУХ, *Шууд ардчилал: АСДҮОУХ-ийн гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008)
- 27 Дэлгэрэнгүй мэдээлэл АСДҮОУХ, *Шууд ардчилал: АСДҮОУХ-ийн гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), х. 41
- 28 АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 27-8
- 29 Саказ, М., ‘Орон нутгийн ардчилал, засаглалын чанарыг бэхжүүлэх эсвэл дордуулах засаглалын уламжлалт/ заншлын тогтолцооны үүрэг, нөлөө: Гана улсын жишээ’, АСДҮОУХ –ийн бага хуралд танилцуулсан илтгэл ‘Иргэдэд түшиглэсэн ардчиллын үнэлгээ: Дэлхийн туршлагын арван жил’ АСДҮОУХ –ын бага хуралд танилцуулсан илтгэл, Бангкок, 2013 оны 9 сарын 16-18 (хэвлэгдээгүй)
- 30 Молиц, П.Д ‘Улс төрийн тогтвортой байдал, саад бэрхшээл, аюул занал: Ботсваны жишээ’, ‘Иргэдэд түшиглэсэн ардчиллын үнэлгээ: Дэлхийн туршлагын арван жил’ АСДҮОУХ –ын бага хуралд танилцуулсан илтгэл, Бангкок, 2013 оны 9 сарын 16-18 (хэвлэгдээгүй)
- 31 Голдфранк, Бэнжамин, *Латин Америкийн орнууд дахь ардчиллын хөгжил: Оролцоо, төвлөрлийг сааруулах ба Зүүний хүчин* (Парк Их сургууль, Пэнн стэйт Их сургуулийн хэвлэх үйлдвэр, 2011)
- 32 АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), х. 28
- 33 АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), х. 28
- 34 Фокс, Ричард Л., Женнифер М.Рамос (хян.), *Цахим-улс төр: Иргэд, сонгууль, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн шинэ эрин* (Нью-Йорк: Кэмбрижийн Их сургуулийн хэвлэх үйлдвэр, 2012)
- 35 *Cap Haitien мужид хийсэн орон нутгийн ардчиллын үнэлгээ*, (Стокгольм: АСДҮОУХ, 2010), <http://www.idea.int/publications/local_democracy_in_cap_haitien/upload/Local_democracy_in_Cap-Haitien.pdf>
- 36 Жендер хэмээх ойлголтыг зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэдэгтэй адилтгаж ойлгож болохгүй. Харин эрх мэдэл, хүчний тэнцвэртэй хуваарилалтыг хэрхэн хийсэн, энэ хуваарилалт эрэгтэй, эмэгтэй иргэдийн хувьд ямар харьцаатай байгааг судлахад ашиглагддаг ойлголт юм.
- 37 НҮБ-ын Нийгмийн хөгжлийн судалгааны хүрээлэн, *Жендерийн тэгш байдал: Тэгш бус дэлхийн дэг журамд шударга ёсыг тогтоох зүтгэл* (Женев: UNRISD/UN, 2005), <<http://www.unrisd.org/80256B3C005BCCF9/search/1FF4AC64C1894EAAAC1256FA3005E7201?OpenDocument>>
- 38 Хоровиц, Леа, *Эмэгтэйчүүдэд ээлтэй сайн засаглалыг бий болгох нь: Бүтээлийн судалгаа*, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил хэлэлцүүлгийн илтгэл No. 43, (Вашингтон: Дэлхийн Банк, 2009), <<http://documents.worldbank.org/curated/en/2009/01/11061201/getting-good-government-women-literature-review>>

- ³⁹ Орон нутгийн засаг захиргааны олон улсын холбоо, Гүйцэтгэх хороо (IULA), Орон нутгийн засаг захиргаа ба эмэгтэйчүүд: Дэлхий нийтийн тунхаг <<http://www.cities-localgovernments.org/uclg/upload/template/templatedocs/worldwidedeclaration.htm>>
- ⁴⁰ Балдвин, С., Крис Шарфман, Зое Грэй, *Цөөнхийн эрх: Зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх түлхүүр* (Цөөнхийн эрхийн Олон улсын бүлэг, 2003); Прэвит Кэвин, 'Нийгмийн тэгш бус байдал хүн ам зүйн бүтцэд нөлөөлөх нь, Либерал ардчиллын төлөө яах вэ?', *Нийгмийн судалгаа: Улирал* 77/1 (хавар 2010), хх. 1–20
- ⁴¹ Брүүкинс Хүрээлэнгийн 'Аюултай харилцаа: Латин Америкийн улсууд дахь улс төрийн санхүүжилт, зохион байгуулалттай гэмт хэргийн асуудал' сэдэвт арга хэмжээнд суурилав, <<http://www.brookings.edu/events/2013/10/15-latin-america-political-finance-organized-crime>>
- ⁴² АСДҮОУХ, *Ардчилал, зөрчил мөргөлдөөн ба хүний аюулгүй байдал: 21-р зууны энх тайвны эрэл* (Стокгольм: АСДҮОУХ, 2006)
- ⁴³ Браттон, Майкл 'Африкийн орнууд дахь олон намын ардчилал, хөгжил хандлага 2000–2012', Афробарометр судалгааны илтгэл No. 105, 2012 оны 10 сар; ба Доорэнсплит Рээнск, 'Шүүмжлэгч иргэд, ардчиллын дэмжлэг ба Африк дахь ардчиллын сэтгэл ханамж', Олон улсын улс төрийн шинжлэх ухааны судалгааны сэтгүүл, 33/3 (2012 оны 6 сар), хх. 279–300
- ⁴⁴ АСДҮОУХ, *АСДҮОУХ –ийн стратеги 2012–2017* (Стокгольм: АСДҮОУХ, 2012), <<http://www.idea.int/about/secretary-general/upload/idea-strategy-2012-2017.pdf>>, х. 1
- ⁴⁵ Кауза, Жон Мэри, 'Африкийн улс төр ба төвлөрлийг сааруулах үйл явц: Уганда, Рванда, Өмнөд Африкийн жишээ', хэлэлцүүлгийн тайлан, 2007, х. 4, <http://www.researchgate.net/publication/228469932_Political_Decentralization_in_Africa_Experiences_of_Uganda_Rwanda_and_South_Africa>
- ⁴⁶ Пруит, Бэтье, Филип Томас, *Ардчилсан хэлэлцүүлэг—хэрэглэгчийн гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2007), хх. 214–24
- ⁴⁷ Энд жендер хэмээх ойлголтыг эмэгтэй, эрэгтэй, гуравдагч хүйс гэдэг утгаар хэрэглэсэн бол бэлгийн чиг хандлага хэмээх ойлголт нь ижил хүйстэн, лесби, эсрэг хүйстэн гэх мэт ойлголтуудыг илэрхийлнэ.
- ⁴⁸ АСДҮОУХ, *Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008), хх. 53–8
- ⁴⁹ <http://www.oxforddictionaries.com/definition/english/crowdsourcing>
- ⁵⁰ АСДҮОУХ-гээс зохион байгуулсан бага хурлын тайлан 'Иргэдэд түшиглэсэн ардчиллын үнэлгээ: Дэлхийн туршлагын арван жил' Бангкок, 2013 оны 9 сарын 16-18 (хэвлэгдээгүй)
- ⁵¹ АСДҮОУХ, *Арабын ертөнц дахь орон нутгийн ардчиллын төлөв байдал: Бүсийн тайлан* (Стокгольм: АСДҮОУХ, 2010)
- ⁵² АСДҮОУХ, *Орон нутгийн ардчиллын төлөөх манлайлал: Орон нутгийн ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийх гарын авлага*, <http://www.idea.int/democracy/upload/Local_Dem_Assessment_Guide.pdf>

- ⁵³ *Кап Хайтен мужид хийсэн орон нутгийн ардчиллын үнэлгээ*, (Стокгольм: АСДҮОУХ, 2010), <http://www.idea.int/publications/local_democracy_in_cap_haitien/upload/Local_democracy_in_Cap-Haitien.pdf>
- ⁵⁴ Шульц Жим, *Ардчиллыг эзэмшигчдийн гарын авлага: Дэлхийг өөрчлөх практик хөтөч*, (Нью-Брансвик, Нью Жэрси: Их сургуулийн хэвлэх үйлдвэр, 2002), <<http://democracyctr.org/wp/wp-content/uploads/2011/10/Strategy-chapter-DOM.pdf>>
- ⁵⁵ Улс төр дэх эмэгтэйчүүдэд зориулсан ухуулга, сурталчилгааны гарын авлага: Ухуулга сурталчилгааг төлөвлөхүй, UN Women, IPS Africa, <<http://www.ipsnews.net/publications/Planning%20for%20Advocacy.pdf>>
- ⁵⁶ Улс төр дэх эмэгтэйчүүдэд зориулсан ухуулга, сурталчилгааны гарын авлага: Ухуулга сурталчилгааг төлөвлөхүй, UN Women, IPS Africa, <http://www.ipsnews.net/publications/Planning%20for%20Advocacy.pdf> >
- ⁵⁷ Шууд ардчиллын механизм гэдэгт ард нийтийн санал асуулга, буцаан татах, иргэдийн санаачилга зэрэг багтана. Дэлгэрэнгүй мэдээллийг: АСДҮОУХ, *Шууд ардчилал: АСДҮОУХ-ийн гарын авлага* (Стокгольм: АСДҮОУХ, 2008)

Талархал

Энэхүү товхимлыг боловсруулахад олон байгууллага, хувь хүн хувь нэмрээ оруулсан билээ. Өнгөрөгч арван жилийн хугацаанд дэлхийн олон оронд орон нутгийн ардчиллын төлөв байдлыг үнэлэх үнэлгээний ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн багийн гишүүд, холбогдох байгууллагуудад талархаж буйгаа илэрхийлье. Тэдний хуримтлуулсан туршлага, мэргэжлийн дүгнэлт, санал зөвлөмжүүд нь энэхүү үнэлгээний гарын авлагын агуулга, хүрээг дахин шинэчлэн, сайжруулах бидний ажилд дэмжлэг өгөөд зогсохгүй, ерөнхий чиг хандлагыг тодорхойлж бидний ажлыг удирдан залж чадсан юм.

Судалгааны энэ чиглэлээр урьд өмнө хэвлэгдэн гарсан олон арван гарын авлага бидний ажилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан бөгөөд тэдгээрийн заримаас дурдвал *Орон нутаг дахь ардчилал; Ардчиллын үнэлгээний гарын авлага; Дэлхийн найман улсад хийсэн үнэлгээ, Ардчиллын чанарыг үнэлэхүй: Практик гарын авлага* зэрэг болно.

2003 онд анх хэвлэгдсэн *Орон нутгийн ардчиллын төлөв байдлын үнэлгээ* – г дахин шинэчлэхэд 2009 оноос Иорданы Амман хот, Египт, Морокко, Йемен зэрэг улсуудад зохион байгуулсан семинарын үр дүн, оролцооны аргыг дэлгэрүүлэх үйл явц зэрэг нь чухал хувь нэмэр оруулсан болно. 2011 онд мөн ижил төрлийн семинарыг, Замби улсын Лусака хотод зохион байгуулсан юм. Эдгээр арга хэмжээ нь дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн үнэлгээний багуудын гишүүд нэг дор цугларан, орон нутгийн ардчиллын төлөв байдлыг үнэлэх үнэлгээний хүрээний давуу болон сул талуудыг хэлэлцэх, санал бодлоо солилцох, сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлсны үр дүнд үнэлгээний энэ хувилбарыг боловсруулсан билээ.

Энэхүү гарын авлагын агуулгыг хянаж, сайжруулан, үнэтэй санал зөвлөмж өгсөн дараах хүмүүс, мэргэжилтнүүдэд гүнээ талархаж байна:

- Эдна Ко, Филиппины Төрийн удирдлага, засаглалын коллежийн профессор
- Рамон Фернан III, Филиппины Ардчиллын үнэлгээний баг
- Абдул Каффар Карим, Ёогкарта, Индонез

- Кэлли МакМанн, Улс төрийн шинжлэх ухааны дэд профессор, Олон улсын харилцааны сургуулийн хугацаат захирал, Кэйс Вэстэрн Их сургууль, Кливланд
- Тимоти Д.Сиск, Профессор, Деканы орлогч, Жосэф Корбэлийн Олон улсын харилцааны сургууль, Дэнвэрийн Их Сургууль
- Горан Фэжик, АСДҮОУХ-ийн Стратеги, бодлогын судалгааны нэгжийн ахлах зөвлөх асан

Мөн түүнчлэн энэхүү гарын авлагыг хянасан Найла Прието, Кготатсо Семела-Серотэ, Румбидзай Кандавасвика-Нунду болон АСДҮОУХ-ийн бусад холбогдох ажилтнууд, хамтран зүтгэгч нарт талархсанаа илэрхийлье.

Төгсгөлд нь АСДҮОУХ-ийн хэвлэл хариуцсан ажилтан Лиза Хагман, энэхүү товхимлыг боловсруулах, хэвлэх шатанд захиргааны зүгээс дэмжлэг үзүүлсэн Давид Росэн нарт талархаж буйгаа илэрхийлье.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэнгийн тухай товчхон

АСДҮОУХ гэж юу вэ?

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн нь (АСДҮОУХ) дэлхий даяар тогтвортой ардчилалд дэмжлэг үзүүлэх зорилготой засгийн газар хоорондын байгууллага юм.

Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн зорилго бол илүү хүчтэй ардчилсан институт, үйл явц, илүү тогтвортой, хууль ёсны, үр дүнтэй ардчиллыг дэмжихэд оршино.

АСДҮОУХ бол ардчиллын хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг цорын ганц засгийн газар хоорондын байгууллага юм. Тус байгууллага алсын хараагаа ардчиллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа, хуримтлуулсан туршлага, мэдлэг мэдээллээ хуваалцах замаар дэлхий дахинд танигдсан, ардчиллыг дэмжигч гол байгууллага болох хэмээн тодорхойлжээ.

АСДҮОУХ – ийн зүгээс ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

АСДҮОУХ нь сонгуулийн үйл явц, үндсэн хууль боловсруулах үе шат, улс төрийн оролцоо, төлөөлөл, ардчилал ба хөгжил, хөгжил ба жендер, нийгмийн ялгаатай бүлэг, зөрчил мөргөлдөөн, аюулгүй байдал зэрэг салбарт мэргэжлийн судалгаа, үнэлгээ хийх харьцуулсан мэдлэг мэдээлэл, ойлголт бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

АСДҮОУХ нь дээрх чиглэлээр хийсэн судалгаа, цуглуулсан мэдлэг, мэдээллийг үндэсний болон орон нутгийн түвшинд өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлэх хүсэлтэй иргэд, олон нийттэй хуваалцах, харилцан ярилцах замаар ардчилсан өөрчлөлтийг дэмжихийн төлөө ажилладаг.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд тус хүрээлэн дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг:

- Ардчиллын чадавх, хууль ёсны байдал ба итгэл үнэмшил дээшилсэн байх
- Иргэд, олон нийтийг хамарсан оролцоо, эгэх хариуцлагатай төлөөллийг нэмэгдүүлэх
- Илүү хууль ёсны, үр нөлөөтэй ардчилсан хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

АСДҮОУХ үйл ажиллагаагаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

Ардчилал гэдэг бол нийгмийн хөгжлийн явцад тухайн улс үндэстний дотроос бий болж, өргөжин хөгжиж байдаг үйл явц мөн. Тиймээс бүх улс оронд тохирох ардчиллын нэг загвар гэж үгүй. Ардчилсан нийгмийн хөгжил, төлөв байдлыг тухайн орны иргэд, олон нийт хамгийн бодитой үнэлж, хэмжиж чадна. АСДҮОУХ-ийн үйл ажиллагаа нь дэлхий нийтийн, бүс нутгийн, тусгаар улс үндэстний болон орон нутгийн түвшинд хэрэгжих бөгөөд гагцхүү өөрчлөлтийг авчрах орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлаж, төвлөрч үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

АСДҮОУХ-ийн зүгээс улс орнуудтай хамтран ажиллахдаа аль нэг талыг баримталдаггүй, шууд зааварлаж зөвлөхөөс илүүтэй харилцан ярилцах, хамтран ажиллах зарчмыг баримталдаг бөгөөд улс төрийн тэгш оролцоо, ардчиллын онцлог шинж байдал, улс төрийн болон шийдвэр гаргах үйл явц дахь эмэгтэй эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоо, төлөөллийг бий болгох, өөрчлөлт, шинэчлэлийг эхлүүлэх улс төрийн хүсэл зоригийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг зорьдог.

Тус хүрээлэн үзэл бодол, байр суурийн хувьд ялгаатай улс төрийн институт, хувь хүмүүсийн өргөн төлөөллийг нэг дор цуглуулж, семинар, бага хурал, чадавх бэхжүүлэх сургалт зэргийг зохион байгуулах замаар, дэлхийн хэмжээнд, бүс нутаг, улс, орон нутгийн түвшинд мэдлэг, мэдээлэл, туршлага солилцоход дэмжлэг үзүүлдэг.

АСДҮОУХ нь хаана үйл ажиллагаагаа явуулдаг вэ?

Дэлхийн бүх бүс нутагт АСДҮОУХ үйл ажиллагаагаа явуулдаг. Стокгольм хотод тус хүрээлэнгийн төв салбар байрлах бөгөөд Африк, баруун Ази, Ази, Номхон далай, Латин Америк болон Карибын тэнгисийн бүс нутагт салбартай юм.

АСДҮОУХ нь НҮБ-ын байнгын ажиглагч байгууллага болно.

Гишүүн орнууд

АСДҮОУХ-ийн гишүүн орнууд нь бүгд ардчилсан улс бөгөөд хүрээлэнгийн үйл ажиллагааг улс төрийн болон санхүүгийн хувьд тогтмол дэмжиж ажилладаг. Тус хүрээлэнгийн гишүүн улсуудад Австрали, Барбадос, Бельги, Бенин, Ботсван, Канад, Кэйп Вэрд, Чили, Коста Рика, Доминикийн Бүгд Найрамдах Улс, Финланд, Герман, Гана, Энэтхэг, Мавритан, Мексик, Монгол, Намиби, Голланд, Норвеги, Перу, Филиппин, Португал, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцарь, Уругвай улс багтдаг. Япон улс ажиглагчийн статустай.

Удирдлага

АСДҮОУХ –ийн үйл ажиллагааг гишүүн орнуудын төлөөллөөс бүрдсэн Зөвлөл удирдан зохион байгуулдаг бөгөөд Зөвлөхийн баг (Зөвлөл) дэмжлэг үзүүлж ажилладаг.